

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДАД
ЗОРИУЛСАН БОДЛОГЫН ГАРЫН АВЛАГА

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЛУУЧУУДЫГ
ҮР ДҮНТЭЙ ТАТАН ОРОЛЦУУЛАХ НЬ

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба,
БНХАУ-ын Хонконг дахь Авлигын эсрэг бие даасан хороо,
Авлигатай тэмцэх байгууллагуудын Олон Улсын Холбоо

2023



ТӨСЛИЙН ХАМТРАГЧИД

Авлигын эсрэг бие даасан хороо (АЭБДХ) нь БНХАУ-ын Хонг Конг дахь хууль сахиулах байгууллага бөгөөд хууль сахиулах, зохион байгуулалттай урьдчилан сэргийлэх, олон нийтэд боловсрол олгох замаар төрийн болон хувийн хэвшил дэх авлигатай тэмцэх зорилготой. АЭБДХ нь авлигатай тэмцэхэд олон улсын хамтын ажиллагааны ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж буй байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (МБГХТА) нь дэлхий нийтийг хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, терроризмоос хамгаалахад улс орон, бүс нутгуудад тусалж ирсэн. Энэ нь улс орон, бүс нутгийн хувьд дангаараа шийдвэрлэхэд хэт өргөн цар хүрээний асуудал тул МБГХТА нь бодит тусламж үзүүлж, үйл ажиллагаанд үндэстэн дамнасан арга барилыг хөхиүлэн дэмждэг. Тус байгууллага нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэхэд гишүүн орнуудад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээдэг.

Авлигатай тэмцэх байгууллагуудын Олон Улсын Холбоо нь 2006 онд байгуулагдсан бөгөөд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, дэлхий хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд авлигатай тэмцэх байгууллагуудад туслах чиг үүрэгтэй авлигатай тэмцэх бие даасан, улс төрөөс ангид байгууллага юм.

2023 оны арванхоёрдугаар сар

ТАЛАРХАЛ

Энэхүү гарын авлагыг боловсруулахад үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсан нийт мэргэжилтнүүд, залуучууд, судалгаа, гарын авлагын багийн гишүүд, төслийн түншүүдийн төлөөлөл, авлигатай тэмцэх байгууллагуудад төслийн түншүүдийн зүгээс талархал илэрхийлж байна.

Энэхүү бодлогын гарын авлагыг боловсруулсан Hady Fink, Chris Morris, Iris May Ellen Caluag and Brook Horowitz нарт гүнээ талархаж байна. Мөн судалгаа, төсөлд оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Dionela Bigcas, Lady Diandra, Christian Manahan, Celine Santos, Dimitris Ziouvas нарт болон IBLF Global байгууллагад талархал илэрхийлье.

Ажлын хэсэг

БНХАУ-ын Хонконг дахь Авлигын эсрэг бие даасан хороо болон Авлигатай тэмцэх байгууллагуудын Олон Улсын Холбоо:

Jenny Chau
Lawrence Chiu
Eric Ng
Amy Wong
Hazel Wong
Mani Wong

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба:

Roberta Falvo
Bianca Kopp
Leonardo Paradiso

Шинжээчдийн баг

Mead Alsoghayyer
Aruna Badoo
Jan Dauman
M Abdoulaye Diagne
Simon Ho
Serena Ibrahim
Anne Kiprotich
Vivienne Lam
Raymond Lau
Rafeal Leite

Firdaous Mansour
George Pantazis
Kavisha Pillay
Afia Poku
Enock Qoma
Norashiken Salleh
Mohd Nur Lokman bin
Samingan
Aimй Ludovic Sawadogo
Brigitte Slepicka

Andrew Spalding
Konstantinos Spanos
Camila Tort
Jofiliti Veikoso
Helena Whalen-Bridge
Dexter Arvin Yang
Tina Yip
Heela Yoon

Залуучуудын Зөвлөх Хороо

Prekkshya Bimali
Vivienne Lam
Raymond Lau
Rafael Leite
George Pantazis

Afia Poku
Aimй Ludovic Sawadogo
Camila Tort
Dexter Arvin Yang
Tina Yip

Асуулгад оролцсон Авлигатай тэмцэх байгууллагууд

Байгууллага	Улс/нутаг дэвсгэр
Авлигатай тэмцэх хороо	Армен
Авлигаас урьдчилан сэргийлэх комисс	Армен
Ерөнхий прокурорын дэргэдэх Авлигатай тэмцэх газар	Азербайжан
Хууль зүйн яам	Азербайжан
Авлигатай тэмцэх комисс	Бангладеш
Авлигын эсрэг үндэсний байгууллагуудын фронт	Бенин
Авлигатай тэмцэх комисс	Бутан
Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх ажлыг зохицуулах газар	Босни ба Херцоговин Улс
Авлигатай тэмцэх товчоо	Бруней Даруссалам
Авлига, хууль бус хөрөнгө хураах комисс	Болгар улс
Авлигатай тэмцэх тусгай бригад	Бурунди
Авлигатай тэмцэх үндэсний хороо	Камерун
Авлигатай тэмцэх байгууллага	Чад
Ерөнхий хяналтын алба	Чили
Авлигын эсрэг бие даасан хороо	Хонконг, Хятад
Авлигын эсрэг хороо	Макао, Хятад
Улсын прокурорын газрын даргын ажлын алба	Дани
Улсын ерөнхий хяналтын газар	Жибути
Ерөнхий прокурорын газар	Эквадор
Улсын прокурорын газар	Эстони
Үндэсний мөрдөн байцаах товчоо	Финланд
Тусгай прокурорын газар	Гана
Үндэсний ил тод байдлын газар	Грек
Санхүүгийн мэдээллийн алба	Гренада
Үндэсний хамгаалалтын алба	Унгар
Шударга байдал, авлигатай тэмцэх хороо	Жордан
Төрийн үйлчилгээний алба	Кирибати
Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх товчоо	Латви
Тусгай мөрдөн байцаах алба	Литва
Ерөнхий прокурорын газар	Литва
Малайзын Авлигатай тэмцэх хороо	Малайз
Авлигатай тэмцэх хороо	Мальдив
Мальтагийн цагдаагийн алба	Мальта
Авлигын эсрэг бие даасан комисс	Маврики
Авлигатай тэмцэх үндэсний тогтолцооны иргэдийн оролцооны хороо	Мексик
Авлигатай тэмцэх үндэсний тогтолцооны Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар	Мексик
Авлигатай тэмцэх үндэсний төв	Молдав
Авлигатай тэмцэх газар	Монгол
Шударга байдал, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үндэсний газар	Марокко
Авлигатай тэмцэх хороо	Мьянмар
Эдийн засаг, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хороо	Нигери
Дотоод хэргийн яамны Дотоод хяналт, эрүүгийн мөрдөн байцаах, мэргэжлийн стандартын газар	Хойд Македон

Байгууллага	Улс/нутаг дэвсгэр
Үндэсний хариуцлагын товчоо	Пакистан
Ил тод байдал, мэдээлэл олж авах үндэсний газар	Панам
Авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөл	Португал
Үндэсний шударга байдлын агентлаг	Румын
Авлигатай тэмцэх ерөнхий газар	Румын
Омбудсманы газар	Руанда
Ерөнхий прокурорын танхим	Сент Люси
Омбудсман, хүний эрхийн үндэсний байгууллага	Самоа
Залилан, авлигатай тэмцэх үндэсний алба	Сенегал
Авлигаас урьдчилан сэргийлэх агентлаг	Серби
Авлигатай тэмцэх зөвлөл	Серби
Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах товчоо	Сингапур
Авлигаас урьдчилан сэргийлэх газар	Словак
Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Тусгай прокурорын газар	Словак
Авлигаас урьдчилан сэргийлэх комисс	Словени
Улсын дээд прокурорын газар	Словени
Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай прокурорын газар	Испани
Валенсийн нийгэмлэгийн залилан, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх агентлаг	Испани
Каталоны Залилантай тэмцэх алба	Испани
Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх товчоо	Танзани
Авлигатай тэмцэх үндэсний хороо	Тайланд
Авлигатай тэмцэх хороо	Зүүн Тимор
Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний агентлаг	Украин
Ерөнхий прокурорын газар	Украин
Авлигатай тэмцэх үндэсний товчоо	Украин
Абу Даби Хариуцлагын газар	Арабын Нэгдсэн Эмират Улс
Засгийн газрын хяналтын газар	Вьетнам улс
Зимбабвегийн Авлигатай тэмцэх хороо	Зимбабве

Нэмэлт мэдээлэл өгсөн Авлигатай тэмцэх байгууллагууд

Байгууллага	Улс/нутаг дэвсгэр
Авлигатай тэмцэх хороо	Бутан
Авлигатай тэмцэх товчоо	Бруней Даруссалам
Авлигын эсрэг бие даасан хороо	Хонконг, Хятад
Үндэсний ил тод байдлын газар	Грек
Ёс зүй, авлигатай тэмцэх хороо	Кени
Төрийн үйлчилгээний алба	Кирибати
Малайзын Авлигатай тэмцэх хороо	Малайз
Авлигатай тэмцэх үндэсний тогтолцооны Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар	Мексик
Авлигатай тэмцэх үндэсний төв	Молдав

ОРШИЛ

Авлигатай тэмцэх нь амаргүй ажил бөгөөд мэдээж тусгаарлан тэмцэж болохгүй. Үүнд бүх салбарын оролцогч талууд нэгдэж, авлигын бүх хэлбэрийг ойлгох, урьдчилан сэргийлэх, тэмцэхэд үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан нийгмийг хамарсан арга барил шаардлагатай.

Энэхүү ээдрээтэй сорилтыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд дээрээс доош чиглэсэн институцийн уламжлалт арга барилаас давж гарах залуучуудыг байгаагаар нь авч үзсэн үр дүнтэй арга хэмжээг эрэлхийлэх ёстой бөгөөд энэ нь аливаа тогтвортой, үр ашигтай шийдлийн салшгүй хэсэг юм.

Үүнд хэрхэн хүрэх вэ? Чанартай боловсрол олгох, үр дүнтэй чадавхжуулах ажлыг зохион байгуулах нь.

Залуучуудын эерэг өөрчлөлтийн төлөөлөгч болох үүргийг сурталчлах, авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудыг авлигын эсрэг үйл ажиллагаанд нь үр дүнтэй татан оролцуулахад дэмжлэг үзүүлэх түншлэлийг бэхжүүлэх үүднээс, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг Конвенцын 20 жилийн ойг тэмдэглэж буй энэ үеэр БНХАУ-ын Хонгкон дахь Авлигын эсрэг бие даасан хороо (Авлигатай тэмцэх байгууллагуудын Олон улсын холбооны (АТБОУХ) Тэргүүлэгч бөгөөд Нарийн бичгийн дарга нарын албыг хариуцаж байгаа) болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (МБГХТА) нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа залуучуудыг авлигын эсрэг тэмцэлд жинхэнэ хүчирхэг хүч гэдгийг хүлээн зөвшөөрөхийн тулд тэдгээрийг чадавхжуулах ажлыг чиглүүлэх зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулахаар нэгдэв.

Манай нийгмийг төлөвшүүлэхэд залуу түншүүд маань улам бүр чухал үүрэг гүйцэтгэж байгаа шинэ эриний босгон дээр зогсож буй энэ цаг үед АЭБДХ, НҮБ-ын МБГХТА, АТБОУХ-оос **“Авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудыг үр дүнтэй татан оролцуулах нь Авлигатай тэмцэх үндэсний байгууллагад зориулсан бодлогын гарын авлагыг** Авлигатай тэмцэх байгууллагууд өргөнөөр ашиглана гэсэн өөдрөг үзлээр толилуулж байгаадаа таатай байна. Өнөөгийн залуучууд эрч хүчтэй хандлага, хүчтэй дуу хоолой, гуйвшгүй сэтгэл, шинэлэг сэтгэлгээ, хязгааргүй эрч хүчээрээ авлига, гэмт хэргийн эсрэг зогсох, одоо ба ирээдүйг бүтээх салшгүй хэсэг юм.

Энэхүү нийтлэл нь авлигатай тэмцэх хөдөлгөөнд залуучуудыг идэвхтэй оролцуулах итгэл найдвар болж байна. Үүнд төрийн үйлчилгээний ил тод байдлыг сайжруулах, үе тэнгийнхнийхээ дунд шударга байдлыг хөхиүлэн дэмжих, ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх шинэлэг санааг хөгжүүлэх, улмаар ил тод байдал, хариуцлага, ёс зүй, шударга байдал, юуны түрүүнд шударга ёсыг сурталчлах зорилгоор авлигатай тэмцэх байгууллагуудтай хамтран ажиллаж буй залуучуудыг сэдэлжүүлэх түүхийг багтаасан болно.

Авлигатай тэмцэх байгууллагууд энэхүү гарын авлагатай танилцсаны дараа залуучуудын төлөө, тэдгээрийн үйл ажиллагааны үр шимийг хүртэгч бус, харин идэвхтэй хамтрагчийн хувьд авлигын эсрэг тэмцлийг үргэлжлүүлэх урам зоригтой болно гэдэгт итгэж байна. Авлигатай тэмцэх бодлого боловсруулахдаа хүн амын зонхилох хэсэг болох залуучуудын хэрэгцээ, асуудлыг хамруулах байдлаар үндэсний, бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд авлигатай тэмцэх үйлсэд хувь нэмрээ оруулах залуучуудад зориулсан таатай орчныг бүрдүүлэх ажил эрс нэмэгдэнэ гэж найдаж байна.

Залуучуудыг хамтран манлайлах түншийн хувьд үр дүнтэй оролцуулах үед авлига зэрэг асуудлаарх шинэлэг санаанууд нь бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгчдийн анзааралгүй өнгөрсөн байж





магадгүй шинэлэг шийдлүүдийг гаргаж чадна. Олон талт байдлыг хүлээн зөвшөөрч, залуучуудын оролцооны хүчийг ашигласнаар бид иргэдийнхээ хэрэгцээ шаардлагыг ойлгодог, нийтийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулах байр суурьтай болгосон илүү шударга нийгэмд хүрэх замыг нээж өгөх нь гарцаагүй.

Авлига нь дангаараа гэмт хэрэг бөгөөд мөн бусад гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл болохын хувьд цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж байдаг аж: Энэ нь чиг хандлагыг дагаж, байнга өөрчлөгдөж, хэт холбоотой нийгэмдээ дасан зохицож байдаг. Энэ үүднээс авч үзвэл дэлхийн залуучуудын ур чадвар, чадвар нь үе тэнгийнхэн, гэр бүл, хамт олондоо нөлөөлөх хүчтэй учраас авлигатай тэмцэхэд хэчнээн чухал болох нь улам тодорхой болж байна.

Хэрэв бид авлигагүй нийгмийг бий болгохын төлөө цаг хугацаа, хүчин чармайлтаа зориулж чадна гэдэгт итгэж байгаа бол хамтран ажиллаж, бие биеэсээ суралцаж, бие биедээ өөрсдийнхөө шилдэг хувилбар болоход нь тусалж, эцэст нь авлигатай тэмцэх цогц, үр дүнтэй, тогтвортой хамтын хүчин чармайлтын үндэс нь үе дамжсан харилцан суралцах явдал юм гэдгийг ойлгох цаг болжээ.

Дүгнэж хэлэхэд, хэрэв бид энэхүү гарын авлагаараа дамжуулан урагшлуулах, сурталчлахыг зорьж буй том санаагаа хэрэгжүүлэх бол өнөөдөр дэлхийн нийгэмд зан үйлийн өөрчлөлтийг идэвхжүүлэхэд нухацтай хандаж байгаа бол залуучуудыг чадавхжуулах нь сонголт биш, харин зайлшгүй шаардлагатай чухал арга байх болно.

Энэхүү гарын авлага нь дэлхий даяар авлигыг үл тэвчих соёлыг бий болгох арга замыг бидэнд харуулсан эерэг өөрчлөлтийн хурдасгуур болж чадна гэж найдаж байна. Энэ зам нь сорилттой байх нь дамжиггүй, гэхдээ тууштай, хамтын ажиллагаа, уйгагүй хичээл зүтгэлээр бидний аялал одоо болон ирээдүй хойч үеийнхний бахархах өвийг бүтээхэд хөтлөх болно.

БНХАУ-ын Хонг Конг дахь Авлигын эсрэг
бие даасан хорооны дарга,
Авлигатай тэмцэх байгууллагуудын Олон
Улсын Холбооны ерөнхийлөгч

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй
тэмцэх алба, Авлига болон эдийн засгийн
гэмт хэргийн салбарын захирал

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРИАЛГА

Энэхүү гарын авлагыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан Залуучуудын Зөвлөх Хорооны гишүүд бид үеийнхнийхээ төдийгүй ирээдүй хойч үеийн хүртээмжтэй, эрх тэгш хөгжлийг бий болгохыг эрмэлзэж байна.

Хүмүүс болон эх дэлхийгээ аврах, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахын тулд заавал ялах ёстой авлигын эсрэг тэмцэлд бид нэгдэхээ илэрхийлж байна.

Энэхүү гарын авлагыг боловсруулсан БНХАУ-ын Хонконг дахь Авлигын эсрэг бие даасан хороо, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Авлигатай тэмцэх байгууллагуудын Олон улсын Холбоонд талархал илэрхийлж, залуучуудыг нэгэнт татан оролцуулж буй авлигатай тэмцэх байгууллагуудад хувь нэмрээ оруулах, тэднийг хүлээн зөвшөөрөх боломжийг бид талархан хүлээн авч байна.

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудтай хамтран ажиллах боломжийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд залуучуудын энэхүү анхны оролцоог үргэлжлүүлэн, өргөжүүлж, залуучуудын оролцооны үр дүнтэй зарчмуудыг баримтлах ёстой.

Бид авлигатай тэмцэх байгууллага болон олон улсын авлигатай тэмцэх байгууллагуудад хандан дараахь уриалгыг гаргаж байна:

Хөгжүүлэх, дэмжих

- Авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудыг үр дүнтэй оролцуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олон нийтийн кампанит ажил, авлигын эсрэг соён гэгээрүүлэх семинар зохион байгуулах, авлигатай тэмцэх байгууллагуудын ажилтнууд, залуучууд болон бусад гол оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх

Байгуулах

- Энэхүү гарын авлагыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор авлигатай тэмцэх байгууллага, олон улсын авлигатай тэмцэх байгууллагуудтай хамтран Залуучуудын зөвлөх хороодыг байгуулах
- Ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийг хамруулах баталгааг хангах орон нутгийн хүртээмжтэй хөтөлбөрүүдийг боловсруулахын тулд авлигатай тэмцэх байгууллагад залуучуудыг үр дүнтэй татан оролцуулах орон нутгийн болон олон улсын олон хэлтэй вэбэд суурилсан платформуудыг бий болгох

Таних

- Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий бүх байгууллагуудад залуу аваргууд, залуу элч, төлөөлөгчийг авлигын эсрэг ажилд дайчлан таниулах
- Авлигын эсрэг залуучуудын хүчин чармайлт (шагнал, урамшуулал, олон нийтэд түгээсэн нийтлэл гэх мэт)

Хэлэлцэх

- Залуучууд болон авлигатай тэмцэх байгууллагууд дугуй ширээний уулзалт, фокус групп, зөвлөлдөх уулзалт болон бусад форумар дамжуулан авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хамтран ажиллах туршлага, санал бодлоо хуваалцах боломжтой.

Хэрэгжүүлэх

- Энэхүү гарын авлагын хэрэгжилтэд залуучууд хяналт тавьж, зөвлөмжийг түгээх замаар бүх оролцогч талуудын ил тод байдлыг хангах
- Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг үр дүнтэй татан оролцуулахад бэлэн байгаа эсэх, авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг үр дүнтэй татан оролцуулах ажлыг бодитоор хэрэгжүүлэх, авлигатай тэмцэх байгууллагуудын залуучуудын үр дүнтэй оролцоог хянах, үнэлэх багц арга хэрэгслийг боловсруулж, турших, хэрэгжүүлэх
- Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудтай хамтрах ажлын хүрээнд залуучуудыг үр дүнтэй татан оролцуулахад бэлэн байгаа эсэхэд хяналт тавьж, жил бүр тайлагнах

“Авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудыг үр дүнтэй татан оролцуулах нь” авлигатай тэмцэх үндэсний байгууллагуудад зориулсан бодлогын гарын авлагын Залуучуудын Зөвлөх Хорооноос

ГАРЧИГ

Хураангуй

Нэгдүгээр бүлэг: Үзэл баримтлалын хүрээ

- 1А. Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын үр дүнтэй оролцоог хангахад баримтлах бодлогын удирдамж 2
- 1Б. Нэр томьёо, ойлголтын тодорхойлолт 5
- 1В. Бодлогын гарын авлагын судалгаа 7
- 14 9

Хоёрдугаар бүлэг: Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг татан оролцуулах үндэслэл

- 2А. Залуучуудын оролцооны давуу тал 19
- 2Б. Залуучуудын үр дүнтэй оролцоонд тулгарч буй бэрхшээл ба боломж 21
- 28

Гуравдугаар бүлэг: Авлигатай тэмцэх байгууллагууд үйл ажиллагаандаа залуучуудыг хэрхэн үр дүнтэй татан оролцуулах вэ?

- 3А. Зохион байгуулалтын түвшин: 37
- Байгууллагын бэлэн байдлыг хангах нь 39
- 3Б. Зохион байгуулалтын түвшин: Залуусын үр дүнтэй оролцоог авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд нэгтгэн уялдуулах нь 45
- 3В. Хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, амжилтаа үнэлэх, туршлагаас суралцах 72

Дөрөвдүгээр бүлэг: Урагшлах зам

75

Хавсралт I: Судалгааны арга зүй ба мэдээлэл цуглуулах 80

Хавсралт II: Залуучуудын идэвхтэй оролцоо – Байгууллагын идэвхжүүлэгчид 84

ХУРААНГУЙ

Агуулгын хураангуй

Энэхүү гарын авлага нь залуучуудыг авлигын эсрэг үйл ажиллагаанд үр дүнтэй татан оролцуулахад авлигатай тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагуудад туслах зорилготой. Эдгээр байгууллагууд залуучуудыг татан оролцуулах хүсэл эрмэлзэлтэй боловч уг ажлыг хэрхэн зохион байгуулах арга, хэлбэрээ төдийлөн олоогүй байдаг тул энэхүү гарын авлага нь зохих зааварчилгаа болох юм. Гарын авлагыг ном, гарын авлага, материалыг судлан, чанарын болон тоон анхдагч өгөгдөлд үндэслэн боловсруулсан болно.

Залуучуудтай үр дүнтэй хамтран ажиллах болон авлигатай тэмцэх байгууллагуудын ажлын уялдаа холбоог гурван ойлголтоор тодорхойлогдог.

- 1. Залуучуудын оролцоо:** Оролцооны үүрэг, төрлөөс хамааран залуучуудын хувь нэмрийг “дуу хоолой” (өөрөөр хэлбэл, харилцан яриа хэлэлцээнд бүтээлчээр оролцох, тэдэнд нөлөөлж буй асуудлыг хөндөх), “үзэл бодол” (өөрөөр хэлбэл, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын шийдвэр, түүний дотор тэдний бодлого, хөтөлбөрийг мэдээлэх зорилгоор залуучуудаас мэдлэг цуглуулах, дамжуулах) болон “үйлдэл” (өөрөөр хэлбэл, авлигатай тэмцэх үйл ажиллагаа зэрэг өөрсдөд нь болон тэдний бүлгэмд нөлөөлж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн санаачилгыг манлайлах, оролцох) гэж хувааж болно.
- 2. Залуучуудын үр дүнтэй оролцоо:** Залуучуудын оролцоог үр дүнтэй болгоход олон талт байдал ба тэгш оролцоо, оролцоог хангах таатай орчин, үе хоорондын хамтын ажиллагаа, залуучуудын чанартай оролцоо, залуучуудыг чадавхжуулах гэсэн таван сэдвээр тодорхойлогддог тодорхой нөхцөлд үйл ажиллагааг явуулах ёстой.
- 3. Авлигатай тэмцэх байгууллагуудын чиг үүрэг:** Эдгээр байгууллагуудын авлигатай тэмцэх ажлыг урьдчилан сэргийлэх, хууль сахиулах, олон нийтэд таниулах/ухамсрыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, зохицуулалт/бодлого боловсруулах гэсэн таван чиг үүрэгт хувааж болно.

Авлигатай тэмцэхэд залуучуудын үр дүнтэй оролцоо нь залуучууд авлигын эсрэг санаачилгын янз бүрийн үе шатанд оролцогч талуудтай хамтран идэвхтэй оролцох явдал бөгөөд улмаар энэ нь тэдгээрийг чадавхжуулах, авлигын эсрэг үйл ажиллагааг үр дүнд хүргэхэд хувь нэмрээ оруулах таатай орчинд бий болдог.

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг дараахь байдлаар татан оролцуулснаар зохих үр дүнд хүрэх боломжтой.

1. Залуучууд авлигатай тэмцэх байгууллагуудыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд авлигаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх, тэмцэх, оролцогч талуудтай зохих ёсоор харилцах, нөөцийг үр ашигтай удирдах зэрэг гурван гол сорилтыг даван туулахад дэмжлэг үзүүлж болно.
2. Залуучуудыг татан оролцуулах нь авлигатай тэмцэх байгууллагуудын одоогийн үйл ажиллагаанаас гадуур шинэ мэдлэг, санал, санаачилгыг хэрэгжүүлэх зэрэг томоохон боломжийг авлигатай тэмцэх байгууллагуудад олгодог.

Залуучуудын оролцоог дэмжихэд авлигатай тэмцэх байгууллагуудад нийтлэг тулгардаг бэрхшээл нь залуучуудын чадавх, байгууллагуудын бэлэн байдалтай холбоотой. Залуучуудын оролцоог хангах ажлыг эхлүүлэх, сайжруулах хүсэл эрмэлзэлтэй авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд гурван үе шаттайгаар ажиллавал зохино.

1. **Залуучуудын үр дүнтэй оролцуулах байгууллагын бэлэн байдлыг хангах:** Залуучуудын үр дүнтэй оролцоог хангах байгууллагын чадавх нь тухайн байгууллага дахь залуучуудын үр дүнтэй оролцооны таван сэдэвт үндсэн санаа бүхий ажлын бэлтгэлээс хамаарна. Авлигатай тэмцэх байгууллагын бэлэн байдлын түвшинг “байгууллагын идэвхжүүлэгч 13 хүчин зүйл”-ээр хэмждэг. Үнэлгээнд үндэслэн байгууллагууд залуучуудтай үр дүнтэй аргаар амжилттай харилцах боломжоо нэмэгдүүлж чадна.
2. **Үйл ажиллагаандаа залуучуудыг татан оролцуулах ажлыг зохион байгуулах:** Залуучуудыг үр дүнтэй оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулахын тулд авлигатай тэмцэх байгууллагууд Өөрчлөлтийн онолыг дөрвөн үе шаттайгаар хэрэгжүүлэх боломжтой: 1) авлигатай тэмцэх хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох; 2) зорилгодоо хүрэхэд залуучууд ямар хувь нэмэр оруулж болохыг ойлгох; 3) нарийвчилсан үйл ажиллагаа, залуучуудыг хэрхэн оролцуулах талаар дэлгэрэнгүй тайлбарлах; 4) хөтөлбөр нь залуучуудын оролцооны үр дүнтэй шалгуурыг хангаж байгаа эсэхийг шалгах.
3. **Тасралтгүй суралцах, залуучуудын оролцоог сайжруулах хүчин чармайлтыг хянаж, үнэлэх.** Энэхүү гарын авлагын эхний хоёр бүлэгт алхам алхмаар зааварчилгаар хангаж, гуравдугаар бүлэгт ерөнхий зөвлөмж өгнө. Үүний зорилго нь дэлхийн олон оронд ажиллаж байгаа авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулах, оролцоог үр дүнтэй болгох замаар одоогийн үйл ажиллагаагаа сайжруулахад дэмжлэг үзүүлэх явдал юм. Цаашид авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудын үр дүнтэй оролцооны талаарх олон улсын, үе хоорондын хамтын нийгэмлэгийг хөгжүүлэх, бий болгоход дэмжлэг үзүүлэх техникийн болон санхүүгийн нэмэлт эх үүсвэр шаардлагатай.



ГАРЫН АВЛАГЫН БҮТЭЦ

Энэхүү гарын авлага дараахь гурван үндсэн бүлэгт дурдсан агуулгыг багтаасан.

- ➔ **Нэгдүгээр бүлэг: Үзэл баримтлалын хүрээ.** Энэ нь гарын авлагын үндэс болсон судалгаа, өгөгдөл, үзэл баримтлалын талаарх мэдээллийг агуулдаг. Энэ нь оюуны гол таамаглалуудыг тайлбарлаж, үндсэн санааг ойлгоход чухал ач холбогдолтой гол нэр томъёог тодорхойлж, авлигатай тэмцэх эрх бүхий байгууллагууд болон залуучуудын үр дүнтэй оролцооны талаарх судалгааны үндсэн ойлголтуудыг багтаасан.
- ➔ **Хоёрдугаар бүлэг: Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг татан оролцуулах үндэслэл.** Энэ хүрээнд авлигатай тэмцэх байгууллагууд ямар учраас залуучуудыг татан оролцуулах шаардлагатай болохыг судалсан болно. Аливаа шинэ санаачилгын нэгэн адил саад бэрхшээл, боломжууд байдаг. Гэвч залуучуудын үр дүнтэй оролцоог дэмжих үүднээс залуучууд өөрсдийн үзэл бодол, шинэлэг санаа, дуу хоолой, харилцааны ур чадвар, залуучууд болон нийгмийн хөгжилтэй холбоотой асуудлыг сонирхох зэргээр авлигын эсрэг үйл ажиллагааны чанарыг сайжруулахад авлигатай тэмцэх байгууллагуудад тусалж чадна гэдгийг манай судалгаа харуулж байна.
- ➔ **Гуравдугаар бүлэг: Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг хэрхэн үр дүнтэй оролцуулах вэ?** Энэ нь авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудын үр дүнтэй оролцоог хангах байгууллагын бэлэн байдлыг үнэлэх, сайжруулах, эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах, суралцах талаар тэдний хүчин чармайлтыг хянах, үнэлэх чиглэлээр алхам алхмаар нарийвчилсан зааварчилга өгдөг.

Энэхүү гарын авлагад дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хэрхэн хувь нэмэр болох талаарх санааг төгсгөлийн бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно. Түүнчлэн судалгаа хийх, мэдээлэл цуглуулах талаарх мэдээллээс гадна авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудтай бүтээлчээр хамтран ажиллахад бэлэн эсэхийг үнэлэх чиглэлээр дэлгэрэнгүй мэдээллийг хүргэнэ.



1

ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭ





Нэгдүгээр бүлэг: Үзэл баримтлалын хүрээ

Бүлгийн тойм

Чиглүүлэх асуулт:

Энэхүү гарын авлага нь ямар мэдээлэл, өгөгдөл, судалгаа, үзэл баримтлалд үндэслэсэн бэ?

Гол санаа:

- ➔ Энэхүү гарын авлага нь залуучуудыг татан оролцуулах хүсэл эрмэлзэл бүхий авлигатай тэмцэх байгууллагууд дутагдаж буй тэдгээрийг үр дүнтэй оролцуулах зааварчилгаа болно.
- ➔ Залуучуудын үр дүнтэй оролцоо ба авлигатай тэмцэх байгууллагуудын ажлын уялдаа холбоог гурван ойлголтоор тодорхойлдог.
 - ◆ Залуучуудын оролцоо: Оролцооны үүрэг, оролцооны төрлөөс хамааран залуучуудын хувь нэмрийг “дуу хоолой”, “үзэл бодол”, “үйлдэл” гэж ангилж болно.
 - ◆ Залуучуудын үр дүнтэй оролцоо: Залуучуудын оролцоог үр дүнтэй болгоход олон талт байдал, тэгш оролцоо, оролцоог хангах таатай орчин, үе хоорондын хамтын ажиллагаа, залуучуудын чанартай оролцоо ба залуучуудыг чадавхжуулах гэсэн таван үндсэн санаагаар тодорхойлогддог тодорхой нөхцөлд үйл ажиллагааг явуулах ёстой.
 - ◆ Авлигатай тэмцэх байгууллагуудын ажлыг урьдчилан сэргийлэх, хууль сахиулах, олон нийтэд таниулах/ухамсрыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, зохицуулалт/бодлого боловсруулах гэсэн таван чиг үүрэгт хуваадаг.
- ➔ Энэхүү гарын авлага нь ном, гарын авлага, материал, анхан шатны судалгаа (чанарын болон тоон мэдээлэл)-ны өгөгдөлд үндэслэсэн болно.



1А. Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын үр дүнтэй оролцоог хангахад баримтлах бодлогын удирдамж

Авлигатай тэмцэх нь зөвхөн Засгийн газар, авлигатай тэмцэх байгууллагуудын үүрэг биш юм. Олон талт хандлагын ач холбогдлыг дэлхийн бодлогын хэрэглүүр улам бүр хүлээн зөвшөөрч байна. Үүнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцын 13.1-д “иргэний нийгэм зэрэг нийтийн албанаас гаднах хувь хүн, бүлгийн идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих зохих арга хэмжээ авахыг” гишүүн орнуудад уриалсан байдаг.

Залуучууд иргэний нийгмийн гишүүдийн хувьд өөрийн улс орон, нутаг дэвсгэртээ авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэднийг цаашид ч үргэлжлүүлэн урамшуулан дэмжиж, чадавхжуулж, хэрэгжүүлэх боломжийг олгох нь чухал юм. 2021 оны арван хоёрдугаар сарын 13-17-ны өдрүүдэд Шарм-Эль-Шейх хотноо хуралдсан НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын гишүүн орнуудын бага хурал есдүгээр чуулганаараа 9/8 дугаар тогтоол гаргаж, “авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд боловсролын үүргийг нэмэгдүүлэх, залуучуудыг чадавхжуулах” шаардлагатайг нотолсон. Энэхүү баримт бичиг нь авлигын эсрэг боловсролыг дэмжих, залуучуудын оролцоо, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж, уялдаа холбоотой ажиллах нь чухал гэдгийг дахин онцолжээ.

Хэдийгээр залуучуудын оролцоо чухал гэдгийг онцолж байгаа хэдий ч авлигатай тэмцэх байгууллагууд энэхүү оролцоог хэрхэн хангах талаарх зааварчилгаа хомс байна. Гарын авлага нь энэхүү орон зайг нөхөж, авлигатай тэмцэх байгууллага болон олон улсын авлигатай тэмцэх нийгэмлэгийн оролцогч талуудад залуучуудыг үйл ажиллагаандаа үр дүнтэй татан оролцуулахад нь туслах зорилготой юм. Энэ нь залуучуудыг ажилдаа татан оролцуулж буй авлигатай тэмцэх байгууллагуудад үнэлэмж болж, энэхүү хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, энэ замыг хараахан сонгоогүй байгаа авлигатай тэмцэх байгууллагуудад мэдээлэл өгөх, урам зориг төрүүлэхийг зорьж байна. Мөн төрийн холбогдох байгууллагуудын авлигатай тэмцэх бодлого боловсруулагчид болон бусад оролцогч талууд, тэр дундаа олон улсын байгууллага, шинжлэх ухаан, хөгжлийн түншүүд, иргэний нийгэм, залуучуудад хэрэгцээт эх сурвалж болох зорилготой юм. Энэхүү гарын авлагын зорилтот бүлэгт авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын албан хаагч, менежер болон улс орон, нутаг дэвсгэртээ авлигатай тэмцэх үндэсний хүчин чармайлтыг удирдан чиглүүлэх үүрэг бүхий бусад бодлого боловсруулагчид багтана.



Энэхүү гарын авлага нь хэрэгцээт, практик удирдамжаар хангах зорилгоор залуучуудын оролцоог хангах арга барилд чиглэсэн болно. Хэдийгээр онолын үзэл баримтлалыг товч тусгасан боловч тэдгээрийг практикт хэрэглэх зөвлөмж, жишээг хуваалцахад онцлон анхаарав. Гарын авлага нь дэлхийн өнцөг булан бүрд үйл ажиллагаа явуулж буй авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгцээ шаардлага, ашиг сонирхлыг ойлгоход туслах судалгаа, анхан шатны мэдээлэлд үндэслэсэн.

Энэхүү гарын авлага нь бие даасан бүтээл биш, харин авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудын үр дүнтэй оролцоог хангах практик хамтын нийгэмлэгийг бий болгох анхдагч хөшүүрэг болох болно. Үүний тулд туршлага, арга хэрэгсэл, авсан сургамжаа хуваалцах замаар үе тэнгийнхэнтэйгээ суралцах вэб порталын дэлгэрэнгүй мэдээлэл, мөн энэхүү тайлангийн судалгааны үр дүн, анхны практик жишээг оруулсан болно. Үүнийг <https://www.icac.org.hk/icac/myeguide/> дээрээс үзэж болох бөгөөд энэхүү гарын авлагад дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд туслах арга хэмжээний талаарх нэмэлт санааг Дөрөвдүгээр бүлэгт оруулсан болно.

Энэхүү гарын авлага нь энэхүү зөрүүг арилгах, авлигатай тэмцэх эрх бүхий байгууллага болон олон улсын авлигатай тэмцэх нийгэмлэгийн оролцогч талуудад залуучуудыг ажилдаа үр дүнтэй оролцуулахад нь туслах зорилготой юм. Энэ нь залуучуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулж буй авлигатай тэмцэх байгууллагуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх, энэ ажлыг хараахан эхлүүлээгүй байгаа авлигатай тэмцэх байгууллагуудад мэдээлэл, урам зориг өгөхийг зорьж байна.



15. Нэр томьёо, ойлголтын тодорхойлолт

Дараах нэр томьёо, ойлголтууд нь энэхүү гарын авлагын хэлэлцүүлгийн үндэс болно:

Залуучууд: 15-30 насны хүмүүс. Нэгдсэн Үндэстний Байгууллага “залуучууд” гэсэн нэр томьёог 15-24 насны хүмүүсийг хамааруулан ойлгохоор албан ёсоор тодорхойлдог ч (НҮБ-ын залуучуудын талаарх бүх статистик мэдээлэл энэ тодорхойлолт дээр үндэслэдэг) НҮБ “залуучууд гэсэн нэр томьёоны ажлын тодорхойлолт, нарийн ялгаа нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг”¹ гэдгийг хүлээн зөвшөөрдөг ба энэ нь нийгэм соёл, институт, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлүүдтэй холбоотой бөгөөд үйл ажиллагаа явуулж буй улс орнуудад тохирсон байдаг.² Тус гарын авлагад энэхүү уян хатан тодорхойлолтын дагуу залуучуудыг тодорхойлох насны дээд хязгаарыг 30 нас болгон нэмэгдүүлсэн.

Залуучуудын оролцоо: Авлигын эсрэг үйл ажиллагаанд оролцож буй залуучууд түүнийг төлөвлөх, загварчлах, хэрэгжүүлэх, үр дүнд нь хэрхэн хувь нэмрээ оруулахыг хоёр үндсэн хүчин зүйл тодорхойлдог.

- ➔ **Гүйцэтгэх үүрэг:** Залуучууд нь оролцогч, сайн дурын ажилтан, цалинтай дадлагажигч, авлигатай тэмцэх байгууллагын залуу ажилтан, хамтрагч, эсхүл санаачилга удирдагч зэрэг өөр өөр түвшний үүрэг хариуцлага хүлээж болно.
- ➔ **Төрөл:** Залуучууд өөрсдийн хүч чадлаа хэрхэн ашиглаж байгаагаас хамааран авлигатай тэмцэх үйл ажиллагаанд янз бүрийн хэлбэрээр хувь нэмрээ оруулж болно. Энэхүү гарын авлагад залуучуудын оролцооны үйл ажиллагааг дараах гурван ангилалд хуваадаг:³

- ♦ **Дуу хоолой:** Оролцогч талууд болон шийдвэр гаргагчид, түүний дотор авлигатай тэмцэх байгууллагуудтай харилцан яриа хэлэлцээ өрнүүлж, тэдэнд нөлөөлж буй асуудлыг хөндөх.
- ♦ **Үзэл бодол:** авлигатай тэмцэх байгууллагуудын шийдвэр, түүний дотор тэдний бодлого, хөтөлбөрийг мэдээлэх зорилгоор залуучуудаас мэдлэг цуглуулах, дамжуулах.
- ♦ **Үйлдэл:** Авлигатай тэмцэх үйл ажиллагаа зэрэг өөрсдөдөө болон тэдний бүлгэмд нөлөөлж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн санаачилгыг манлайлах буюу оролцох.

Эдгээр тодорхойлолт нь нарийн ялгаатай биш бөгөөд олон үйл ажиллагааны хувьд давхцаж болно. Тодорхойлолтууд нь залуучуудын оролцооны янз бүрийн төрлийг ойлгоход дөхөм болох үзэл баримтлалын хүрээг бүрдүүлдэг.

¹ United Nations, “Global Issues: Youth”.

² General Assembly resolution 36/81; and United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *Meaningfully engaging with youth* (Paris, 2019).

³ The concept is drawn from the research detailed in Plan International and Asian Development Bank, *What's the evidence? Youth engagement and the Sustainable Development Goals* (2018).



Авлигатай тэмцэхэд залуучуудын үр дүнтэй оролцоо: Залуучуудыг таатай орчин бүрдүүлэн оролцуулбал зохих бөгөөд үүний үр дүнд залуучууд авлигын эсрэг санаачилгын янз бүрийн үе шатанд оролцогч талуудтай хамтран идэвхтэй оролцож, тэднийг чадавхжуулж, авлигын эсрэг үр дүнг нэмэгдүүлэхэд хүргэдэг.⁴

Залуучууд оролцож буй бүх үйл ажиллагааг үр дүнтэй гэж үзэх боломжгүй тул залуучуудын “үр дүнтэй” оролцоог залуучуудын оролцооноос ялгах нь чухал Тухайлбал, тэдгээр нь бэлгэдлийн шинжтэй⁵ байж болох ба тэр ч байтугай оролцож буй залуучууд, санаачилга, тэдгээрийг зохион байгуулж буй байгууллагуудад сөрөг нөлөө үзүүлж болно.⁶ Үүнээс гадна авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудын оролцоог үр дүнтэй болгоход чиглэх үед залуучуудын оролцооны үйл ажиллагаа нь үнэ цэнэтэй туршлагыг хуримтлуулах болно (залуучуудын үр дүнтэй оролцооны боломжуудын талаарх мэдээллийг 30-31 дүгээр хуудаснаас үзнэ үү).

Залуучуудын үр дүнтэй оролцооны тухай ном, гарын авлагад гарч буй янз бүрийн тодорхойлолтууд нь ихэвчлэн тодорхой салбар, эсхүл үндсэн санаатай холбоотой байдаг бөгөөд НҮБ-ын “Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад залуучуудын үр дүнтэй оролцоо” гэсэн гарчигтай нийтлэлд залуучуудын үр дүнтэй оролцооны талаар дурдсан байдаг. Бидний судалгаагаар эдгээр тодорхойлолтууд нь залуучуудын оролцоог “үр дүнтэй” гэж тодорхойлох таван сэдэвт үндсэн санааг нэгтгэсэн байна. Үндсэн санаануудыг дараагийн хуудасны хүснэгтэд нэгтгэн харуулав.

Залуучуудын оролцоо нь таатай нөхцөлд явагддаг бөгөөд үүний үр дүнд залуучууд авлигын эсрэг санаачилгын янз бүрийн үе шатанд оролцогч талуудтай хамтран идэвхтэй оролцож, энэ нь тэднийг чадавхжуулж, авлигын эсрэг үр дүнг сурталчлахад тусалдаг.

⁴ Plan International, Youth Voice in Youth Employment сэтгүүл: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдэд залуучуудын үр дүнтэй оролцоог дэмжих замын зураглал (2021)

⁵ Жишээ нь: залуучуудад бодитой эрх мэдэл, нөлөө үзүүлэхгүйгээр шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах, эсхүл залуучуудын олон талт, хүртээмжтэй төлөөллийг хангахгүйгээр хязгаарлагдмал тооны залуучуудын төлөөллийг сонгох гэсэн өнгөцхөн буюу далд оролдлого.

⁶ UNESCO, *Meaningfully engaging with youth*.



Хүснэгт 1: Залуучуудын үр дүнтэй оролцоог тодорхойлсон үндсэн санаа

Үндсэн санаа	Тодорхойлолт
Олон талт байдал ба тэгш оролцоо	Залуучуудын олон талт байдлыг танин мэдэж, байгууллагууд залуучуудын өөр өөр гарал үүслийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн, бүх залуучуудад, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст тэгш боломж олгох шаардлагатайг онцолдог.
Оролцоог хангах таатай орчин	Үйл ажиллагаа, институциудыг хангахын чухлыг онцолдог: ➔ Залуучуудыг татан оролцуулахад шаардлагатай бүх зүйлийг бэлэн болгох (жишээ нь нөөц, боловсон хүчний чадавх, удирдлагын дэмжлэг) ➔ Залуучуудад ээлтэй ажлын арга барил, материалыг ашиглах (жишээ нь, залуучууд чөлөөтэй байх үед энгийн үг хэллэг, цагийн хуваарийг ашиглах) ➔ Залуучуудын үзэл бодлоо хуваалцах, оролцох аюулгүй орчинг бий болгох
Үе хоорондын хамтын ажиллагаа (түншлэл)	Залуучууд болон насанд хүрэгчид хамтран ажиллаж, бие биедээ хариуцлага тооцон, насанд хүрэгчид залуучуудын оруулсан хувь нэмрийг хүндэтгэн, тэднийг адил тэгш хэмээн хүлээн зөвшөөрч, дэмждэг.
Залуучуудын чанартай оролцоо	Залуучууд аливаа санаачилгын янз бүрийн үе шатанд, ялангуяа эхний шатанд нь харилцан зөвшилцснөөр оролцдог үйл ажиллагаа; залуучуудын нас, чадавхад тохирсон арга хэмжээ; ялангуяа залуучуудын саналыг хэрхэн ашиглаж байгаа талаарх мэдээллийг тогтмол түгээдэг арга хэмжээг хэлнэ.
Залуучуудыг чадавхжуулах	Залуучуудын чадавхыг нэмэгдүүлэх, сайжруулах боломжийг олгож, сүлжээ, сонирхогч талуудад хандах боломжийг нэмэгдүүлж, олон нийт болон нийгэм дэх өөрчлөлтөд нөлөөлөх залуучуудаар удирдуулсан үйл ажиллагааг эхлүүлдэг.



Авлигын эсрэг үйл ажиллагаа: Энэ нь төрийн болон хувийн хэвшилд авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийтгэх үйл ажиллагаа юм. Энэхүү гарын авлагын хувьд Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь авлига, авлигатай тэмцэх үйл ажиллагааг тодорхойлох үндсэн эх сурвалж болж байна. Үндэсний эрх зүйн зохицуулалтын олон талт байдал, авлигын динамик, хувьсан өөрчлөгдөж буй, цогц шинж чанарыг харгалзан үзэхийн тулд Авлигын эсрэг конвенцод нарийвчилсан тодорхойлолт өгөөгүй байна. Харин авлигын тодорхой үйлдлүүдийг тодорхойлж, оролцогч улсуудад эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Энэ нь авлигатай тэмцэх олон улсын хууль хэмжээнд хууль ёсны хүчин төгөлдөр цорын ганц баримт бичиг бөгөөд нийтлэгдэх үед 190 улс баталсан авлигын эсрэг хамгийн өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт юм.

Авлигатай тэмцэх байгууллагууд (агентлагууд): Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй төрийн байгууллага. Авлигатай тэмцэх зарим эрх бүхий байгууллага байгуулагдаад удаж байгаа хэдий ч авлигатай тэмцэх чиглэлээр тусгай байгууллагуудыг байгуулах нь олон улсын баримт бичиг, тэр дундаа 2003 онд батлагдсан Авлигын эсрэг конвенцод нийцсэн институцийн хариу арга хэмжээ болж улам бүр нэмэгдсээр байна. Уг конвенцод авлигаас урьдчилан сэргийлэх (6 дугаар зүйл), хууль сахиулах замаар авлигатай тэмцэх (36 дугаар зүйл) байгууллага, байгууллагуудыг бий болгох тухай заалтууд багтсан болно. Энэ нь хэдийгээр оролцогч улсуудад авлигатай тэмцэх тусгай байгууллагатай байхыг үүрэг болгодоггүй ч олон улс орон, нутаг дэвсгэрт ийм байгууллага байгуулахад хүргэсэн. Тухайлбал, өнөөдрийн байдлаар Олон улсын авлигатай тэмцэх байгууллагуудын холбоо /АТБХ/-д 160 гаруй авлигатай тэмцэх байгууллага гишүүнээр элссэн байна. Дэлхийн олон оронд авлигатай тэмцэх байгууллага байдаг ч одоогоор тэдний нарийн тоог судалгаагаар тогтоогоогүй байна.⁷

Үндэсний хэмжээнд авлигатай тэмцэх байгууллагуудын үндсэн чиг үүргийг Хүснэгт 2-т үзүүлэв. Хөрөнгө буцаах, мөрдөн шалгах ажиллагаан дахь олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх зэрэг олон улсын үүрэг хариуцлагыг оруулаагүй болно. Эдгээр нь тусгай техникийн ур чадвар шаарддаг бөгөөд байгууллагуудыг төлөөлөн ажилладаг албан тушаалтнууд гүйцэтгэдэг.

Тиймээс үүнд залуучуудыг татан оролцуулахад тохиромжгүй гэж үздэг.

⁷ French Anti-Corruption Agency, *Global Mapping of Anti-Corruption Authorities* (2020) үзэх.



Хүснэгт 2: Үндэсний хэмжээнд авлигатай тэмцэх байгууллагын чиг үүргийн тодорхойлолт

Чиг үүрэг	Тодорхойлолт
Урьдчилан сэргийлэх	Ил тод байдал, хяналт, шалгалт, тэнцвэрийн тогтолцоог (жишээ нь ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, хөрөнгийн мэдүүлэг, ёс зүйн дүрэм) сайжруулах замаар авлигаас урьдчилан сэргийлэх хүчин чармайлт. Үүнд хамтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжих, ийм практик, бодлогын талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа орно (НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 5, 6 дугаар зүйлийг үзнэ үү).
Хууль сахиулах	Хэргийг мөрдөн шалгах, яллах, сэжигтэй хэргийг мэдээлэх, нотлох баримт цуглуулах, байгууллага хооронд хамтран ажиллах, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх замаар авлигатай тэмцэх хүчин чармайлт (Авлигын эсрэг конвенцын 36 дугаар зүйлийг үзнэ үү).
Олон нийтийг хамарсан сурталчилгаа, мэдлэгийг нэмэгдүүлэх	Авлигын хор уршгийг талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, ил тод, шударга, хариуцлагатай байдал, хууль дээдлэх зэрэг авлигатай тэмцэх зарчмуудыг дэмжих, шударга ёс, итгэлцлийн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн хүчин чармайлт. Үүнд кампанит ажил, нөлөөллийн ажил, олон нийттэй харилцах үйл ажиллагаа хамаарна.
Боловсрол	Суралцах, мэдлэг, ур чадвар, үнэт зүйлийг олж авахад туслах хүчин чармайлт. Үүнд бага, дунд, дээд боловсрол, түүнчлэн мэргэжлийн болон мэргэжлийн ахисан түвшний боловсрол эзэмшиж буй хүмүүсийн дунд авлигатай тэмцэх соёл, ёс зүйн зан үйлийг төлөвшүүлэх мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа хамаарна.
Зохицуулалт, бодлого боловсруулах	Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг үнэлэх, бодлогыг шинэчлэх, авлигын эсрэг төрийн зохицуулалт, хууль тогтоомжийг бий болгох хүчин чармайлт. Авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд чиглэсэн хууль тогтоомж, дүрэм журам, бодлого боловсруулах (хувь нэмэр оруулах) үйл ажиллагаа багтана. Энэхүү олон талт чиг үүрэг нь авлигатай тэмцэх үндэсний стратегийг боловсруулах, зохицуулах, хэрэгжүүлэх, авлигатай тэмцэх үндэсний олон байгууллага, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зэрэг юм.

Авлигатай тэмцэх байгууллагын бүрэн эрхийг урьдчилан сэргийлэх, хууль сахиулах чиг үүргээр хязгаарлах, эсхүл аль алиныг нь хослуулсан хэлбэрээр тогтоож болно. Үүний үр дүнд урьдчилан сэргийлэх, хууль сахиулах, эсхүл олон зорилго бүхий гурван өөр төрлийн байгууллагыг бий болгоход хүргэж болзошгүй.⁸ Гэсэн хэдий ч залуучуудыг хэрхэн үр дүнтэй татан оролцуулах талаарх зөвлөмжүүд нь зөвхөн тухайн үйл ажиллагааны шинж чанараас шалтгаалах тул аливаа төрлийн авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага болон бусад төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаанд хамаарна.

⁸ Organisation for Economic Co-operation and Development, *Specialized Anti-Corruption Institutions – Review of Models: Second Edition* (Paris, 2013).

1В. Бодлогын гарын авлагын судалгаа

Залуучуудын үр дүнтэй оролцоо, авлигатай тэмцэх байгууллагуудын ажлын уялдаа холбоог судалсан эрдэм шинжилгээний ажил, судалгаа хомс байна. Өргөн хүрээний оролцоо ба хөгжлийн талаарх ном, гарын авлагын хувьд залуучуудыг татан оролцуулах (эсхүл залуучуудын оролцоо) ялангуяа боловсрол, эрүүл мэнд, засаглалын талаарх эрдэм шинжилгээний бүтээл, түүнчлэн байгууллагын тайлан, бусад хэвлэл, семинарын илтгэл, тунхаг зэрэг эрдэм шинжилгээний бус ном, гарыг авлагад тусгагдсан байдаг. Авлигын эсрэг санаачилгад залуучуудын оролцоог харуулсан эрдэм шинжилгээний судалгаа бага байна. Түүнчлэн залуучуудын “үр дүнтэй” оролцоо гэдэг ойлголт сүүлийн жилүүдэд, ялангуяа НҮБ зэрэг олон улсын байгууллагууд болон иргэний нийгмийн янз бүрийн сүлжээнд бий болсон.

Залуучуудыг авлигын эсрэг тэмцэлд үр дүнтэй татан оролцуулах чиглэлээр шинжээч, мэргэжилтний чиглэл шаардлагатай байсан нь энэхүү гарын авлагад зориулан шинэ судалгааг хийхэд хүргэж, судалгааг 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 2 дугаар сарын хооронд зохион байгуулсан. Тулгарсан сорилтуудын нэг нь залуучуудын оролцоо, залуучуудын үр дүнтэй оролцооны талаарх одоо байгаа үзэл баримтлалыг өөрчлөх, бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгчид өөрсдийн ажилдаа хэрэглэх боломжтой хүрээнд авлигатай тэмцэх үйл ажиллагаатай уялдуудах хэрэгцээ байв. Үүний үр дүнд шинээр гарч ирж буй салбарын анхны, шинэлэг судалгаанд тулгуурлан цаашид нэмэлт судалгаа хийвэл үр өгөөжөө өгөх энэ сэдвээр анхны бодлогын гарын авлага болж байгаа юм. Энэхүү гарын авлагад зориулан хийсэн арга зүй, судалгааны тайлбарыг Хавсралт I-д үзүүлэв.

⁹ United Nations, *Our Common Agenda Policy Brief 3: Meaningful Youth Engagement in Policymaking and Decision-making Processes* (2023).

УЛС ОРНУУДЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГУУД ЗАЛУУЧУУДЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХЭРХЭН ТАТАН ОРОЛЦУУЛДАГ ТАЛААР СОНИРХОЖ БАЙНА УУ?



БНХАУ-ын Хонг Конг дахь АЭБДХ-ны элч нар их, дээд сургуулийн оюутнуудын авлигын талаарх ойлголтыг нэмэгдүүлж байна.

Авлигын эсрэг бие даасан хороо(АЭБДХ)-ноос залуучуудыг шударга байдал, авлигатай тэмцэх чиглэлээр хийж буй ажилд татан оролцуулах зорилгоор АЭБДХ-ны **Элчийн хөтөлбөрийг** боловсруулжээ. Жил бүрийн энэ хөтөлбөрийг их, дээд сургуулиудтай хамтран хэрэгжүүлдэг.

Шударга ёс, авлигатай тэмцэх, хууль дээдлэхийг сурталчлах сонирхолтой залуучуудаас нээлттэй сонгон шалгаруулалтыг явуулдаг. АЭБДХ-ны сонгосон Элч нар манлайллын сургалт, зөвлөгөө өгөх, төсөл боловсруулах, менежментийг багтаасан нэг жилийн хөтөлбөрт хамрагддаг.

Шударга байдал, хууль ёсны талаар залуучуудад чиглэсэн мессежийг бэлтгэхийн тулд залуучууд багаар ажилладаг бөгөөд дараа нь кампус болон онлайн мэдээллийн хэрэгслээр үе тэнгийнхэндээ түгээдэг. Үүнд багт наадам, семинар, асуулт хариулт, онлайн кампанит ажил болон залуучуудын дунд түгээмэл хэрэглэгддэг бусад арга хэмжээг зохион байгуулж болно.



ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ АЛБА

ОЮУТНУУДЫН ЧАДАВХЫН ӨРСӨЛДӨӨН МАРГААШИЙН ШУДАРГА БАЙДЛЫН МАНЛАЙЛАГЧИД



www.aead.gr



Грекийн “Маргаашийн Шударга байдлын манлайлагчид” тэмцээн нь залуу үеийнхэнд оролцох урам зориг өгч байна.

Залуучуудын дунд авлигын эсрэг ойлголт дутмаг байгааг харгалзан Грекийн Ил тод байдлын үндэсний газар (ИТБҮГ) идэвхтэй арга хэмжээ авч, залуучуудад авлигын эсрэг боловсрол олгоход чиглэсэн кампанит ажлыг орон даяар эхлүүлсэн.

Уламжлалт арга хэлбэрээр залуучуудыг чиглүүлэхээс илүүтэй хамтран ажиллах арга барилыг сонгон, залуучуудыг өдөр тутмын амьдралдаа авлигатай тэмцэх, ёс зүй, шударга ёсыг баримтлах чиглэлээр өөрсдийн кампанит ажлын төслүүдийг хэрэгжүүлэх боломж олгосон. ИТБҮГ нь өргөн хүрээний оролцогчдыг татахын тулд бага, дунд, ахлах сургуулиудтай хамтран ажиллаж, богино хэмжээний кино, зурагт хуудас, хүүхэлдэйн кино, өгүүллэг болон бусад бүтээлч ажлуудыг агуулсан **урлагийн төслүүдээ** ирүүлэхийг уриалсан. Дараа нь эдгээр материалыг янз бүрийн салбарын мэргэжилтнүүдээс бүрдсэн уралдааны хороо хянан үзэж сонгон шалгаруулсан.

ИТБҮГ нь Боловсролын яам, олон улсын байгууллага, ТББ, залуучуудын нийгэмлэгийн нөлөө бүхий хүмүүс зэрэг нэр хүндтэй байгууллагуудтай байнга хамтран ажиллаж, хамгийн онцгой төслүүдийг шалгаруулдаг.



Кирибати Гадаад арлуудын овог аймгуудын дунд драмын замын шоу зохион байгуулдаг.

Номхон далайн өмнөд хэсэгт орших 33 арлаас бүрдсэн жижиг улс болох Кирибатиин Төрийн үйлчилгээний алба (ТҮА) авлигатай тэмцэх зэрэг шинэчлэлийнхээ талаар олон нийтэд хүргэх арга замыг эрэлхийлж байна. Тус улсын хүн амын зонхилох хэсэг болох залуучуудад хүргэх мессежийг хамгийн сайн түгээгч нь залуучууд бөгөөд тэдэнтэй харилцах хамгийн сайн арга бол тайзны урлаг юм гэж ТҮА-аас дүгнэсэн.

ТҮА-аас орон нутгийн иргэний нийгмийн залуучуудын бүлгийг татан оролцуулж, залуучуудад өөрсдийнх нь хэлээр, интерактив хэлбэрээр гол мессежийг хүргэх зорилгоор авлигатай тэмцэх газрын ажилтнуудын бичсэн **драмын** жүжгийг үзүүлсэн. Жүжигчдийг хэсэг бүлгээрээ арлуудыг тойрон аялж, нутгийн овог аймгуудад эдгээр интерактив үзүүлбэрүүдийг хүргэх арван хоёр залуу идэвхтнүүдийг сонгосон. Мөн авлигын эсрэг үзэл баримтлалын талаар олон нийтийг хэлэлцүүлэгт татан оролцуулах зорилгоор үзүүлбэрүүдийг ашиглажээ.




Мексикийн Авлигын эсрэг дататонд залуучууд хамтран ажилласан.

2018 оноос хойш Үндэсний дижитал платформоор дамжуулан Мексикийн Авлигатай тэмцэх үндэсний тогтолцооны Гүйцэтгэх ажлын алба жил бүр **авлигын эсрэг Дататоныг зохион байгуулдаг** бөгөөд энэ нь төрийн тогтолцооны өгөгдлийг ашиглан авлигын эсрэг залуучуудыг нэгтгэх платформ юм. Мэдээлэлд төрийн худалдан авах ажиллагааны алба гэх мэт олон төрийн байгууллагуудын өгөгдлүүд багтсан болно.

Жил бүр Дататон тэмцээнд эмэгтэйчүүд, залуучууд зонхилсон 70 гаруй хүн оролцдог. Багуудыг авлигатай тэмцэх чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд чиглүүлдэг. Оролцогчид өөрсдийн гарц, шийдлүүдийг дэвшүүлдэг бөгөөд шилдэг санааг шалгаруулж, энэ нь дижитал инновац ба авлигатай тэмцэх ажлын хоорондын уялдаа холбоог сайжруулахад дэмжлэг болдог. Залуучуудын бүтээлч санааг тус улсын Үндэсний дижитал платформд нэгтгэсэн нь авлигатай тэмцэхэд залуучуудад чиглэсэн инновацын ач холбогдлыг бататгаж байна.

Эдгээр жишээнүүдийн дэлгэрэнгүйг энэхүү бодлогын гарын авлагын вэб порталаас үзэж болно.





2

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
БАЙГУУЛЛАГУУД
ЗАЛУУЧУУДЫГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНДАА ТАТАН
ОРОЛЦУУЛАХ ҮНДЭСЛЭЛ





Хоёрдугаар бүлэг:

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг татан оролцуулах үндэслэл

Бүлгийн хураангуй

Чиглүүлэх асуулт:

Авлигатай тэмцэх байгууллагууд яагаад залуучуудыг татан оролцуулах шаардлагатай вэ?

Гол санаа:

- ➔ Авлигатай тэмцэх байгууллагууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ авлигаас үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж, тэмцэх, оролцогч талуудтай зөв зохистой харилцах болон нөөцийг үр ашигтайгаар удирдах гэсэн гурван үндсэн асуудалтай тулгардаг. Залуучуудыг татан оролцуулах явдал нь эдгээр асуудлыг шийдвэрлэхэд тусална.
- ➔ Залуучуудын оролцоог дэмжихэд авлигатай тэмцэх байгууллагуудад тулгардаг хамгийн нийтлэг бэрхшээл нь залуучуудын чадавх болон тухайн байгууллагын бэлэн байдалтай холбоотой байдаг.
- ➔ Залуучуудыг татан оролцуулах нь авлигатай тэмцэх байгууллагуудад, тэр дундаа салбараасаа гадуур ажиллах томоохон боломжийг олгодог.






2А. Залуучуудын оролцооны давуу тал

Уламжлалын хувьд залуучуудын оролцоог авлигатай тэмцэх байгууллагын ажлын гол бүрэлдэхүүн хэсэг гэж үздэггүй байлаа. Бүрэн эрх, төсөв, шаардлагатай чадамж олон байгууллагад дутмаг байдаг. Тэдгээрийн ажлын мөн чанар нь өндөр нууцлал болон тодорхой ур чадвар шаарддаг. Иргэний нийгэмтэй хамтран ажиллах тодорхой болгоомжлол байгаагаас гадна эдгээр хүчин зүйлс нь авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудын оролцоо хязгаарлагдмал байгааг илэрхийлдэг.

Авлигатай тэмцэх байгууллагуудын талаарх манай судалгаанаас харахад оролцогч байгууллагуудын дийлэнх нь залуучуудыг татан оролцуулах нь чухал гэж үзсэн байна. Эдгээр байгууллагууд залуучуудыг дэмжих үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, бэхжүүлэхийг зорьж байна.



Жич: Эхний асуултад 10 (цэнхэр зураас), хоёр дахь асуултад (улаан зураас) 11 оролцогчийн сонгосон “Би мэдэхгүй/хариулахгүй байхыг илүүд үзэж байна/Хариулах боломжгүй” гэх хариултуудыг зурагт оруулаагүй болно.

Авлигатай тэмцэх зарим байгууллагууд бүрэн эрхийнхээ хүрээнд, эсхүл авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд залуучуудыг татан оролцуулах үүрэгтэй. Судалгаанд оролцсон 73 авлигатай тэмцэх байгууллагын 47 (64 хувь) нь үндэсний хөтөлбөрийг хариуцан ажилладаг гэж хариулжээ. Эдгээрээс 35 байгууллага (74 хувь) залуучуудын оролцооны талаар үндэсний хөтөлбөрт тусгагдсан гэж хариулсан байна.

Дээрх гаргасан загвараас харвал залуучуудыг татан оролцуулж байгаа 49 авлигатай тэмцэх байгууллагын үзэж байгаагаар залуучуудын оролцуулахын гол давуу тал нь:¹⁰

- ➔ Байгууллагын үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх (78 хувь)
- ➔ Залуучуудыг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд оролцуулах нь тэдэнд таатай байх болно гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх (71 хувь)
- ➔ Залуучуудын сонирхол, хэрэгцээнд илүү нийцсэн үйл ажиллагаа (65 хувь)
- ➔ Авлигатай тэмцэх байгууллагууд шинэлэг шийдэл, санааг олж авдаг (65 хувь)
- ➔ Залуучууд авлигатай тэмцэх үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл цуглуулахад тусалцаа үзүүлдэг (63 хувь)

¹⁰ Энэхүү судалгааны асуултад олон хариулт өгөхийг зөвшөөрсөн.

Авлигатай тэмцэх байгууллагуудын залуучуудын оролцоог хангаж байгаа гол үр өгөөж нь тэднийг оролцуулж буй байгууллагуудын үйл ажиллагаа, суурь мэдлэгт үнэ цэнийг нэмэгдүүлж чадах залуучуудын онцлог шинж чанар юм. Эдгээр шинж чанар нь:¹¹



Бүтээлч байдал: Залуучууд ямар нэгэн бэрхшээлийг ихэвчлэн бүтээлч арга замаар даван туулдаг. Судалгаанаас харахад залуучууд бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх, нөөцийг олж авахад бэрхшээлтэй тулгарвал нөөц хязгаарлагдмал байсан ч бүтээлч, шинэлэг арга замыг эрэлхийлдэг.



Төрөлхийн хамтрагчид: Залуучууд нийгмийн нөхцөл байдлыг сайжруулах хүсэл эрмэлзлээс үүдэлтэй үе хоорондын хамтын ажиллагаа зэрэг сүлжээ, холбоо байгуулах гэх мэт хамтын ажиллагааны арга барилд ихээхэн ач холбогдол өгөх хандлагатай байдаг.



Халамжтай, хариуцлагатай иргэд: Технологийн хүртээмжтэй, дэлхийн үйл явдлын талаар мэдлэгтэй залуучууд дэлхийн сайн сайхны төлөө Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахад бэлэн, тууштай, урам зоригтой байх магадлалтай.



Дижитал ур чадвар: Залуучуудын байгалиас заяасан технологийн чадвар нь дижитал технологийн хурдацтай хөгжилтэй нийцэж байна. Залуучуудаар манлайлуулсан хөгжлийн санаачилгын дижитал бүрэлдэхүүн хэсэг нь эерэг үр дүнд хүрэхийг нэмэгдүүлдэг болохыг нотлох баримт харуулж байна.



Нөлөөлөл: Залуучууд нийгэмд итгэлцлийг бий болгохын сацуу өөрсдөө гүн гүнзгий ойлголттой болж, төслийн үр дүнг дэмжих, мэдээлэх зорилгоор үе тэнгийнхэн, эцэг эх, хамт олондоо нөлөөлж, сургадаг.



Шинэлэг сэтгэлгээ: Түүхэн цаг үеийн асуудалд шинэ хандлагыг тодорхойлох үүрэгтэй залуучууд бол үнэ цэнтэй хөрөнгө юм.

¹¹ АХБ-ны "Азийн залуучуудын төлөөх АХБ" номноос авав.



Дээрх шинж чанарууд нь авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэгцээтэй болох нь манай судалгаагаар тогтоогдсон. Авлигатай тэмцэх байгууллагуудын хувьд залуучуудад байвал зохих хамгийн тохиромжтой таван онцлог шинж чанарыг доорх графикт дэлгэрэнгүй харуулав.



Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны чадавх нь залуучуудтай авлигатай тэмцэхэд хамтарч ажиллаж чадах хэмжээнд хүрэх бололцоог олгох тодорхой шалгуурыг хангасан байх ёстой. Ном зохиолын тойм, ярилцлага болон фокус бүлгийн хэлэлцүүлэг нь үйл ажиллагааны дараах гурван үндсэн боломжийг харуулдаг (3А бүлгийг үзнэ үү):

- ➔ Залуучуудыг дайчлах, бүх түвшинд шийдвэр гаргахад тэдний оролцоог хангах, хамтран ажиллах хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, зөвлөлдөхөд чиглэгдсэн залуучуудын оролцооны бүтэц
- ➔ Залуучуудын оролцоог хангахуйц аюулгүй байдлыг хангах үйл явц (жишээ нь, семинар зохион байгуулах аюулгүй газар, цахим уулзалтын үеэр нэр болон холбоо барих хаягийн нууцлал г.м)
- ➔ Авлигатай тэмцэх чиглэлээр залуучууд удирддаг¹² байгууллагуудын хүртээмжтэй нөөц (жишээ нь, сайн дурын залуучуудад зориулсан унаа болон амьжиргааны зардал, залуучуудын зөвлөх болон залуучуудаар удирдуулсан санаачилгыг санхүүжүүлэх тэтгэлэг г.м)

Энэ нь залуучуудыг таатай орчин бүрдүүлэн татан оролцуулахад авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудад бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад тулгардаг дараах гурван үндсэн асуудлыг даван туулахад тусалж болохыг харуулж байна:

1. Авлигаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй тэмцэх
2. Гол оролцогч талуудтай зөв, зохистой харилцах
3. Нөөцийг үр ашигтай удирдах

¹² “Залуучууд удирддаг” гэдэг нь залуучуудад чиглэсэн насанд хүрэгчдийн удирдаж болох байгууллагуудаас ялгаатай, залуучууд удирддаг (мөн залуучуудын эзэмшдэг) байгууллагыг хэлнэ.



1. Авлигаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй тэмцэх

Бэрхшээл:

Авлигатай тэмцэх нь угаас хэцүү бөгөөд хэмжигдэхүйц үр дүнд хүрэх нь төвөгтэй зорилт билээ. Авлигын түвшнийг үнэн зөв үнэлэх нийтлэг арга байхгүй бөгөөд авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны амжилт болон ахиц дэвшлийг үнэлэх нь бүр ч хэцүү юм. Цаашлаад авлигын асуудлыг шийдэх гарцыг олоход шинэлэг сэтгэлгээ хэрэгтэй.

Залуучууд бэрхшээлийг даван туулахад хэрхэн тусалж чадах вэ:

Залуучууд авлигатай тэмцэх байгууллагуудад илүү сайн үр дүнд хүрэхэд нь тусалж чадна. Төслийн төсөл боловсруулах, бэлтгэл үе шатанд, ялангуяа төсөл нь соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, эсхүл залуучуудын чадавхыг дээшлүүлэхийг зорьсон тохиолдолд тэдний оролцоог аль болох эрт хангавал тухайн төсөл нь илүү үр дүнтэй, тогтвортой хэрэгжинэ (30-31 дүгээр хуудаснаас залуучуудыг утга төгөлдөр оролцуулах мэдээллийг харна уу). Залуучуудыг татан оролцуулах нь үйл ажиллагаагаа сайжруулахад үр өгөөжөө өгдөг. Тиймээс залуучуудыг судалгаа, мэдээлэл цуглуулах ажилд эртнээс татан оролцуулж, төслийн арга хэмжээний хариу үйлдлийг сайжруулах мэдээллийг хүртээмжтэй болгосноор хөтөлбөрийн хүрээ, чанарыг нэмэгдүүлэх боломжтой¹³. Манай судалгаагаар залуучуудтай ажиллаж буй 49 авлигатай тэмцэх байгууллагын 65 хувь нь залуучуудын оролцооны үр дүнд тэдний ажил залуучуудын сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцэх болсон гэж мэдээлжээ.

Залуучууд шинэлэг санаа гаргадаг. Хувийн хэвшлийн салбарт залуу мэргэжилтнүүд ахлах удирдах албан тушаалтандаа интернэт болон цахим орчныг бүтээлчээр ашиглах тал дээр “ментор” хийх нь нийтлэг байдаг. Авлигатай тэмцэх чиг үүрэгтэй байгууллагуудад ийм дэмжлэг үзүүлэх нь тэдний мэдлэгийн уламжлалт хүрээг тэлэхэд дэм болох ёстой. Судалгаанд хамрагдсан залуучуудтай хамтран ажилладаг авлигатай тэмцэх байгууллагуудын 65 хувь нь шинэлэг санаа, шийдлүүдийг олж авах нь залуучуудын оролцооны нэг том давуу тал гэж үзсэн байна. Үе хоорондын хэлэлцүүлэг нь залуучуудад тэдний оролцоо хэрэгтэй байх мэдрэмж төрүүлж, тэдний манлайллын чадварыг нь хөгжүүлдэг.

¹³ ADB, “Meaningful Youth Engagement in Water: Partnering with the Youth in Improving Water Security”, 29 April 2022



2. Гол оролцогч талуудтай зохих ёсоор харьцах

Бэрхшээл:

Авлигатай тэмцэх байгууллагыг ихэвчлэн авлигатай тэмцэж чадна гэх итгэл үнэмшилтэйгээр байгуулдаг бөгөөд энэ нь эргээд эрх мэдэл, бодит бус хүлээлтийг бий болгодог. Энэхүү хүнд бэрхшээлийг даван туулахын тулд авлигатай тэмцэх байгууллагууд дан ганц авлигатай амжилттай тэмцээд зогсохгүй, харин өөрсдийн ололт амжилтыг түгээх нь чухал юм. Байгууллагууд өөрсдийн хүрсэн үр дүнг дараах хоёр гол оролцогч талуудад илэрхийлж, мэдээлэх ёстой:

- ➔ Авлигатай тэмцэх байгууллагуудад хяналт тавих үүрэг бүхий дээд байгууллагууд нь тухайн байгууллагууд зорилгодоо хүрч байгаа гэдэгт итгэл дүүрэн байх ёстой (жишээ нь, бүрэн эрхээ хэрэгжүүлж, нөөцөө зохистой ашиглаж байна).
- ➔ Иргэд авлигатай тэмцэх байгууллагууд авлигыг бууруулж, улмаар иргэдийн амьдралд эерэгээр нөлөөлж амжилтад хүрч байна (жишээ нь, төрийн үйлчилгээг илүү үр дүнтэй хүргэхэд хувь нэмрээ оруулж байна) гэдгээ байгууллагуудаас нотлохыг шаарддаг.

Дээрх оролцогч талуудтай харилцаагаа бэхжүүлэх нь авлигатай тэмцэх байгууллагын хувьд илүү өргөн хүрээний дэмжлэг авахад туслах бөгөөд энэ нь байгууллагын гол зорилгодоо хүрэхэд чухал ач холбогдолтой.

Залуучууд бэрхшээлийг даван туулахад хэрхэн тусалж чадах

ВЭ:

Залуучууд авлигатай тэмцэх байгууллагад уламжлалт байдлаар хандахад хүндрэлтэй байдаг залуучуудын бүлгэмийн давуу талыг ойлгоход тусалж чадна. Залуучуудын хэрэгцээ, сонирхлын талаар мэдэж байх нь байгууллагын хөтөлбөрт хамаарах бүрэлдэхүүн хэсгийн асуудлыг шийдвэрлэхэд нь тусалж чадна. Хязгаарлагдмал нөөц бололцоотой авлигатай тэмцэх байгууллагын хувьд шийдвэрлэх асуудлынхаа эрэмбийг ухаалгаар тогтоох нь чухал бөгөөд уг бэрхшээлийг залуучуудын тусламжтайгаар даван туулах боломжтой.

Залуучууд авлигатай тэмцэх байгууллагын ололт амжилтыг үе тэнгийнхэндээ хүргэхэд тусалж чадна. Залуучуудыг татан оролцуулах нь авлигатай тэмцэх байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон залуучуудад ээлтэй хэв маяг, мэдээллээр дамжуулан тэдгээрт хүргэх чадварыг нэмэгдүүлдэг. Залуучууд мэдээллийг илүү өргөн хүрээнд түгээж чадна. Шударга ёс, ёс суртахууны талаарх эерэг мессежийг хуваалцах, мөн авлигын нийгмийн хор аюул бүхий “хүн бүр хийдэг” гэх үзэл хандлагыг өөрчлөх



байдлаар залуучуудын оролцооны ач холбогдол илэрхийлэгддэг. Залуучуудын дуу хоолойг нэмэгдүүлэх нь олон нийтэд хувь нэмрээ оруулах, албан болон албан бус байгууллагын чадавхыг бэхжүүлэх, залуучуудыг хорт үр дагавартай, хууль бус үйл ажиллагаанд оролцохоос сэргийлж, тэдний оролцоог өргөн хүрээнд нэмэгдүүлэх боломжтой. Үе тэнгийнхэндээ нөлөөлөх нь үнэхээр хүчирхэг чадвар юм. Үүнээс гадна ах дүү, эцэг эх, гэр бүл, олон нийтийн бусад гишүүдийг сурган хүмүүжүүлэх, тэднийг дайчлахад ч залуучууд чухал үүрэг гүйцэтгэдэг¹⁴.

Олонх залуучууд хүсэл эрмэлзэл, харилцах ур чадвартай хүмүүс байдаг. Залуучуудын харилцааны чадвар, шийдлээ нээлттэй хуваалцах байдал, асуулт асууж, мэдлэгээ түгээхэд бэлэн байдаг нь авлигатай тэмцэх байгууллагын хувьд ашиглаж болох чухал давуу тал юм. Манай судалгаагаар залуучуудтай хамтран ажилладаг 49 авлигатай тэмцэх байгууллагын 78 хувь нь залуучуудын оролцоог хангасан хөтөлбөрийн хамгийн чухал давуу тал нь олон нийт тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагааг илүү сайн мэддэг болсон явдал гэж үзжээ.

Авлигын эсрэг олон нийтийн хандлагыг бүхэлд нь өөрчилж байж авлигатай бодитойгоор тэмцэх боломжтой. Тиймээс залуучуудыг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд татан оролцуулах нь өөрөө чухал үр дүн юм. Авлигатай тэмцэх байгууллага залуучуудтай хамтран ажиллаж буй гол туршлага нь ирээдүйд авлигатай амжилттайгаар тэмцэхэд залуучууд чухал үүрэг гүйцэтгэнэ гэх итгэл үнэмшил юм. Эерэг үр дүн гаргах эсэх нь залуучуудын эрдэм боловсрол хийгээд авлигатай тэмцэх байгууллагад дадлагажих, эсхүл үүнтэй төстэй бусад идэвх санаачилгаас шалтгаална. Залуучууд эерэг өөрчлөлтийг авчрахад идэвхтэй оролцох үед тэдэнд бий болсон ур чадвар, үнэт зүйлс нь иргэний нийгмийн байгууллагад (залуучууд удирддаг, эсхүл залуучуудад чиглэсэн байгууллагуудыг хамааруулан) гол үүрэг гүйцэтгэж, улмаар насанд хүрсэн хойноо улс төр, нийгэм, шашин шүтлэг, соёлын салбарт удирдах албан тушаалыг хаших үед ч үргэлжилдэг. Түүнчлэн залуучуудын үр дүнтэй оролцоо нь тэдгээрийг чадавхжуулдаг. Авлигын эсрэг санаачилгад үр дүнтэй оролцож буй залуучууд идэвхтэй иргэн болж, засаглал, болон хөгжилд бодитой хувь нэмэр оруулах ур чадвар, нөөц, нийгмийн капиталаар хангагдах тал дээр тодорхой дэмжлэгийг олж авдаг. Манай судалгаагаар залуучуудтай хамтран ажилладаг 49 авлигатай тэмцэх байгууллагын 71 хувь нь залуучуудыг авлигатай тэмцэх үйл ажиллагаанд татан оролцуулж улмаар залуучууд үүгээрээ олонд танигдах нь залуучуудын хувьд чухал ач холбогдолтой байсан гэж үзжээ.

Залуучуудын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр авлигатай тэмцэх байгууллагыг үндэсний болон олон улсын хэмжээнд эерэг сурталчлах боломжийг олгодог. Залуучуудтай идэвхтэй хамтран ажиллаж буй байгууллага

¹⁴ Youth Power 2, "Peer Mobilizers", 13 December 2021.



нь залуучуудыг татан оролцуулах үндэсний болон олон улсын хүчин чармайлтад ч хувь нэмрээ оруулахад тусалдаг. Үүний үр өгөөжийг сайн таньсны үр дүнд эдүгээ олон улсын засгийн газар болон байгууллага нь залуучуудыг үр дүнтэй оролцуулахыг эрэлхийлж байна. Залуучуудыг татан оролцуулснаар авлигатай тэмцэх байгууллагууд үндэсний болон олон улсын хэмжээнд гүйцэтгэх засгийн газрын үүрэг, амлалтыг дэмжиж буйгаа илэрхийлдэг (жишээ нь, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн нийгмийн оролцооны тухай 13 дугаар зүйлийг дагаж мөрдөх, Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх, залуучуудын хөгжлийн талаарх үндэсний зорилтууд, эсхүл Залуучууд 2030: НҮБ-ын Залуучуудын стратеги гэх мэт олон улсын зорилтуудыг биелүүлэх.)¹⁵

3. Нөөцийг ур ашигтай удирдах

Бэрхшээл:

Авлигатай тэмцэх олон байгууллага санхүү, боловсон хүчин, техникийн нөөцөөр ихээхэн дутагддаг. Тэдний төсөв болон чадавх нь гүйцэтгэх үүрэгтэй нь ихэвчлэн тохирдоггүй бөгөөд ихэнх тохиолдолд улс орон, нутаг дэвсгэрийн хэмжээнд авлигатай тэмцэх ажлыг удирдан чиглүүлэхэд асар их хөрөнгө мөнгө шаарддаг ажил юм. Энэ нь ялангуяа авлигатай тэмцэх байгууллага нь бага нөөцөөр авлигын өндөр түвшинтэй тэмцэж буй хөгжиж орнуудад хамаатай.

Залуучууд бэрхшээлийг даван туулахад хэрхэн тусалж чадах

ВЭ:


Залуучуудтай хамтран ажиллах нь авлигатай тэмцэх байгууллагын нөөцөд үнэтэй хувь нэмэр болж чаддаг. Залуучууд зохих ёсоор ажиллаж чадвал авлигатай тэмцэх албаны хүнд ачааллыг үүрч, авлигатай тэмцэхэд хөшүүрэг болох үр дүнтэй хамтрагч болж чадна. Залуучуудын үр дүнтэй оролцоо нь авлигатай тэмцэх байгууллагаас ихээхэн хүчин чармайлт, төсөв шаарддаг төдийгүй залуучуудад санхүүгийн болон захиргааны хангалттай дэмжлэг, тохирсон урамшуулал хэрэгтэй байдаг. Гэсэн хэдий ч сайн харилцаа нь залуучуудын эерэг хувь нэмэр тэдний оролцооны зардлаас илүү их ашиг тустай байх нөхцөлийг бүрдүүлдэг.

¹⁵ United Nations, Youth 2030: Working with and for Young People (2018).

2Б. Залуучуудын үр дүнтэй оролцоонд тулгарч буй бэрхшээл ба боломж

Залуучуудын үр дүнтэй оролцоонд тулгарч буй саад бэрхшээл

Авлигатай тэмцэх байгууллага залуучуудын оролцоог үндсэн үйл ажиллагаагаа болгон хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын болон практикийн асуудлуудтай тулгардаг. Судалгаанд хамрагдсан авлигатай тэмцэх байгууллагуудын тодорхойлсон хамгийн нийтлэг саад бэрхшээлийг доор харуулж байна.



Залуучуудыг татан оролцуулж буй авлигатай тэмцэх 49 байгууллагын өгсөн хариултыг энэ чиглэлээр ажилласан туршлагагүй авлигатай тэмцэх 18 байгууллагын хариулттай харьцуулбал сонирхолтой зүйл ажиглагдсан. Хариултууд нь хамгийн нийтлэг саад бэрхшээлийн хувьд залуучуудын мэдлэг болон авлигатай тэмцэх байгууллагын зохион байгуулалтын бэлэн байдлын талаар санал нэгдэж байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч залуучуудын оролцоог ханган ажиллаж байсан туршлагатай авлигатай тэмцэх байгууллагууд өөрсдийн бэлэн байдал болон таатай орчинтой холбоотой саад бэрхшээлд илүү төвлөрч, бусад хувилбаруудыг ч (залуучуудын оролцоог хангадаггүй авлигатай тэмцэх байгууллагуудын сонгосон 3 хувилбараас дунджаар 25 хувилбараас 6-г нь) сонгосон байна. Энэ нь авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудтай хамтран ажиллахад мэргэших шаардлагатай байгааг харуулж байна.



Залуучууд ч мөн дээрх дүгнэлттэй санал нэг байдаг. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт залуу мэргэжилтнүүд авлигатай тэмцэх байгууллагын ажлын нууцлал, мөн тухайн байгууллагын ихэнх ажилд өндөр чадвар шаарддаг байдал нь хөндлөнгийн этгээд, тэр дундаа залуучуудыг татан оролцуулахад хүндрэлтэй байдаг гэж дурджээ. Түүнчлэн эрх мэдэл, төсөв, өрсөлдөх чадвар болон бусад ур чадвар дутмаг байгаа нь залуучуудтай хамтрахад гол асуудал нь болдог.

Эцэст нь, мэргэжлийн дүн шинжилгээ, ярилцлага, тусгай бүлгийн хүрээнд гаргасан дүгнэлтэд дараах нэмэлт бэрхшээлүүдийг тодорхойлсон байна:

- ➔ Зөвхөн санхүүгийн эх үүсвэр болон/эсхүл нийгэм-улс төрийн хүрээнд танил талтай “элит” залуучуудыг татан оролцуулж, улмаар бусад нийгмийн эмзэг бүлгүүдийн залуучуудыг оролцуулдаггүй байх эрсдэлтэй
- ➔ Авлигатай тэмцэх ажил нь залуучуудаас хамаардаггүй байх бэрхшээл
- ➔ Үр дүнтэй оролцооноос илүү бэлгэдлийн шинжтэй залуучуудын оролцооны практик
- ➔ Залуучуудын дунд авлигатай тэмцэх техникийн ур чадвар, туршлага дутмаг гэсэн сөрөг ойлголт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх байгууллага нь:

1. Залуучуудын оролцоог эрэлхийлэх тодорхой үндэслэлийг бий болгох, үүнд энэ нь тэдний бодлогын зорилтуудтай хэрхэн нийцэж байгааг багтаах;
2. Залуучуудыг татан оролцуулах тал дээр эвлэлдэн нэгдэхэд анхаарч ажиллах.

Дээрх алхмууд нь байгууллагуудад залуучуудыг татан оролцуулахтай холбоотой хүндрэл бэрхшээлийг даван туулахад тусалж, чухал үр дүнг бий болгох боломжтой.



Залуучуудын оролцоог үр дүнтэй болгох боломж

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын оролцоог хангах үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг болсон. Эдгээр байгууллагууд залуучуудыг ихэвчлэн ажлынхаа хүлээн авагч (ашиг хүртэгч) болгон оролцуулдаг. Манай түүврийн хүрээнд авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг мэдлэг дээшлүүлэх болон олон нийтэд хүргэх хөтөлбөр (82 хувь) болон боловсролын хөтөлбөрт (72 хувь) хамгийн их оролцдог гэж мэдээлжээ.

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг үр дүнтэй оролцуулах туршлага хэдий түгээмэл биш ч тэдний оролцоог хангах үзэл баримтлал тогтсон бөгөөд залуучуудын оролцооны талаарх ач холбогдол тодорхой байр суурь эзэлдэг болсон. Боломж нь бүрдсэн нөхцөл байдалд залуучууд чухал үүрэг гүйцэтгэж, өргөн хүрээнд үүрэг хариуцлага хүлээдэг болсон. Залуучуудын оролцооны энгийн хөтөлбөрүүд нь залуучуудын санаачилгаар тухайн хөтөлбөрийг боловсруулж, төлөвлөж, хэрэгжүүлэх байдлаар тэдний оролцоог анхнаас нь илүү өргөн хүрээнд хангадаг болсон.

Үр дүнтэй оролцох нь залуучуудын оролцоог сайжруулдаг. Авлигатай тэмцэх байгууллагын хөтөлбөрт залуучуудын оролцоог хангах (ашиг хүртэгч болгох) нь ихээхэн ач холбогдолтой. Судалгаанд хамрагдсан байгууллагууд залуучуудын оролцоог хангасны үр дүнд залуучуудын чадавх нэмэгдсэн гэж мэдээлжээ: Оролцогчдын 78 хувь нь шинэ ур чадвар эзэмшиж, 76 хувь нь одоо байгаа ур чадвараа хөгжүүлсэн байна. Залуучуудын оролцоо нь залуучуудыг авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар илүү мэдлэгтэй болгохоос гадна бусад залуучуудыг идэвхтэй оролцуулах, хамтран ажиллах, авлигатай тэмцэх цаашдын үйл ажиллагаанд манлайлах чадавхыг нэмэгдүүлж, идэвхжүүлдэг. Авлигатай тэмцэх байгууллагын залуучуудын оролцооны хөтөлбөрүүдэд залуучуудын оролцоо нь үр дүнтэй байх зарчмуудыг хэрэгжүүлэх нь тэдгээрийн үр ашигтай байдлыг улам нэмэгдүүлж, үр нөлөөг улам бэхжүүлэх болно. Залуучууд шинэ үзэл бодол, шинэ ур чадвар, урам зориг, эрч хүч, шинэлэг санааг гаргаж, өөрсдийн хэрэгцээ, сорилт бэрхшээлийн талаар илүү гүнзгий ойлголттой болдог. Аюулгүй болон бусад насны бүлгийг хамарсан, сонирхолтой, дэмжлэг өгөх орчинд залуучуудын энэхүү зохист оролцоо нь авлигатай тэмцэх байгууллагыг илүү үр дүнтэй, тогтвортой үр дүнд хүргэдэг. Залуучуудтай харилцах нь авлигатай тэмцэх байгууллагын боловсрол, ухамсар, мэдлэг олгох ажилд онцгой ач холбогдолтой болохыг судалгаагаар тогтоожээ.

Залуучуудын оролцоо нь үр дүнтэй байх зарчмуудыг хэрэгжүүлэх замаар тэдний оролцоог нэмэгдүүлэх нь авлигатай тэмцэх байгууллагын хувьд хялбар хэрэгжих боломжтой. Залуучуудтай хэдийнээ хамтран ажиллаж буй байгууллагууд залуучуудын оролцоог хангах хөтөлбөртөө их зардал гаргалгүйгээр үр дүнгээ мэдэгдэхүйц байдлаар нэмэгдүүлэх боломжтой. Нийгэмд оршиж буй авлигыг арилгахын тулд залуу төлөөлөгчдийн ур чадварыг нээн илрүүлэх нь улс орнуудын авлигатай тэмцэх байгууллагуудын хувьд нээлттэй боломж юм.



Залуучуудыг амжилттай татан оролцуулахын тулд тэдний үгийг сонсох, хэрэгцээг хангах, тэдний үеийнхний ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагааг хамтран зохион байгуулах нь чухал билээ. Үүнд боловсрол, зохистой хөдөлмөр, уур амьсгалын өөрчлөлт ба хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, сайн сайхан байх зэрэг хамаарна, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.¹⁶ Залуучуудын анхаарал хандуулж буй сэдвүүдэд нөлөө үзүүлэхийн төлөө авлигатай тэмцэх нь бусад насны бүлгэмүүдийн харилцан яриа, ойлголцлыг гүнзгийрүүлж, улмаар тухайн байгууллагад залуучуудын оролцоог бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Залуучуудын оролцоо нь НҮБ зэрэг дэлхийн олон байгууллагын хэлэлцэх асуудлын нэг болоод байна. Залуу нөлөөлөгчдийн хүчин чармайлтын дүнд засгийн газрууд залуучууд удирдан манлайлахгүй юмаа гэхэд өөрчлөлтийн нэг хэсэг нь байх чадвартайг нь хүлээн зөвшөөрсөн. Иймээс залуучуудын оролцоог олон улс орон болон бүс нутаг өөрсдийн үндэсний хөгжлийн төлөвлөгөө, эсхүл ижил төстэй бодлогын баримт бичигтээ тусгаснаар залуучуудыг татан оролцуулах ажил идэвхтэй өрнөж байна. Иймээс энэ чиглэлийн үйл ажиллагаа нь авлигатай тэмцэх байгууллагуудад салбараасаа гадуур ажиллах боломж олгодог. Үүнд дараахь зүйлс хамаарна, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:

- ➔ Олон нийтэд эерэг нөлөө үзүүлэх: Арга хэмжээ, уулзалт, үндэсний болон олон улсын кампанит ажлаар дамжуулан явуулна.
- ➔ Санхүүгийн болон техникийн дэмжлэг: Залуучуудын үүрэг, оролцоог бэхжүүлэхтэй холбоотой төсөл, санхүүжилтийн боломжоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- ➔ Гадны байгууллага болон улс төрийн дэмжлэг: Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэсний болон олон улсын тэргүүлэх зорилтуудтай уялдуулах замаар (2А бүлгээс үзнэ үү) зохион байгуулна.
- ➔ Эрхэм зорилгодоо хүрэхэд олон нийтийн дэмжлэг чухал: Ил тод болон хариуцлагатай байх нь авлигатай тэмцэх үндсэн зарчим юм. Авлигатай тэмцэх байгууллага залуучуудтай хамтран ажиллахдаа олон нийтийг үр дүнтэй оролцуулж, авлигыг эсрэг тэмцлийг иргэдэд хамааралтай асуудалтай холбож, авлигатай тэмцэх ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэхэд залуучуудыг идэвхтэй оролцуулснаар иргэдийнхээ өмнө илүү хариуцлагатай болж чадна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Залуучуудын үр дүнтэй оролцоог хангахын тулд авлигатай тэмцэх байгууллага авлигатай тэмцэх хөтөлбөрөө залуучуудад ашигтай байх тал руу нь (эсхүл тэднийг оролцогч мэт авч үзэн) чиглүүлэх ёстой.

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучууд руу чиглэж, авлигатай тэмцэх хөтөлбөрөө боловсруулахдаа энэ нь тухайн байгууллага болон залуучуудад ямар ач тус авчрах вэ гэдэгт үндэслэх ёстой. Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын оролцооны ач холбогдлыг тодорхойлсноор үр дүнтэй, бүтээмжтэй хэрэгжилтийг хангаж, хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд утга төгөлдөр залуусын оролцооны зарчмыг баримтлах ёстой.

¹⁶ NielsenIQ, Global Youth survey report (2022); PwC, "The Global Youth Outlook: A voice for youth action on the Sustainable Development Goals"; United Nations, "Global Issues – Youth"; International Labour Organization, "Decent Work".

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГУУД ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАН АЖИЛЛАДАГ ТАЛААРХ ЖИШЭЭ



*Бутан дахь “Шударга байдлын клубийн гишүүд
утга зохиолын үйл ажиллагаанд оролцдог*

Бутан Улсын Авлигатай тэмцэх хороо нь Үндэсний шударга байдал болон Авлигатай тэмцэх бодлогын хүрээнд 3-24 насны хүүхэд, залуучуудад чиглэсэн цуврал үйл ажиллагаанд **Залуучуудын шударга байдлын бодлогын хөтөлбөрийг** хэрэгжүүлжээ.

Уг хөтөлбөрт шударга байдлын клуб, сургалтын хөтөлбөр мөн сургуулийн албан ёсны хөтөлбөрт хамрагдах багш болон салбарын сургалтууд орно. Үүний үр дүнд шударга байдлын боловсролын хөтөлбөрийг боловсруулдаг. Шударга байдлын клубүүд нь залуучуудыг нэгтгэж, олон нийтэд мэдээлэл болон нөлөөллийн кампанит ажил өрнүүлдэг. Мөн уг хөтөлбөр нь залуучуудад байгаль орчноо хайрлан хамгаалах хандлагыг бий болгоход чиглэгдсэн бөгөөд ойн аж ахуй, уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжлийн ёс зүйн талаар хүртээмжтэй сургалтыг явуулдаг. Уг хөтөлбөр нь хичээлээс гадуурх хөтөлбөрүүдээс бүрдэж, хөдөлмөр эрхэлдэг болон хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудад ч нээлттэй байдаг.


Авлигатай тэмцэх
болон шударга байдлын
талаарх лекц хичээл



Хэлэлцүүлэг Уулзалт



Бүлгийн
хэлэлцүүлэг



Илтгэл

Бруней Даруссалам авлигаас урьдчилан сэргийлэх талаар үндэсний сургалтын хөтөлбөрт тусгаж, залуучуудыг дадлагажуулах ажлыг зохион байгуулдаг

Бруней Даруссалам Улсын хүн амын 55 хувь нь 15-40 насныхан байдаг тул Брунейн Засгийн газар Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу авлига, гэмт хэргийн хор уршгийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор залуучуудад зориулсан цуврал хөтөлбөрүүдийг боловсруулж, ёс суртахууны нийтлэг үнэт зүйлсийг залуу үеийнхэнд төлөвшүүлэхийг зорьжээ.

2006 оноос эхлэн үндэсний сургалтын хөтөлбөрт авлигаас урьдчилан сэргийлэх агуулгыг оруулсан. Залуучуудад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхийн хүрээнд Бруней Даруссалам Улсын Авлигатай тэмцэх Товчоо (АТТ) **дадлага хийх** тогтолцоог бүрдүүлсэн. Энэхүү дадлага нь төрөл бүрийн боловсролын түвшний оюутнуудад нээлттэй бөгөөд үндсэн зорилго нь авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдлэг олгох, мэдээллийн технологи, харилцаа холбоо, АТТ-ны боловсролын санаачилгыг дэмжих явдал юм. Дадлагыг эхлүүлэхээс өмнө оролцогчдыг АТТ-ны ажлын орчин, дадлагатай танилцах сургалтад хамруулдаг. Нэмж дурдахад оролцогчид өөрсдийн сонгосон сурах арга барилаа илэрхийлж, дадлагын хугацаа дуусахад хүрэхийг зорьсон түвшин болон үр дүнг тоймлох боломжийг тэдэнд олгодог. Амжилттай төгссөний дараа оролцогчдод төгсөлтийн гэрчилгээ олгож, их сургуулиас дадлагын гүйцэтгэлийн чанарыг оноогоор үнэлдэг.



Кени Улсын залуучууд хөгжим болон жүжгээр дамжуулан авлигатай тэмцэх урам зоригийг авч байна

Кени Улсын залуучуудад чиглэсэн олон нийтийн боловсролын хөтөлбөрүүдийн дунд Ёс зүй, авлигатай тэмцэх хороо (ЁЗАТХ) нь жил бүр болдог Кенийн Үндэсний Драм, Кино Наадам (КҮДКН) болон **Кенийн Үндэсний Хөгжмийн Наадмын** (КҮХН) үеэр шударга байдлыг сурталчлах үйл ажиллагааг ивээн тэтгэж, оролцжээ.

Эдгээр нь Кени Улсын Боловсролын яамнаас жил бүр зохион байгуулдаг арга хэмжээ юм. КҮХН-ын арга хэмжээнд улс орны өнцөг булан бүрээс болон бүх шатны боловсролын (сургуулийн өмнөх, бага, дунд сургууль, Багшийн дээд сургууль, Техникийн сургалтын байгууллага, их дээд сургуулиуд) хоёр сая гаруй суралцагч хамрагддаг.

ЁЗАТХ нь үндэсний их баяр наадмын дэд сэдэв болох авлигатай тэмцэх чиглэлээр үндсэн оролцогч талын хувиар ивээн тэтгэж, оролцдог. Авлигатай тэмцэх дэд сэдвийн хүрээнд дуу, жүжиг, хүүрнэл зохиол, кино, бүжгээр илэрхийлсэн ёс зүй, авлигын эсрэг агуулгыг бий болгохын тулд залуучууд өөрсдийн авьяас чадвар, бүтээлч байдлаа ашигладаг. Жүжиг, кино болон хөгжмийн уралдаан нь дөрвөн түвшинд (харьяа муж, муж, бүс нутаг, улсын түвшинд) явагддаг. Авлигатай тэмцэх зэрэг төрөл бүрийн сэдвээр шалгарсан багууд нь олон нийтийн төлөөлөл оролцсон гала арга хэмжээ, улсын дээд удирдлага болон бусад төрийн албан хаагчдыг хамруулсан Төрийн концертод өөрсдийн үзүүлбэрийг толилуулах боломжтой. Сонгогдсон үзүүлбэр нь Кенийн Боловсролын хүрээлэнгийн телевизийн суваг болох Edu Channel-ээр цацагддаг.



Залуу төлөөлөгчид 2022 онд Малайз Улсад болсон Авлигатай тэмцэх Оюутны Нэгдлийн Хэлэлцээрт хамтран ажиллаж байна

Малайзын Авлигатай тэмцэх хороо (МАТХ) **Авлигатай тэмцэх Оюутны Нэгдлийг** (АТОН) байгуулснаар боловсролын систем болон залуучуудын идэвх хоорондын холбоог бий болгожээ.

АТОН нь боловсролын байгууллагуудтай хамтран ажиллаж, их, дээд сургуулиудад авлигатай тэмцэх хөдөлгөөнийг манлайлах залуучуудыг элсүүлсэн. АТОН нь сургуулийнхаа хүрээнд болон сургуулиас гадуур кампанит ажил явуулахаас эхлүүлэн бодлогын хэмжээнд нөлөөлөх түвшинд үйл ажиллагаа явуулдаг авлигатай тэмцэх бүлгүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлжээ.

Залуучуудын тэргүүлэх эдгээр бүлгүүд нь авлига хүмүүс болон нийгэмд хэрхэн хор хөнөөл учруулдаг, түүнтэй хэрхэн тэмцэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх төслүүдийг боловсруулдаг. Уг төслүүд нь сургуулийн захирал болон МАТХ-ны нарийн хяналт дор хэрэгждэг.

Нэг жил үргэлжлэх уг төслүүдийн явцад МАТХ нь байгууллагын боловсролын тогтолцоотой нийцсэн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг өргөн хүрээнд хэрэгжүүлдэг. Төсөл хэрэгжиж дууссаны дараа МАТХ-ны ажилтнууд төсөл зорилгодоо хүрсэн эсэхэд дүгнэлт хийж, үнэлгээ өгдөг. Төсөл хэрэгжиж дууссаны дараа оролцогчид ирээдүйн АТОН-ийн гишүүдэд ментор хийх урам зориг орсон байдаг.



Залуу Молдавчууд Авлигын эсрэг сайн дурынхны уулзалтын үеэр баг бүрдүүлэх ажилд оролцож байна

Авлигатай тэмцэх сайн дурын ажилтнууд нь авлигын эсрэг санаачилгыг олон нийтэд сурталчлах, төрийн байгууллагын хүчин чармайлтыг дэмжих зорилготой билээ. Молдав даяарх төрийн байгууллагуудад залуу сайн дурынхныг татан оролцуулах ажлыг анхлан эхлүүлж, Авлигатай тэмцэх үндэсний төв нь боловсролын байгууллагуудад залуучуудыг татан оролцуулахад анхаарч, Боловсролын яамтай хамтран төслийг санаачлан хэрэгжүүлжээ.

Цахимаар элсэлтийн бүртгэл хийх явцад зуу гаруй хүсэл тэмүүлээр дүүрэн залуус сайн дурын ажилтнаар бүртгүүлсэн. Бүртгүүлсний дараа нэр дэвшигчдийг нарийн сонголт, ярилцлага хийх замаар шалгаруулж, хамгийн тохиромжтой гэх хүмүүсийг сонгосон эсэхээ нягталдаг. Оролцогчид шалгарсны дараа өөрсдийн сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг тогтоох эрхтэй бөгөөд өдөр тутмын зардлаар хангагддаг.

Эдгээр залуу сайн дурын ажилтнууд нь олон нийтийн оролцоо, судалгаа, мэдээлэл цуглуулах, кампанит ажлын санаачилга гэх гурван үндсэн чиглэлээр үүрэг хариуцлага хүлээдэг. Тухайлбал, авлигатай тэмцэх тухай театрчилсан тоглолт, комик болон хүүхэлдэйн киногоор дамжуулан авлигын эсрэг мэдээлэл солилцох нь олны анхаарлыг татсан үйл ажиллагаа болсон юм. Сайн дурын хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа оролцогчдын оруулсан хувь нэмрийг үнэлж гэрчилгээ болон шагнал олгодог.

Эдгээр жишээнүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү бодлогын гарын авлагын вэб порталаас дээрээс үзэж болно.





3

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
БАЙГУУЛЛАГУУД ҮЙЛ
АЖИЛЛАГААНДАА ЗАЛУУЧУУДЫГ
ХЭРХЭН ҮР ДҮНТЭЙ ТАТАН
ОРОЛЦУУЛАХ ВЭ?





Гуравдугаар бүлэг: Авлигатай тэмцэх байгууллагууд үйл ажиллагаандаа залуучуудыг хэрхэн үр дүнтэй татан оролцуулах вэ?

Бүлгийн агуулга

Чиглүүлэх асуулт:

- ➔ Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг үр дүнтэй оролцуулах таатай орчин бүрдүүлдэг үү?
- ➔ Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын үр дүнтэй оролцоог хангах ажлыг хэрхэн зохион байгуулдаг вэ?

Гол санаа:

- ➔ Залуучуудын оролцоог хангах чиглэлээр гаргаж буй хүчин чармайлтаа эхлүүлэх, сайжруулах сонирхолтой Авлигатай тэмцэх байгууллагууд 3 үе шаттайгаар зохион байгуулдаг.
 1. Залуучуудын үр дүнтэй оролцоог хангах арга хэмжээг зохион байгуулахад байгууллагын бэлэн байдлыг хангах (Бүлэг 3А)
 2. Залуучуудыг оролцоог хангах арга хэмжээнүүдийг үйл ажиллагааны түвшинд хөгжүүлэх (Бүлэг 3Б)
 3. Залуучуудын үр дүнтэй оролцоог сайжруулах болон тасралтгүй суралцах талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг хянаж, үнэлж байх (Бүлэг 3В)



3А. Зохион байгуулалтын түвшин: Байгууллагын бэлэн байдлыг хангах нь

1.Бэлэн байдлын бүрэлдэхүүн хэсгүүд: Байгууллагын чадавхын хүчин зүйлс

Залуучуудын үр дүнтэй оролцоог амжилттай хангахын тулд тухайн байгууллагын хүний нөөцийн чадавх, зохион байгуулалтын бүтэц, бодлого болон үйл явц, мөн орчин нь тодорхой нөхцөлийг хангасан байх ёстой. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн нөхцөл байдлын болон чанарын үзүүлэлтийг “байгууллагын чадавхын хүчин зүйлс” гэж нэрлэх бөгөөд залуучуудыг үр дүнтэй татан оролцуулахад байгууллагын бэлэн байдлыг тодорхойлдог.

Байгууллагын чадавхыг тодорхойлдог 13 хүчин зүйлсийг тоймлон 5 үндсэн санааны хүрээнд дараагийн хуудасны 3 дахь хүснэгтэд харуулав. Хэдийгээр энэхүү жагсаалт нь бүх санааг багтаагаагүй ч гэсэн залуучуудыг үр дүнтэй оролцуулах хүчин зүйлсээ тодорхойлох замаар өөрсдийн чадавх болон туршлагаа сайжруулахад авлигатай тэмцэх байгууллагуудад арга зүйн чиглэл болдог¹⁷. Залуучуудын оролцоог хангахдаа залуучуудыг үр дүнтэй оролцуулах зорилгын хүрээнд тэдгээрийн аюулгүй байдлыг хангасан орон нутгийн оролцооны орчинд зохион байгуулах ёстой.

¹⁷ Институтийн чадавхыг тодорхойлдог 13 хүчин зүйлсийн дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт II-оос харна уу.





Хүснэгт 3: Залуучуудыг үр дүнтэй оролцуулах байгууллагын бэлэн байдлын бүрэлдэхүүн хэсгүүд: Байгууллагын чадавхыг тодорхойлох хүчин зүйлс

Залуучуудын үр дүнтэй оролцооны үндсэн санаа	Байгууллагын чадавхыг тодорхойлох хүчин зүйлс	Зорилтууд
Ялгаатай байдал ба тэгш оролцоо	1. Оролцогч талуудын дүн шинжилгээ 2. Оролцооны төлөвлөгөө	Залуучуудын бүлгүүд, тэр дундаа оролцоо нь хангагдахгүй байгаа нийгмийн эмзэг бүлгүүдийг тодорхойлж, тэдний үзэл бодол болон оролцоход саад болж буй бэрхшээлийг ойлгох. “итгэл хүлээхүйц” залуучуудын институцийн сүлжээ болон эмзэг бүлгүүдийн залуучуудын төлөөллийн багийг бий болгох.
Оролцоог хангах таатай орчин	3.Залуучуудын оролцоог дэмжихэд зориулсан санхүүжилт 4.Залуучуудын оролцооны гэрээ байгуулах албан ёсны механизмууд 5.Залуучуудыг үр дүнтэй оролцуулах үйл явцын талаарх ажилтнуудын мэдлэг 6.Залуучуудын аюулгүй байдлыг хангах	Авлигатай тэмцэх байгууллагуудын залуучуудыг үр дүнтэй оролцуулах хүчин чармайлтыг дэмжиж, тогтвортой байлгах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх; Байгууллагын худалдан авалт, түншлэлийн механизмуудыг залуучуудад ээлтэй болгох; Залуучуудын үр дүнтэй оролцоог дэмжихийн тулд хангалттай нөөц (санхүүгийн болон хүний нөөц)-ийг хуваарилж, залуучуудад ээлтэй нягтлан бодох бүртгэлийн зохих тогтолцоог бүрдүүлэх; мөн залуучуудыг үр дүнтэй оролцуулах талаар авлигатай тэмцэх байгууллагын ажилтнуудад үнэлгээг хийж, сургалт зохион байгуулах; Ялгаварлан гадуурхалгүйгээр залуучуудыг оролцуулах болон асуудлыг нухацтай авч үзэх аюулгүй орчинг бүрдүүлэх;
Үе хоорондын хамтын ажиллагаа (түншлэл)	7.Авлигатай тэмцэх байгууллага-залуучуудын хамтын ажиллагааны төлөвлөгөө	Авлигатай тэмцэх байгууллага болон залуучуудын оролцооны үр өгөөжийг хангах, нэгдсэн зорилгод хүрэх, нөөц, сүлжээг ашиглах, хоёр талын бусад хувь нэмрийг хөшүүрэг болгохын тулд хамтын үнэт зүйлд суурилсан түншлэлийг бий болгох.
Залуучуудын оролцооны чанар	8.Залуучуудын хөдөлгөөн 9.Залуучуудын оролцооны бүтэц 10.Залуучуудад ээлтэй материал, чадавхыг дэмжих	Залуучууд зөвхөн авлигын эсрэг арга хэмжээг идэвхгүй хүлээн авахаас илүүтэйгээр чанартай оролцох боломжийг бүрдүүлж, туршлага, чадвараа харгалзан юу хийж чадах талаар бодит ойлголттойгоор үүнийг тэнцвэржүүлэх. Төлөвлөх, загвар гаргах, хэрэгжүүлэх зэрэг тодорхой үүрэгтэйгээр залуусыг сайн дурын ажилтан, дадлагажигч, хамтрагч болон манлайлагч байдлаар авлигын эсрэг үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг зохион байгуулах; Залуучуудыг тогтмол уулзах, тасралтгүй оролцуулж байх (залуусын зөвлөлдөх, эсхүл зөвлөх бүлэг г.м) тогтсон бүтцийг бий болгох.
Залуучуудыг чадавхжуулах	11.Залуучуудын чадавхыг бэхжүүлэх 12.Залуучуудын (урвуу) зөвлөх хөтөлбөр ^a 13.Залуучуудын оролцооны асуудлаар мэргэшсэн насанд хүрэгчдийн баг	Залуучуудад хувь хүний хөгжил (залуу мэргэжлийн боловсон хүчин, дадлагажигч, сайн дурын ажилтан г.м)-ийг дэмжих болон тэдний нийгэмдээ өөрчлөлт хийхэд нөлөөлөх чадварыг хөгжүүлэх боломжоор хангах. Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудтай хамтран хэрэгжүүлсэн ажил, залуучуудын гаргасан ололт амжилтыг үнэлж, алдаршуулан, авлигатай тэмцэх өргөн хүрээний байгууллага, залуучуудын нийгэмлэгт түгээж, онцолсон байх. Авлигатай тэмцэх газрын насанд хүрсэн ажилтнууд залуучуудыг бүтээлчээр татан оролцуулах үр чадвартай байх.

^a (Залуучуудын урвуу харилцаа) Менторын хөтөлбөр нь залуу үеийн хамтран ажиллагч, эсхүл гадны залуучуудын хамтрагч нь хэн нэгэн ахлахад зөвлөдөг зөвлөх хөтөлбөр юм. Ийм маягаар залуучууд ахлах ажилтнуудад өгөх зүйлтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх зөвлөн туслах урвуу харилцаа юм.



Байгууллагын чадавхын хүчин зүйлс тус бүрийн мөн чанар, ач холбогдол нь тэдгээрийн нөхцөл байдлын орчин, тухайлбал, авлигатай тэмцэх байгууллагын цар хүрээ болон үйл ажиллагаанаас хамаарна. Авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудыг татан оролцуулах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнөх байгууллагын чадавхын хүчин зүйлсийг бүрдүүлсэн эсэх нь чухал шаардлагатай асуудал биш юм. Гэсэн хэдий ч авлигатай тэмцэх байгууллагууд нь байгууллагын бэлэн байдлыг хангахад гурван үндсэн асуудалд онцгойлон анхаарвал зохино. Үүнд:



Залуучуудын оролцоог дэмжихэд зориулсан санхүүжилт (Байгууллагын чадавхыг тодорхойлох хүчин зүйлс-3) захиргааны зардлын үр дүнтэй, уян хатан тогтолцоог бүрдүүлэх болон шаардагдах санхүүжилтээр хангах.



Залуучуудын аюулгүй байдлыг хангах (Байгууллагын чадавхыг тодорхойлох хүчин зүйлс-6) Залуучуудын оролцоог хангах аюулгүй, хүндэтгэл хүлээсэн, хүртээмжтэй орчныг бий болгох зохистой үйл явцыг бүрдүүлэх;



Залуусын оролцоог хангах бүтэц (Байгууллагын чадавхыг тодорхойлох хүчин зүйлс-9) нь авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын оролцоог хангах үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө байгууллагад шаардлагатай наад захын арга хэрэгслийг олж авахад чиглэсэн залуучуудын оролцоог шийдвэр гаргах бүхий л түвшинд хангах болон түнш болон хамтрагч талын хувьд урьдчилан яриа хэлэлцээг хийх, зөвлөлдөх замаар залуучуудыг татан оролцуулах бүтэц

Байгууллагын чадавхыг тодорхойлох дээрх 3 хүчин зүйлс нь урьдчилсан нөхцөл гэж тооцогддог бөгөөд авлигатай тэмцэх байгууллагууд залуусыг үр дүнтэй оролцуулах үйл ажлаа эхлүүлэхийн өмнө эдгээр нөхцөлийг хангасан байх ёстой гэсэн үг юм.



2. Байгууллагын бэлэн байдлын үнэлгээ

Залуучуудыг үр дүнтэй оролцуулах зарчмын хүрээнд залуучуудыг татан оролцуулах, оролцоог сайжруулах талаар тодорхой төлөвлөгөө гаргасан байх хэрэгтэй. Залуусын оролцоог энэхүү аргачлалын дагуу эхнээс нь хангах нь авлигатай тэмцэх байгууллагуудад ихээхэн нэмэртэй. Эхний үед байгууллагууд залуучуудыг үр дүнтэй оролцуулах сайн туршлагын хувьд зарим асуудлаар дутагдалтай тал байж магадгүй. Гэсэн хэдий ч ихэнх тохиолдолд тэд залуучуудын оролцоог тодорхой хэмжээнд хангах боломжтой байх бөгөөд уг үйл ажиллагаанд нь үр өгөөжөө өгөх болно.

Залуучуудын оролцооны төлөвлөгөөг тодорхойлсны дараа авлигатай тэмцэх байгууллагууд өөрсдийн дотоод механизм, боловсон хүчний чадавх болон залуучуудыг үр дүнтэй оролцуулах туршлагыг үнэлэх хэрэгтэй. Байгууллагын бэлэн байдлын үнэлгээнд байгууллагын чадавхыг тодорхойлох хүчин зүйлсийг доор харуулсан загварын дагуу хянан үзэх шаардлагатай. Үүнд:





Байгууллагын бэлэн байдлын үнэлгээ нь хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Алхам 1: Байгууллагын бэлэн байдлын суурь нөхцөлийг хангах - Байгууллагын чадавхыг тодорхойлогч 3 үндсэн хүчин зүйлс (урьдчилсан нөхцөл)-ийг нягталж үзэж, шаардлагатай тохиолдолд залуучуудын оролцоог хангах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө эдгээр хүчин зүйлсийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хамгийн бага түвшинд нь хангасан байхыг шаардана.

Алхам 2: Байгууллагын бэлэн байдлыг үнэлэх - Байгууллагын чадавхыг тодорхойлогч бүх 13 хүчин зүйлсийг нягталж үзэх. Энэхүү аргачлалын дагуу ажилласны үр дүнд залуучуудыг үр дүнтэй оролцуулахад авлигатай тэмцэх байгууллагын бэлэн байдал болон ерөнхий чадавхыг бүхэлд нь үнэлэх юм. Байгууллагын чадавхыг тодорхойлдог 13 хүчин зүйлсийг тус бүрд үнэлэх болон авлигатай тэмцэх байгууллагуудын хүрэх үр дүнгийн талаар тусгайлсан зааварчилгааг энэхүү бодлогын [гарын авлагын вэб порталд](#) байрлуулсан болно.

Авлигатай тэмцэх байгууллагууд нь байгууллагын чадавхыг тодорхойлогч хүчин зүйлсийн жагсаалт болон шаардлагын түвшинг хоёуланг нь орон нутгийнхаа нөхцөл байдалд тохируулан өөрчлөн боловсруулах шаардлагатай. Ингэхдээ, залуучуудыг татан оролцуулахад хялбар, төвөгтэй байдлыг тодорхойлж болох гадаад хүчин зүйлс (залуучуудын тэргүүлдэг иргэний нийгмийн байгууллагын бүртгэлийн шаардлага, авлигын эсрэг идэвхтэй сургалтуудтай орон нутгийн их сургуулиуд г.м)-ийг тусгаж өгөх хэрэгтэй. Залуучуудын үр дүнтэй оролцоог хангах тухайн бүс нутгийн онцлог нөхцөл байдал, залуучуудыг чадавхжуулах, ижил төстэй төрийн байгууллагууд, хувийн хэвшил, шинжлэх ухааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах цар хүрээ, мөн гүн гүнзгий ойлголт нь авлигатай тэмцэх байгууллагуудад залуучуудыг үр дүнтэйгээр оролцуулах тохиромжтой арга зүйг боловсруулахад тусална. Энэхүү арга зүй нь туршлагагүй (залуучуудын оролцоог хангахад байгууллагын бэлэн байдлын түвшин доогуур үнэлэгдсэн), эсхүл илүү туршлагатай (залуучуудыг татан оролцуулж байгаа боловч өөрсдийн үйл ажиллагаан дахь оролцооны чанарыг сайжруулахыг хүсч байгаа) авлигатай тэмцэх байгууллагуудын аль аль нь ашиглах боломжтой. Аль ч тохиолдолд байгууллагын бэлэн байдлыг өндөр түвшинд хангахыг зорих ёстой. Нөөц бололцоо багатай, мөн залуусыг оролцуулах ажлын туршлага нимгэн авлигатай тэмцэх байгууллагуудын хувьд бусад байгууллагаас зөвлөх үйлчилгээ авахаар хандаж болох юм. Үүний дүнд авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын үр дүнтэй оролцоог хангахад хүрээнд өөрийн давуу болон сул талын талаар нарийвчилсан ойлголттой болно. Энэ нь залуучуудын чадавхыг сайжруулах, татан оролцуулах талаар авах арга хэмжээ, арга барилыг багтаасан тодорхой замыг тодорхойлох үндэс болдог. Үүнд залуучуудыг үр дүнтэйгээр оролцуулах үйл ажиллагааны бэлэн байдлыг хангахын тулд байгууллагын дотоод чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ түншлэлээр дамжуулан, эсхүл гол ажлуудаа бусад этгээдээр/аутсорсинг хийх замаар анхаарал хандуулбал зохих хэсгүүд болон сул талуудыг сайжруулахад чиглэсэн тусгайлан дэмжлэг авах, эсхүл болгоомжтой ажиллах шаардлагыг тусгаж болно.



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын оролцооны дотоод чадавх, ур чадварын түвшингээс хамааран дотооддоо, эсхүл мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр залуучуудыг үг дүнтэй татан оролцуулах байгууллагын бэлэн байдалд үнэлгээг хийлгэх хэрэгтэй.

Энэхүү үнэлгээний үр дүн нь авлигатай тэмцэх байгууллагын чадавхын түвшинг тодорхойлж, залуучуудыг бодитойгоор татан оролцуулахаас өмнө авах шаардлагатай арга хэмжээг багтаасан, мөн хэрхэн сайжруулах тодорхой төлөвлөгөөг тус байгууллагад гаргаж өгдөг.

Энэхүү үнэлгээ нь авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг оролцуулах асуудлыг үйл ажиллагааныхаа нэг хэсэг болгон зохион байгуулах үндэс суурь болдог (ЗБ бүлгийг үзнэ үү). Үнэлгээг хяналт-шинжилгээ, үнэлгээ, сургалтын үйл явцын нэг хэсэг болгон давтамжтайгаар хийж байх хэрэгтэй (ЗБ бүлгийг үзнэ үү).




3Б. Зохион байгуулалтын түвшин:Залуусын үр дүнтэй оролцоог авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд нэгтгэн уялдуулах нь

Байгууллагын бэлэн байдлын түвшин (3А бүлэг)-ийг хангасан авлигатай тэмцэх байгууллагууд нь залуучуудын үр дүнтэй оролцоог дөрвөн үе шатаар дамжуулан өөрсдийн үйл ажиллагаа (жишээ нь, төсөл, хөтөлбөр болон мэдлэг олгох)-тай уялдуулах боломжтой.

1.Байгууллагын үйл ажиллагааны үйл явц

Өөрчлөлтийн онолын аргачлалыг авлигатай тэмцэх байгууллагууд хөтөлбөр боловсруулахдаа өргөн ашигладаг. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Өөрчлөлтийн онолыг “боломжит нотолгоонд тулгуурлан шалтгаан-үр дагаврын шинжилгээнд үндэслэн тухайн хөндлөнгийн оролцоо, эсхүл цогц арга хэмжээ нь хөгжлийн тодорхой өөрчлөлтөд хэрхэн хүргэхийг тайлбарлах арга”¹⁸ гэж тодорхойлсон байдаг. Энэ нь урт хугацааны нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөх цогц хөтөлбөрүүдийг боловсруулах, хянах, үнэлэхэд түгээмэл хэрэглэдэг арга бөгөөд дэлхийн бүхий л салбарт, тэр дундаа авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд ч ашиглаж болно.

Ерөнхийдөө Өөрчлөлтийн онол нь логик алхмуудаар үйл ажиллагаа нь хэрхэн үр дүнд хүргэдгийг дараах байдлаар¹⁹ тодорхойлдог



¹⁸ United Nations Development Group of Latin America and the Caribbean, “Theory of Change concept note” (October, 2016), p.4.

¹⁹ Энэ бол хялбаршуулсан хувилбар юм. Үйл ажиллагааны хэрэгжилт, түүнээс гарах үр дүн нь авлигатай тэмцэх байгууллагуудын шууд хяналтад байх бөгөөд Өөрчлөлтийн онолын дагуу тодорхойлсон зорилт нь үнэн зөв тохиолдолд л дунд болон урт хугацааны үр дүн (үр дүн болон үр нөлөө)-д хүрнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг United Nations Development Group of Latin America and the Caribbean, “Theory of Change concept note” (October 2016), p.4; CHR. Michelsen Institute, U4 Issue No.8 – How to monitor and evaluate anti-corruption agencies (2011); CHR. Michelsen Institute, U4 Issue No.6 – Theories of change in anti-corruption work (2012); and CHR. Michelsen Institute, U4 Issue No.8 – Methods for learning what works and why in anticorruption (2013).үзэх.



Үүнд: Авлигатай тэмцэх байгууллагууд нь залуучуудын үр дүнтэй оролцоог өөрсдийн үйл ажиллагаандаа нэгтгэн уялдуулахдаа Өөрчлөлтийн онолыг бусад салбарт ашигладагтай нэгэн адилаар хэрэглэж болно. Ингэхдээ урт хугацааны зорилгоос (үр нөлөө) эхлүүлэх бөгөөд дараах диаграммд үзүүлсэн шиг дөрвөн үе шат/алхмаар хойноос урагш логик дарааллын дагуу хэрэгжүүлдэг.



- ➔ Алхам 1. Авлигатай тэмцэх байгууллагын зорилтуудыг тодорхойлох: Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж хүрэх үр дүн (outcome) болон хөтөлбөрийн үр нөлөөг тодорхойлно.
- ➔ Алхам 2. Залуучуудын оролцооны хувь нэмрийг тодорхойлох: Залуучуудтай ажиллахдаа авлигатай тэмцэх байгууллагын тодорхойлсон үр дүнд хүрэхэд залуучуудын ямар үйл ажиллагаа дэмжлэг үзүүлж болохыг өргөн хүрээнд тогтоох.
- ➔ Алхам 3. Нарийвчилсан хөндлөнгийн оролцооны арга барилыг төлөвлөх: Залуучуудын үйл нарийвчилсан үйл ажиллагааг хамтран боловсруулах, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлох.
- ➔ Алхам 4. Залуучуудын үр дүнтэй оролцоог шалгах: 3-р алхамд тодорхойлсон арга хэмжээ нь залуучуудын үр дүнтэй оролцоонд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах.

Залуучуудын үр дүнтэй оролцоог үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд авлигатай тэмцэх байгууллагууд болон залуучууд эхнээсээ хамтран ажиллах хэрэгтэй. Авлигатай тэмцэх байгууллагуудаас залуучуудын оролцооны бүтцийг урьдчилан бий болгосноор (Байгууллагын чадавхыг тодорхойлох хүчин зүйлс 9, энэ нь залуучуудыг тогтмол нэгтгэх, эсхүл тасралтгүй оролцуулах боломжийг олгодог) байгууллагууд залуучуудын үр дүнтэй оролцоог хангах үйл ажиллагааны төлөвлөлт хийх, загвар гаргах гол цэгүүдэд зөвлөлдөх болон зөвлөгөө авах боломжоор хангана.



Үйл ажиллагааны дөрвөн алхам

АЛХАМ 1: ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ТОДОРХОЙЛОХ

Чиглүүлэх асуулт:

Хөтөлбөрийн хүрээнд авлигатай тэмцэх байгууллагууд юунд хүрэхийг зорьж байна вэ?

Авлигатай тэмцэх байгууллагуудын зорилт нь авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, түүнтэй тэмцэх явдал юм. Ихэнх улс орон, бүс нутагт авлигатай тэмцэх ажил нь Засгийн газрын стратегийн зорилтуудын нэг хэсэг бөгөөд үндэсний хэмжээнд авлигатай тэмцэх байгууллага нь авлигатай тэмцэх ажлыг удирдан чиглүүлдэг тэргүүлэгч байгууллага байх ба үгүй юм гэхэд гол оролцогч байгууллага нь байдаг.

Нэн түрүүнд авлигатай тэмцэх байгууллагууд уг хөтөлбөрүүд нь өөрсдийн үйл ажиллагааны зорилго (*жишээ нь*, жилийн төлөвлөгөөндөө тусгасан) болон стратегийн тэргүүлэх зорилт (*тухайлбал*, үндэсний хөгжлийн төлөвлөгөө, эсхүл авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртэй хэрхэн уялдаж байгааг тодорхой болгох ёстой. Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагааг стратегийн зорилтуудтай уялдуулах нь сайн туршлага юм. Өөрчлөлтийн онолыг ашиглан аливаа төслийг боловсруулахдаа урт хугацааны зорилт, *тухайлбал*, авлигатай тэмцэх байгууллагуудын хувь нэмрээ оруулснаар гаргах үл нөлөөний асуудлаас эхлэх хэрэгтэй. Үйл ажиллагаагаа стратегийн зорилтуудтай уялдуулах нь дэлхийн олон орны авлигатай тэмцэх олон байгууллагын хувьд томоохон сорилт болж байгааг туршлага²⁰ харуулж байна.

Алхам 1-ийн үр дүн

Авлигатай тэмцэх байгууллагууд өөрсдийн хөтөлбөрүүд нь юунд (outcome) хүрэхийг зорьж, стратегийн тэргүүлэх зорилтуудтай (үр нөлөө) хэрхэн нийцэж байгааг) хэрхэн нийцэж байгааг нарийвчлан тодорхойлж, томьёолсон байна.

Хөтөлбөрийн үр дүн нь залуучуудын үр дүнтэй оролцоог авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулахад дараагийн алхмуудын үндэс суурь болж өгнө.

²⁰ United Nations Development Programme, *Strategic Programming for Anti-Corruption Agencies – Regional Guidance Note for ASEAN* (Bangkok, 2022).



ОНОЛЫН ЖИШЭЭ

Алхам 1

Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний дагуу төрийн худалдан авах ажиллагааны үнэ цэнийг тухайн улс орон, нутаг дэвсгэрийн стратегийн зорилт гэж тодорхойлсон.

Авлигатай тэмцэх байгууллагын хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн төрийн албан хаагчид болон тендерт оролцогчид хоорондоо байнга үгсэн хуйвалдаж байдаг нь төрийн худалдан авах ажиллагаанд тулгамдаж буй гол асуудлын нэг болохыг тогтоожээ. Үйл явцын ил тод байдлыг нэмэгдүүлснээр нууцаар хуйвалдах явдлыг олон нийтээс нуун дарагдуулах, гарах магадлалыг бууруулж, энэ салбар дахь авлигын түвшинг бууруулна.

Алхам 1-ийн үр дүн: Авлигатай тэмцэх байгууллага нь Өөрчлөлтийн онолын дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлсон. Үүнд:

- ➔ Үр нөлөө: төрийн худалдан авалт дахь мөнгөний үнэ цэнэ (Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний стратегийн зорилт)
- ➔ Үр дүн: төрийн худалдан авах ажиллагааны ил тод байдлын өндөр түвшин

Жич: Дөрвөн алхмын танилцуулгыг хялбарчлах, залуучуудыг үр дүнтэй оролцуулах үйл ажиллагааг тодорхой тайлбарлахын тулд залуучууд гарц/ үр дүнгээс шууд ашиг хүртэгчид гэж тооцох боломжгүй үр дүнд зориулан энэхүү жишээг зориуд сонгосон болно.



АЛХАМ 2: ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦООНЫ ХУВЬ НЭМРИЙГ ТОДОРХОЙЛОХ

Чиглүүлэх асуулт:

Залуучуудын оролцооны ямар үйл ажиллагаа үр дүнд хүрэхэд нь хувь нэмэр оруулах вэ?

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудтай хамтран ажиллахын ашиг тусыг тодорхой харж байгаа хэдий ч залуучуудын оруулах хувь нэмэр болон залуучуудаар гүйцэтгүүлэх ажил үүргийг тодорхой болгож өгөх замаар тэдгээрийн оролцооны үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой (1Б бүлгийг үзнэ үү). Авлигатай тэмцэх байгууллагууд нэг дэх алхамд тодорхойлсон үр дүнд хүрэхийн тулд залуучууд хэрхэн оролцож хувь нэмрээ оруулахыг тодорхой болгож өгөх нь хамгийн чухал юм. Тавьсан зорилтуудад хүрэхийн тулд залуучууд хэрхэн хувь нэмрээ оруулж болохыг тодорхой болгох замаар залуучуудын үр дүнтэй оролцоог хэрэгжүүлэх зорилтуудын биелэлттэй уялдуулж өгөхийг зөвлөдөг. Алхам 2-ыг төлөвлөхдөө залуучуудыг татан оролцуулж хамтран боловсруулах нь сайн туршлагад тооцогдох бөгөөд энэ нь залуучуудын оролцоог илүү оновчтой, тогтвортой хэрэгжүүлэхэд тустай байдаг. Авлигатай тэмцэх байгууллагын дэвшүүлсэн үр дүнд хүрэхэд залуучууд хэрхэн хувь нэмрээ оруулах, эсхүл оруулах ёстой талаар санал санаачилга гаргахад туслах хоёр арга байдаг. Энэ 2 арга нь бие биеэ үгүйсгэдэггүй, гэхдээ давхцах тал байдаг. Эдгээрийн аль алиныг нь ашиглавал хамгийн сайн үр дүн өгөх болно. Үүнд:

1. **Авлигатай тэмцэх байгууллагын хэтийн төлөв: Авлигатай тэмцэх байгууллагыг зорилгодоо хүрэх, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд залуучууд хэрхэн дэмжих вэ?**
Энэ арга нь авлигатай тэмцэх байгууллагуудад тулгарч буй сорилтод тулгуурладаг (2А бүлгээс үзнэ үү). Энэ нь зөвхөн авлигатай тэмцэх байгууллагуудад тулгамдаж буй асуудалд тулгуурлан залуучуудын оролцооны хувилбаруудыг тодорхойлдог тул залуучуудад төвлөрсөн бус үр дүнд хүрэх эрсдэлтэй байдаг. Авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд залуучуудыг үр дүнтэй оролцуулах арга замыг тодорхойлохоос илүүтэйгээр тэдгээрийг үйл ажиллагаандаа татан оролцуулах нь чухал болохыг ойлгуулахад илүү тохиромжтой. Үр дүнтэй оролцоог бэхжүүлэхэд нөлөөлөх байгууллагын зарим хүчин зүйлс (3А бүлгээс үзнэ үү)-ийг сайжруулахад чиглэсэн Залуучуудын оролцооны үйл ажиллагааны хөтөлбөр нь энэхүү аргачлалын үр дүнд гарч болох бөгөөд энэ нь авлигатай тэмцэх байгууллагаас залуучуудыг үр дүнтэй татан оролцуулахад үнэтэй хувь нэмэр оруулж болно.
2. **Залуучуудын үзэл бодол: Залуучууд авлигатай тэмцэх байгууллагуудыг зорьж буй үр дүндээ хүрэхэд туслах ямар нэмэлт үнэ цэнийг бий болгох вэ?**
Энэхүү хандлага нь авлигатай тэмцэх байгууллагуудын зорьж буй зорилтуудад анхаарлаа төвлөрүүлж, зорилгодоо хүрэхэд шаардлагатай ажилд нь үнэ цэнэ нэмэх залуучуудын гүйцэтгэх үүрэг, тэдний чадавхыг тодорхой харгалзан үзэхэд чиглэдэг. Энэ нь залуучуудад төвлөрсөн арга бөгөөд залуучуудын



сонирхлыг харгалзан, төслийн эхний үе шатанд оролцож байгаа тохиолдолд тэдгээрийн өвөрмөц давуу талыг илүү сайн ашиглах үүднээс залуучуудыг үр дүнтэй оролцуулах хувилбаруудыг тодорхойлоход тохиромжтой байдаг.

Иргэний нийгэм, тэр дундаа залуучууд өөрсдөдөө хамааралтай нийгмийн бүлэг, тэдгээрийн сайн сайхан байдалд шууд нөлөөлөх асуудлыг чин сэтгэлээсээ сонирхдог. Туршлагаас харахад иргэд өөрт нь хувь хүнийх нь хувьд нөлөө үзүүлж эхлэх үед авлигатай тэмцэх үйл ажиллагаанд оролцох хандлагатай байдаг. Ийм учраас эрүүл мэнд, ус, боловсрол гэх мэт иргэдийн амьжиргаанд шууд илт нөлөө үзүүлдэг асуудлын хүрээнд, мөн нийгмийн бүлгүүдийн хэрэгцээ шаардлага болон эрхийг хамгаалах чиглэлээр илүү олон иргэний нийгмийн байгууллага ажиллаж байхад авлигатай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага цөөхөн байдаг²¹.

Оролцооны тохиромжтой хөтөлбөрийг хэрэгжүүлэх шийдвэр нь зөвхөн залуучуудын үр дүнтэй оролцоог хүлээн зөвшөөрснөөр хязгаарлаж болохгүйг анхаарах нь чухал. Авлигатай тэмцэх байгууллагууд нь хөтөлбөрийн зорилтууд, түүнд хүрэхээр хэрэгжүүлэх тодорхой үйл ажиллагаа, тэдгээрийн гарцыг залуучуудыг оролцуулсан болон оролцуулаагүй байдлаар тодорхойлох шаардлагатай. Гэсэн хэдий ч, ялангуяа авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг татан оролцуулах үүрэг хүлээсэн үед залуусын оролцоо чухал бүрэлдэхүүн хэсэг хэвээр байх болно. Авлигын эсрэг тодорхой үр дүнд хүрэхээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд залуучуудыг оролцуулах шаардлагатай биш бол авлигатай тэмцэх байгууллага болон оролцож буй залуучуудад сөрөг нөлөө (*жишээлбэл*, хэлбэрийн төдий оролцох г.м эрсдэл) үзүүлж болзошгүй тул залуучуудыг хөтөлбөрт хүчээр оролцуулахгүй байвал зохино.

Авлигатай тэмцэх байгууллагууд залуучууд эцсийн үр шимийг нь хүртэхээр тодорхой зорилтуудыг тавьсан тохиолдлууд байдаг. Авлигатай тэмцэх байгууллагын чиг үүрэг болон стратегийн бусад баримт бичигт залуучуудыг зорилт болгон (*жишээлбэл*, залуучуудад чиглэсэн авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, эсхүл авлигын эсрэг боловсролын хөтөлбөрүүдэд хамруулах) тодорхойлон тусгаж болно.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртөө залуучуудын оролцоог тусгаж болно²². Ийм тохиолдолд энэхүү хөтөлбөрийн чиглэл нь залуучуудын оролцооны сайн туршлагын төрөл, цар хүрээг тодорхойлоход тусалж (*жишээ нь*, жишээ нь, залуучуудыг авлигын эсрэг мессежийг орон нутгийн иргэдэд хүргэх, залуучуудыг чадавхжуулах, боловсролын хөтөлбөрийг дэмжих түнш гэж хүлээн зөвшөөрөх) болох юм. Авлигын эсрэг хөтөлбөрийн эцсийн үр шимийг залуучууд хүртэхээр байсан ч гэсэн дөрвөн үе шат/алхмыг мөрдөх хэрэгтэй, ингэснээр залуучуудын оролцооны гол бүрэлдэхүүн хэсгүүдийг оруулах нь үнэ цэнийг нэмэгдүүлэх магадлалтай. Үнэн хэрэгтээ авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын боловсрол, мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд залуучуудыг татан оролцуулах нь онцгой ач холбогдолтой болохыг судалгаа харуулж байна.

²¹ CHR. Michelsen Institute, *U4 Practice Insight 2022:2 – Civil society monitoring in the health sector* (2022)

²² Бидний судалгаагаар Авлигатай тэмцэх үндэсний стратегия хариуцдаг ихэнх авлигатай тэмцэх байгууллагуудаас эдгээр баримт бичигт залуусын оролцооны бүрэлдэхүүн хэсгүүд тусгасан болохыг танилцуулсан байна (2А бүлгээс харна уу).



Алхам 2-ын үр дүн

Залуучуудын оролцооны тодорхой үйл ажиллагаануудыг нэгтгэж, хөтөлбөрийн зорилтот үр дүнд хүрэхэд түлхэц болохуйц үзэл баримтлалд тулгуурлан тусгасан Өөрчлөлтийн онолын өргөтгөсөн хувилбар.

ОНОЛЫН ЖИШЭЭ

Алхам 2

Авлигатай тэмцэх байгууллага алхам 1-ийн үр дүнг “төрийн худалдан авах ажиллагааны ил тод байдал илүү өндөр түвшинд хүрнэ” гэж тодорхойлсон. Тэрээр одоогоор энэ үр дүнд хүрэх хоёр арга замыг тодорхойлбол: Үүнд гэрээлэгч байгууллагууд мэдээллийг нээлттэй болгох, эсхүл олон нийт мэдээлэл авах хүсэлт гаргах боломжтой. Тендерийн цахим систем нь эхний арга замын нийтлэг жишээ бөгөөд нөгөө арга замын хувьд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлэл авах хүсэлтийг дурдаж болно.

Авлигатай тэмцэх залуучуудын зөвлөх, түншүүдтэйгээ хамтран ажилласнаар залуусын хувь нэмрийг дараах байдлаар нэмэгдүүлж болно. Үүнд:

- ➔ Тэд өндөр чанартай өгөгдөл хангалтгүй байгаа нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд тендерийн цахим систем, их өгөгдөлд дүн шинжилгээ хийх, бизнесийн шинжилгээний хэрэгслүүдийг хөгжүүлж, турших зэрэг технологид суурилсан шийдлүүдийг дэмжих болно.
- ➔ Тэд орон нутгийнхаа худалдан авалтын талаарх мэдээлэл авах хүсэлт гаргах, тухайлбал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шаардах, тендерийн мэдээллийг хэвлэн нийтлэхэд хяналт тавих зэргээр ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд үе тэнгийнхнийгээ дайчилж болно.

Төрийн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг илүү өндөр түвшинд хүргэхийн тулд авлигатай тэмцэх байгууллага нь хакатон зохион байгуулж, цахим тендерийн системийг хөгжүүлэхэд технологийн мэдлэгтэй залуусыг нэгтгэн, санал бодлоо солилцох боломжтой. Түүнчлэн техникийн болон санхүүгийн боломж хязгаарлагдмал байгааг харгалзан авлигатай тэмцэх байгууллага нь эхний ээлжинд орон нутгийн хэмжээнд төрийн худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахад анхаарч болно.

АЛХАМ 3: ХӨНДЛӨНГИЙН ОРОЛЦООНЫ НАРИЙВЧИЛСАН ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ

Чиглүүлэх асуулт:

Үр дүнд хүрэхийн тулд залуучууд хэрхэн оролцох ёстой вэ?

Авлигатай тэмцэх байгууллага нь алхам 2-т тодорхойлсны дагуу залуучуудаар хийлгэвэл зохих үйл ажиллагаа (хөндлөнгийн оролцоо, төсөл, хөтөлбөр)-ны загвар болон аргачлалыг тодорхойлж, төлөвлөнө. Үүнийг дахин залуучуудтай хамтран боловсруулах хэрэгтэй.

1. Залуучуудын үүрэг

Залуучуудын гүйцэтгэх үүргийг нарийн тодорхойлохын тулд хоёр үндсэн хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд:

- ➔ **Оролцооны цар хүрээ:** Энэ нь авлигатай тэмцэх эрх бүхий байгууллага, залуучуудаас хүлээгдэж буй ажлын үр дүнгийн түвшин, шинж чанар, түүнчлэн хамтын ажиллагааны давтамж болон идэвхийг илэрхийлнэ.
- ➔ Авлигын эсрэг санаачилга (үйл ажиллагаа, гарц)-уудыг боловсруулах, хэрэгжүүлэхэд залуучуудын тавих **хяналтын түвшин**.

Эдгээр гол хүчин зүйлсээс хэр зэрэг хамаарч байгаагаас шалтгаалан авлигын эсрэг санаачилгад залуучуудын оролцоог дараах дөрвөн үүрэгт хувааж болно. Үүнд:



Тайлбар: ЮНЕСКО-гоос боловсруулсан, *Залуучуудтай үр дүнтэй хамтран ажиллах нь* - НҮБ-ын ажилтнуудад зориулсан заавар, сургалтын материал (Парис, 2019)

Залуучуудын оролцооны цар хүрээг нэмэгдүүлэхийн тулд үйл ажиллагааны загвар гаргах, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд тэдгээрийг илүү түлхүү татан оролцуулах, энэ хүрээнд уялдааг хангах ажлыг тогтмол зохион байгуулж болно. Харин нөгөө талаас, түр зуурын холбоо тогтоох, эсхүл нэг удаагийн шинжтэй ажлыг гүйцэтгэхэд оролцох (зөвлөлдөх уулзалтад оролцох г.м) зэрэг нь оролцооны түвшин бага байгааг харуулна.

Оролцооны цар хүрээ, хяналтын түвшинг доогуур байлгах нь залуучуудын санаачилгыг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжийг хязгаарладаг, эсхүл эсрэгээр байж болно.



**Ахлах сургуульд авлигын эсрэг сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх нь:
залуучуудын гүйцэтгэх өөр өөр ажил үүргийн жишээ**

Ахлах сургуульд авлигын эсрэг сургалтын хөтөлбөрөөр сургалт оруулахад залуучуудын гүйцэтгэж болох өөр өөр ажил үүргийн жишээг уг үйл ажиллагааг төлөвлөх болон хэрэгжүүлэхэд тавих хяналт, оролцооны түвшнээс хамааруулан дараах дөрвөн хувилбараар харууллаа.

1. Оролцогчид: Оюутнууд авлигатай тэмцэх байгууллагын мэргэжилтний авлигын эсрэг сургалтад хамрагдана.

2. Идэвхтэн дэмжигчид: Авлигатай тэмцэх байгууллагын дадлагажигч, эсхүл залуу ажилтан нь авлигатай тэмцэх байгууллагын насанд хүрсэн мэргэжилтнүүдийн боловсруулсан сургалтын хөтөлбөрөөр оюутнуудад сургалт хийнэ.

3. Түншүүд: Авлигатай тэмцэх байгууллага сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулах үеэс эхлэн залуучуудын байгууллагыг татан оролцуулж, сургалтын хөтөлбөрийг авлигатай тэмцэх байгууллагын ажилтнуудтай хамтран боловсруулахаас өмнө залуучуудын чадавхын судалгаа хийх, мөн холбогдох талууд, зөвлөхүүдийг оролцуулан фокус бүлгийн хэлэлцүүлэг өрнүүлдэг. Залуучууд сургагч багш, чиглүүлэгчээр ажиллах, залуучуудын чадавхыг үнэлэх, сургалтын дараах судалгаа авах зэргээр сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусалдаг.

4. Манлайлагчид: Залуучуудын тэргүүлдэг иргэний нийгмийн байгууллагууд нь хандивлагч байгууллагаас санхүүжилт авч, өөрсдийн боловсруулсан сургалтыг өөрөө (ахлах сургуулиудад) зохион байгуулдаг. Тэд авлигатай тэмцэх байгууллагыг сургалтын хөтөлбөртэй танилцах, хамтран боловсруулах, сайжруулах, мөн сургалтын зарим хэсгийг зохион байгуулахад хамтран ажиллаж үйл ажиллагаанд нь хувь нэмэр оруулахыг хүсч болно. Энэхүү сургалтын хөтөлбөрийг авлигатай тэмцэх байгууллага болон иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж байгаа талаар нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллээр сурталчилдаг. Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд залуус өөр өөр үүрэг гүйцэтгэж янз бүрийн бүлгийн хувиар оролцох боломжтой бөгөөд эдгээр дөрвөн хувилбаруудад ахлах сургуулийн сурагчид оролцогч байна. Эцсийн үр шимийг нь залуучууд хүртдэг хөтөлбөрүүдэд залуучуудыг үр дүнтэйгээр оролцуулах зарчмуудыг ашигласнаар тэдгээрийг олон төрлийн үүрэг гүйцэтгэж оролцох шийдлүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ төрлийн төслүүд хамгийн үр дүнтэй гэж үзэж санал болгодог.

Залуусын оролцоонд гүйцэтгэсэн ажил үүргийн үр дүн нь авлигатай тэмцэх байгууллагуудын нэн түрүүнд анхаарал хандуулах ёстой зүйл байдаг. Эдгээр үүргүүдийн болон авлигатай тэмцэх байгууллагын ажилд өөрөөр хэрхэн нийцэх талаарх тоймыг Хүснэгт 4-т харуулав.



Хүснэгт 4: Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд залуучуудын гүйцэтгэх үүрэг

Залуучуудын гүйцэтгэх үүрэг	Үйл ажиллагааг хэн санаачилдаг вэ?	Залуучууд хэзээнээс оролцож эхэлдэг вэ?	Залуучууд ямар үйл ажиллагаа явуулж болох вэ?
Оролцогчид	Авлигатай тэмцэх байгууллага	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад	Авлигын эсрэг санаачилга нь залуучууд үр дүнд шууд оролцох боломж хязгаарлагдмал байдаг. Жишээ нь: - Авлигын эсрэг боловсролын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, арга зүйг нэвтрүүлэх - Одоо байгаа бодлого, стратеги, хөтөлбөрийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах
Дэмжигчид	Авлигатай тэмцэх байгууллага	Хөтөлбөрийн тодорхой үе шатанд	Авлигын эсрэг санаачилга нь залуусын мэдлэг, ур чадвар, сүлжээгээр нөхөж боломжтой орон зайг нарийвчлан тодорхойлсон байдаг. Жишээ нь: - Авлигын эсрэг олон нийтэд зориулсан материалыг боловсруулах - Авлигын эсрэг олон нийтийн бүлгүүдийн буюу сургуулийн уулзалт хийх - Хууль зүйн товч танилцуулга боловсруулах, нотлох баримт цуглуулахад дэмжлэг үзүүлэх
Түншүүд	Авлигатай тэмцэх байгууллага болон залуучуудын байгууллагууд	Эхний шатанд, эсхүл шаардлагатай тохиолдолд	Залуучуудын хамтран санаачилж, хамтран төлөвлөж, хамтран боловсруулж, хамтран хэрэгжүүлж, хамтран удирддаг авлигын эсрэг санаачилга. Жишээ нь: - Авлигатай тэмцэх байгууллагыг дэмжих зорилгоор залуучуудын зөвлөх бүлгүүд, зөвлөлүүдийг ажиллуулах, дугуй ширээний ярилцлага, бодлогын хэлэлцүүлэг болон үе хоорондын төлөөллийг хамруулсан ижил төстэй арга хэмжээ зохион байгуулах. - Авлигатай тэмцэх байгууллагыг залуучуудтай хамтран хөтөлбөр хэрэгжүүлэхэд нь өөрсдөө санхүүжүүлэх нэмэлт дэмжлэг үзүүлэх, шинэ боломжуудыг ашиглах
Залуу манлайлагчид	Залуучууд, эсхүл залуучуудын байгууллага	Төслийн (мөчлөгийн) туршид	Залуучууд өөрсдөө төлөвлөж, хэрэгжүүлж, удирддаг авлигын эсрэг санаачилга юм. Ингэхдээ тэд өөрсдийн чадвар, хүсэл тэмүүлэл болон бусад давуу талаа ашиглан авлигатай тэмцэх үйл ажиллагаанд эергээр хувь нэмрээ оруулж байдаг. Жишээ нь: Оролцогч талуудын дүн шинжилгээг хийх, төслийг төлөвлөх, санхүүжилт олох, хэрэгжилтийг зохион байгуулах болон орон нутгийн нийгмийн бүлгүүдийн авлигын эсрэг судалгааг хийж авлигатай тэмцэх байгууллагын олон нийтийг соён гэгээрүүлэх хөтөлбөрт хувь нэмэр оруулах



Залуучууд хэр оролцож байна вэ?

Залуучуудыг хамтад нь цуглуулах, эсхүл үйл ажиллагаанд оролцохыг урьдаг. Оролцогч арга хэмжээний өмнө болон дараа ямар нэг байдлаар оролцохгүй.

Залуучуудыг сайн дурын ажилтан, дадлагажигч, зөвлөхөөр ажиллуулдаг. Тэд санаачилгын нэг, эсхүл хэд хэдэн үе шатанд оролцож болдог. Санаачилга болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэрт тэд шууд нөлөө үзүүлдэггүй.

Залуучууд авлигатай тэмцэх байгууллагын ажилтнуудтай хамтран уг санаачилгыг хэрэгжүүлснээр илүү их нөлөөллийг олж авдаг. Энэ нь ихэвчлэн авлигатай тэмцэх чиглэлээр ажиллах сонирхолтой залуучуудаар удирдуулсан байгууллагууд болон залуусын бүлгүүдтэй хамтран ажиллахыг хэлдэг. Түншлэлийн хүрээнд залуучууд авлигатай тэмцэх байгууллагын ажилтнуудтай эрх тэгш хамтран ажиллах, хамтын санаачилгыг чиглүүлж, шийдвэрт нөлөөлөх, өөрсдийн нөөц бололцоо (эрч хүч, инновац, харилцааны ур чадвар г.м)-г бүрэн дүүрэн ашиглах боломжийг олгодог. Залуучуудын оролцооны эдгээр үйл ажиллагааны зардлыг хуваах эсвэл гуравдагч этгээдээс санхүүжүүлэхийг зөвшөөрч болно.

Залуучууд санаачилгын төлөвлөлт, хэрэгжилтээс эхлээд хяналт-шинжилгээ, үнэлгээ хүртэлх бүх хэсгийг хариуцдаг. Энэ үүргийн хүрээнд залуучуудад зөвлөх, ажиллах орон зай болон нөөцөөр хангах, мэдээлэл өгөх, чадавхыг бэхжүүлэх, бусад оролцогч талуудтай холбоо тогтооход авлигатай тэмцэх байгууллагуудын тусалцаа залуучуудад шаардлагатай байдаг. Залуучуудын оролцоог хангах эдгээр үйл ажиллагааг гуравдагч этгээд санхүүжүүлж болно.



2. Үйл ажиллагааны төрөл

Залуучуудын оролцооны агуулгаас үйл ажиллагааны төрөл нь хамаардаг бөгөөд үйл ажиллагааны төрлийг “дуу хоолой”, “үзэл бодол”, “үйлдэл” гэж (2Б бүлэгт) тодорхойлсон байдаг. Эдгээр үйл ажиллагаа тус бүр нь авлигатай тэмцэх байгууллагын чиг үүргийг өөр өөр арга замаар дэмжиж болно.

Залуучуудын оролцоог үйл ажиллагаандаа амжилттай уялдуулж нэгтгэхийн тулд тухайн байгууллагууд нь залуучууд ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зорьж байгааг болон авлигатай тэмцэх байгууллагаас ямар чиг үүрэг дээр дэмжлэг үзүүлэх талаар залуустай ойлголцолд хүрэх ёстой.





3. Үйл ажиллагааны тодорхойлолт – Сонголтуудын цэс

Хоёр үндсэн шалгуур (залуучуудын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны төрөл) дээр тулгуурлан нөхцөл байдлыг үнэлж үр дүнд хүрэхэд залуучууд тусалж чадах үйл ажиллагааг авлигатай тэмцэх байгууллагууд тодорхойлох боломжтой байдаг. Үйл ажиллагаанууд, түүний дотор тэдгээрийн гарц (шууд үр дүн)-ийг тодорхойлсноор Өөрчлөлтийн онолоор тодорхойлсон логик алхмуудыг дагаж мөрдөх үйл явц дуусгавар болдог.

Бидний судалгаанд тодорхойлсон практик жишээнүүдийг “сонголтын цэс” байдлаар Хүснэгт 5-д тоймлон оруулсан бөгөөд эдгээрээс санаа, сэдэл авч болох юм. Залуусын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны төрлүүд болон тэдгээрийн гүйцэтгэж буй үүрэг оролцооны талаар бодит жишээнүүдийг багтаасан нэмэлт мэдээллийг энэхүү бодлогын гарын авлагын цахим хуудаснаас үзнэ үү. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын оролцоог хангах олон төрлийн үйл ажиллагааг нөхцөл байдалдаа тохируулан зохион байгуулснаар туршлага хуримтлуулах бөгөөд урт хугацааны үнэ цэнтэй харилцааг хамтран ажилласан хүмүүс болон залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудтай тогтоох болно.



Хүснэгт 5: Залуучуудын үйл ажиллагааны төрөл, тэдгээрийг авлигатай тэмцэх байгууллагуудын чиг үүрэгт нэгтгэх нь

Авлигатай тэмцэх байгууллагын чиг үүрэг	Үйл ажиллагааны төрөл
	Дуу хоолой
Урьдчилан сэргийлэх	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг авах, түүнд эгэх холбоо бий болгохын тулд санал хүсэлт цуглуулах - Залуучуудтай фокус бүлгийн хэлэлцүүлэг өрнүүлж, тэдний бүтээлч санал хүсэлтийг (дуу хоолой) цуглуулах. - Нийгмийн бүлгийн төлөөлөл болсон залуучууд болон авлигатай тэмцэх газрын төлөөлөл, нийтийн албан тушаалтнуудтай дугуй ширээний ярилцлага зохион байгуулж, залуучуудын дуу хоолойг сонсож, сонирхсон асуудлуудыг (жишээлбэл, төрийн үйлчилгээний чанар, төрийн худалдан авах ажиллагааны явц байдал гэх мэт) хэлэлцэх.
Хууль сахиулах	Авлигын, эсхүл бусад авлига гэж ойлгогдохуйц үйлдлийн талаар мэдээлэх - Залуучууд шүгэл үлээх суваг ашиглан гомдол, мэдээлэл гаргах - Нийтийн албан тушаалтнуудын авлига гэж ойлгогдохуйц үйл ажиллагаа, тэдний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдлүүдийн тухай залуучууд, олон нийтийн нэргүй мэдээллүүд (дуу хоолой) шалгах.
Олон нийтэд мэдээлэл хүргэх, ойлголтыг нэмэгдүүлэх	Авлигатай холбоотой тулгарч байгаа сорилт, авлигатай тэмцэх арга хэмжээний талаар мэдээлэл цуглуулж, түгээх - Дугуй ширээний ярилцлага, уулзалт, авлигын эсрэг уралдаан тэмцээн зохион байгуулах замаар нийгмийн бүлэг дэх залуус, сургуулийн сурагчдын дуу хоолойг сонсох - Нийгмийн бүлэгт авлигын эсрэг мэдээ мэдээллийг түгээж, тэднийг кампанит ажилд хамруулах зорилгоор залуучуудын сүлжээг дайчлах
Боловсрол	Авлигын эсрэг боловсролын үзэл баримтлалын талаар харилцан яриа өрнүүлэх - Залуучуудын дуу хоолойг сонсохын тулд авлигын эсрэг платформ дээрх боловсролын нийгмийн сүлжээний хаягаар дамжуулан оролцоог хангах - Үе үеийн төлөөллийг оролцуулсан мэдээлэл солилцох, сонсох арга хэмжээг (жишээлбэл, бодлогын яриа хэлэлцүүлэг, семинар, хурал гэх мэт) зохион байгуулах.
Зохицуулалт ба бодлого боловсруулалт	Авлигатай тэмцэх бодлого, журмын хэрэгжилтэд дэмжлэг авах, мэдээлэл түгээх зорилгоор санал, хүсэлтийг цуглуулах - Авлигатай тэмцэх шинэ журам, бодлогын талаар нийгмийн бүлэг дэх залуучуудын харилцан ярилцлагыг зохион байгуулж, тэдгээр журам, бодлогын талаар мэдээлэл түгээх, санал хүсэлт авах - Үе үеийн оролцоо бүхий шийдвэр гаргах, бодлого, хөтөлбөр боловсруулах форумд залуусын дуу хоолойг нэгтгэж, дамжуулахын тулд нийгмийн бүлэг дэх залуу шинжээчдийг дайчлах.



Үзэл бодол	Үйлдэл/үйл ажиллагаа
Урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг боловсруулах, эсхүл түүнийг сайжруулахын тулд өгөгдөл, мэдээллийг бий болгох - Авлигатай тэмцэх байгууллагаас хэрэгжүүлж байгаа урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг дэмжих зорилгоор бодлогын судалгаа, өгөгдлийн дүн шинжилгээг хамтран боловсруулж хийх - Урьдчилан сэргийлэх ажилд нийгмийн бүлгийн төлөөлөл болсон залуучуудын оролцоог хэрхэн хангах талаар судалгаа (судалгаа гэх мэт) хийх.	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг (төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх) үзүүлэх. - Нийтийн албан тушаалтнууд болон хөтөлбөрүүдийн ил тод байдал, хариуцан тайлагналтад хяналт шинжилгээ хийж, дэмжлэг үзүүлэх зорилгоор аппликейшн, платформ, арга хэрэгслийг зохион бүтээх - Нийгмийн бүлгүүдийн дунд бүлгэмүүдийг байгуулж, нийтийн төсөл хөтөлбөр, тендерт хяналт тавиулах
Хууль сахиулах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд туслах өгөгдөл, мэдээллийг бий болгох - Алдаа дутагдлын талаар бичиг баримтын түвшинд хяналт шалгалт явуулж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх - Авлигатай тэмцэх байгууллагуудад хууль сахиулах чиглэлээр судалгааг нийгмийн бүлгүүд дэх залуучуудын дунд зохион байгуулж, түгээхэд нь туслах.	Хуулийн сахиулах үйл ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ - Зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх байдалд хяналт шинжилгээ хийлгүүлэх - Авлига гэж ойлгогдохуйц үйл ажиллагаа, авлигын хэргийн талаар нотлох баримт цуглуулахад туслах өгөгдөл, аналитикийн аппликейшн, платформ, арга хэрэгслийг хөгжүүлэх
Олон нийтийн ойлголт мэдлэг, иргэдийн тулгамдсан асуудлуудын талаар өгөгдөл, мэдээллийг бий болгох - Авлигатай тэмцэх байгууллагаас нийгмийн сүлжээ, түүнээс гарч байгаа өгөгдөлд дүн шинжилгээ хийж, авлигын эсрэг санаачилгын талаарх олон нийтийн ойлголтыг цуглуулахад дэмжлэг үзүүлэх. - Төрийн үйлчилгээний чанарын талаарх санал хүсэлтийг цуглуулж, дүн шинжилгээ хийх	Олон нийтэд мэдээлэл түгээх, ойлголт өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх - Авлигатай тэмцэх байгууллагын санаачилга (түншүүд)-тай холбоотой авлигын эсрэг асуудлаар олон нийгмийн сүлжээгээр дамжуулан кампанит ажил өрнүүлэх. - Авлигатай тэмцэх залуучуудын клубүүдийг байгуулан ажиллуулж, авлигатай тэмцэх байгууллагуудтай байнгын хамтын ажиллагааг хангах.
Боловсролын сургалтын хөтөлбөрт авлигын эсрэг үзэл баримтлалыг тусгах үр дүнтэй арга замуудын талаарх ойлголтыг бий болгох - Залууст авлигын эсрэг хичээл заах албан бус, интерактив сурган хүмүүжүүлэх арга зүйг судалж турших - Залуучуудын нийтийн боловсролын хөтөлбөрт зориулсан гарын авлага, арга хэрэгсэл болон бусад материалыг боловсруулах	Авлигын эсрэг боловсролын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх - Авлигатай тэмцэх чиглэлээр залуучуудын манлайллын сургалт (мөн зуслангуудад) зохион байгуулж, авлигын эсрэг тэмцэгч залуучуудыг тодруулах - Авлигатай тэмцэх байгууллагаас хэрэгжүүлж байгаа санаачилгын хүрээнд залуучуудыг дадлагажуулах, сайн дурын ажил хийх боломжоор хангах
Авлигаас учирч байгаа сорилт, авлигын эсрэг зохицуулалт, бодлогын үр нөлөөний талаар өгөгдөл, мэдээллийг бий болгох - Байгаль орчныг хамгаалахад шаардлагатай авлигатай тэмцэх шинэ зохицуулалт, бодлогод залуучуудаар удирдуулсан ирээдүйд төлөвлөсөн төлөвлөлтийг хэрэгжүүлэх - Авлигатай тэмцэх бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээнд дэмжлэг үзүүлэхийн тулд залуучуудыг судалгаа явуулах, өгөгдөл цуглуулахад дайчлах.	Авлигатай тэмцэх үр дүнтэй зохицуулалт, бодлогын төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх - Залуучуудын удирдсан дизайнд суурилсан сэтгэлгээний аргуудыг ашиглан шинээр батлагдах бодлогыг боловсруулахад орц болгон цуглуулах - Дадлагажигч залуучууд, сайн дурын залуучуудыг авлигатай тэмцэх бодлого, журмын талаар олон нийтэд зориулсан нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах ажилд дайчлах.



4. Зураглал: Өөрчлөлтийн онолын тайлбар

Өөрчлөлтийн онолыг гүйцээн дуусгахдаа авлигатай тэмцэх байгууллагууд нь хөндлөнгийн оролцооны талаарх бүрэн зураглалыг харуулсан тайлбарыг нэмж, Өөрчлөлтийн онолын дараах логик алхмуудыг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгадаг. Үүнд:

- Үйл ажиллагаа нь гарцыг бий болгодог
- Гарц нь үр дүнд хүргэдэг
- Үр дүн нь үр нөлөөг бий болгодог

Шалгалтаар үл нийцэх, эсхүл илүү тохиромжтой хувилбар байгаа нь тогтоогдвол авлигатай тэмцэх байгууллага алхам 3-ыг дахин эхлүүлж болно.

Үйл ажиллагааг тодорхойлохоос гадна тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар зураглалд тусгана. Жишээлбэл, хэрэв үйл ажиллагааг “залуучуудтай ажилладаг иргэний нийгмийн байгууллагад зориулсан семинар” гэж тодорхойлсон бол энэ үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаарх зураглалд: семинарыг хэн төлөвлөх, бэлтгэх, явуулах, үр дүнг үнэлэх, хэн санхүүжүүлж, зохион байгуулах, түүнтэй холбоотой худалдан авалтыг хэн хийх, хуваарь, эцсийн хугацааг хэн хариуцах болон бусад холбогдох асуудлын талаар тайлбарлана. Энэхүү арга барил, аргачлалын нарийвчилсан тайлбар нь залуучуудыг оруулах хувь нэмрийг ойлгоход чухал ач холбогдолтой (алхам 2) бөгөөд уг үйл ажиллагаа, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх нь залуучуудын үр дүнтэй оролцоог хангаж чадсан эсэхийг үнэлэх үндэс болно (алхам 4). Сайн туршлагын дагуу уг тайлбарт залуучуудын үр дүнтэй оролцооны механизмуудыг нарийвчлан тусгасан, ажлын даалгаврыг тодорхойлсон, хэрэгжүүлэх хуваарь, зардлын нарийвчилсан төлөвлөгөөг тусгасан үзэл баримтлалын тэмдэглэлийг багтааж болно.

Хөтөлбөрийг боловсруулах хүрээнд авлигатай тэмцэх байгууллагууд баримт бичигтээ залуучуудын үр дүнтэй оролцооны зарчмуудыг дагаж мөрдөж буй эсэхэд хийсэн үнэлгээг багтаасан байх ёстой.

Үзэл баримтлалын тэмдэглэлд залуучуудын үр дүнтэй оролцооны таван үндсэн санаа тус бүртэй уялдуулан баримтжуулсан үйл ажиллагаа, гарц бүрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулах нь энгийн бөгөөд ойлгомжтой арга юм. Сайн туршлагад хангалттай нөөц байгаа эсэх, төлөвлөсөн хугацаа бодитой эсэхийг шалгах зэрэг орно. Залуучууд энэ төлөвлөлт, боловсруулалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцвол зохилтой.



Энэ нь Өөрчлөлтийн онолыг боловсруулах хялбаршуулсан тайлбар гэдгийг (энэ гарын авлагын зорилгын үүднээс) тэмдэглэх нь зүйтэй. Авлигатай тэмцэх байгууллагын хөтөлбөрт Өөрчлөлтийн онолыг боловсруулахад шаардлагатай залуучуудын үр дүнтэй оролцооноос гадна нэмэлт бүрэлдэхүүн хэсгүүд байдаг. Үүнд орцын тодорхойлолт (төсөв, ажлын ачаалал гэх мэт), Өөрчлөлтийн онолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаа, таамаглал, түүнчлэн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь түвшин, мэдээллийн эх үүсвэр болон бусад зүйлс багтана. Авлигатай тэмцэх болон авлигатай тэмцэх байгууллагын ажлын хүрээнд Өөрчлөлтийн онолыг хэрэглэхэд анхаарах бусад асуудалд таамаглал, үзүүлэлт, хамаарал зэрэг орно.²³

Алхам 3-ын үр дүн

Өөрчлөлтийн онолыг авлигатай тэмцэх байгууллагуудын ажилд залуучуудыг татан оролцуулах зорилготой хөндлөнгийн оролцоо (үйл ажиллагаа, гарц)-оор төгсгөж, хөндлөнгийн оролцооны нарийвчилсан тайлбар (зураглал)-ыг тусгана.

Залуучуудын үр дүнтэй оролцооны механизмын нарийвчилсан мэдээлэл, ажлын даалгаврын тойм зэргийг багтаасан иж бүрэн үзэл баримтлалыг боловсруулах нь сайн туршлага юм.

²³ Иж бүрэн Өөрчлөлтийн онол болон түүнийг авлигын эсрэг ажил болон авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд хэрхэн ашиглах зааварчилгааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг CHR. Michelsen Institute, U4 Issue No.8 – How To Monitor and Evaluate Anti-Corruption Guidelines for Agencies, Donors and Evaluators (2011); and CHR. Michelsen Institute, U4 Issue No.6 – Theories of Change in Anti-Corruption Work (2012), 14 дэх талаас үзнэ үү.



ОНОЛЫН ЖИШЭЭ

Алхам 3

Алхам 3-ын үр дүнд авлигатай тэмцэх байгууллага дадлагажигч залуучууд болон орон нутагт “итгэл хүлээхүйц” залуучуудын сүлжээний сайн дурын ажилтнуудтай хамтран үйл ажиллагаа зохион байгууллаа. Үүний үндсэн дээр тус байгууллага нь хөтөлбөрийг дэмжих зорилгоор гарцад хүрэх залуучуудын оролцооны үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Гарц 1: Төслийн удирдлагыг бэхжүүлсэн байна

- ➔ **Үйл ажиллагаа 1:** Авлигатай тэмцэх байгууллагын дадлагажигч нар нарийвчилсан үйл ажиллагааг хамтран зохион байгуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт шинжилгээ хийхэд тусална. Мөн дадлагажигчид нь төслийн хэсэг бүрийн төлөөллөөс бүрдсэн Залуучуудын зөвлөх хороонд нэгдэх сонирхолтой, тодорхой ур чадвартай байгууллагын түнш болох орон нутагт “итгэл хүлээхүйц” залуучуудын сүлжээний гишүүдийг дайчилж болно. Уг Зөвлөх хорооны гишүүд нь тээвэр унаагаар хангагдах бөгөөд орц тус бүрийн хэрэгжилтийн дараа тэтгэлэг авна.
- ➔ **Үйл ажиллагаа 2:** Авлигатай тэмцэх байгууллагын дадлагажигчид нь хэрэгжилтийн түвшинд оролцогч талуудын дүн шинжилгээг хийж, авлигатай тэмцэх байгууллагын Залуучуудын зөвлөх хорооны зарим төлөөлөлтэй хамтран залуучуудын оролцоог хангах төлөвлөгөөг боловсруулна.
- ➔ **Үйл ажиллагаа 3:** Авлигатай тэмцэх байгууллагын дадлагажигчид байгууллагын төслийн ажилтан, худалдан авах ажиллагааны багт иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах гэрээнд тусгах ажлын даалгаврыг боловсруулах, худалдан авах ажиллагаа явуулах, хакатон тэмцээн зохион байгуулах, гурван загварт санаачилга(аппликейшин бүтээх шинэ санаа гаргах, хөгжүүлэх, нэвтрүүлэх)-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Гарц 2: Худалдан авах ажиллагааны талаарх ойлголт, иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.

- ➔ **Үйл ажиллагаа 1:** Иргэний нийгмийн байгууллага нь орон нутгийн залуучуудын сүлжээтэй хамтран гурван дүүрэг, хорин тосгонд олон нийтийг дайчлахаар гэрээ байгуулсан. Оролцогч талуудын дүн шинжилгээ, мэдлэг



ойлголтыг тодорхойлох судалгааг явуулж, олон нийтийн үйл ажиллагааны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, түүнд дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллээр хангана. Хорин тосгон дахь элч залуучуудыг сургаж, дайчилна.

- ➔ **Үйл ажиллагаа 2:** Гурван ахлах сургуультай хамтран авлигатай тэмцэх клуб байгуулах, сургалтын хэрэгцээг үнэлэх, орон нутгийн залуучуудын сүлжээ, авлигатай тэмцэх байгууллагын сургалтын багтай нягт хамтран ажиллаж, сургуулиудад авлигатай тэмцэх ажлыг турших залуучуудын сургалтын хөтөлбөрийг туршина (Энэ үйл ажиллагааг 70-71-р хуудсанд нарийвчлан авч үзэх болно).

Гарц 3: Төрийн худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна.

- ➔ **Үйл ажиллагаа 1:** Залуучуудыг хакатон тэмцээнд оролцож, 10,000 долларын сантай гурван шагналын төлөө өрсөлдөхийг урина. Тэдгээрээр цахим тендерийн систем (тосгоны буцалтгүй тусламжийн хувьд), их өгөгдөлд дүн шинжилгээ хийдэг программ хангамж, эсхүл бизнесийн мэдээлэл цуглуулах хэрэгслийг зохион бүтээлгэнэ.
- ➔ **Үйл ажиллагаа 2:** Хакатон тэмцээний ялагчид авлигатай тэмцэх байгууллагын төслийн удирдлагын багаас гурван загварт санаачилгын залуучуудын оролцоотой холбоотой бүрэлдэхүүн хэсэгт хяналт шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлж, вэбэд суурилсан худалдан авах ажиллагааны хэрэгслийг туршихад орон нутгийн залуучуудыг дайчлахад тусална.



АЛХАМ 4: ЗАЛУУЧУУДЫН ҮР ДҮНТЭЙ ОРОЛЦООГ ШАЛГАХ

Чиглүүлэх асуулт:

Үйл ажиллагаа (болон гарц) нь залуучуудын оролцоог үр дүнтэй болгох шаардлагыг хангаж байна уу?

Залуучуудыг татан оролцуулах хүсэл эрмэлзэл нь ихэвчлэн чин сэтгэлээсээ байдаг боловч хэрэгжилт нь бэлгэдлийн шинж чанартай байж болно. Үүний үр дүнд залуучууд ямар ч үр дүнтэй биш байдлаар оролцдог. Иймээс энэхүү эцсийн алхамд авлигатай тэмцэх байгууллага өөрсдийн сонгосон арга барил нь залуучуудын үр дүнтэй оролцоог дэмжсэн эсэхийг үнэлэх ёстой. Энэ алхмын үндэс суурь нь залуучуудын үр дүнтэй оролцооны үндсэн санаа (хүснэгт 1-ийг үзнэ үү) болон уг үндсэн санаатай үйл ажиллагаа, гарц хэрхэн тохирч байгааг нарийвчлан заасан хөтөлбөрийн тайлбар (жишээ нь, үзэл баримтлалын тэмдэглэл) юм. Энэ нь үйл ажиллагаа, үр дүн нь эдгээр үндсэн санаатай хэрхэн нийцэж байгааг нарийвчлан тодорхойлдог. Энэ хэсэгт таван үндсэн санаа тус бүрийг хянах зарчмуудыг тайлбарлаж, дараа нь онолын жишээг үзүүлэв. Залуучуудын үр дүнтэй оролцоонд тавих шалгалтыг хэрхэн хийх талаар дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү бодлогын гарын авлагын вэб порталаас (англи хэл дээр) олж үзэж болно.

Үндсэн санаа 1: Олон талт байдал ба тэгш оролцоо

Залуучуудын манлайлагчидтай хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр тодорхойлогдсон залуучуудын оролцоонд тулгарч буй бэрхшээлүүдийн нэг нь санхүүгийн эх үүсвэр болон нийгэм-улс төрийн харилцаа холбоо бүхий зарим “элит” залуучуудын талд зарим залуусын оролцоог хязгаарлах, улмаар нийгмийн эмзэг хэсгийн төлөөллийн бүлгүүдийг оролцуулахгүй байх эрсдэл юм. Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд “зөв суурьтай” (жишээ нь, хууль, эрх зүй болон төрийн удирдлагын тусгай мэдлэгтэй) залуучууд хамрагдах магадлал өндөр гэж үздэг бөгөөд өөр хэлбэрээр дэмжлэг үзүүлэх боломжтой, ердийн бус ур чадвар, уламжлалт бус мэргэжилтэй бусад залуучуудыг татан оролцуулахыг орхигдуулж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг бэрхшээлийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон тэдгээрийн асран хамгаалагчдын хоорондын эрх мэдлийн тэнцвэргүй байдлаас үүдэн авлигын эрсдэл үүсдэг болохыг судалгаа харуулж байна. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслан дэмжих зориулалттай хөрөнгийг шамшигдуулсан, хөгжлийн бэрхшээлтэй болохыг нотолсон баримт бичиг авах болон бусад эрх эдлүүлэхийн тулд хахууль авах гэх мэт болно. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон авлигын гэмт хэргийн талаар мэдээлэх чадварын хувьд саад бэрхшээлүүд учрах бөгөөд энэ нь мэдээлэх механизм нь тэдний хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, хамгаалалтын тусгай механизм дутмаг байгаатай холбоотойгоор үүсдэг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс авлигад ноцтой бөгөөд харьцангуй байдлаар өртөж болохыг харуулж байна.

²⁴ Chr. Michelsen Institute U4 Anti-Corruption Resource Centre, *Corruption and the equal enjoyment of rights for persons with disabilities*, U4 Helpdesk Answer, 29 April 2022.



Авлигад өртөж байгаа өөр нэг бүлэг бол эмэгтэйчүүд юм. Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс илүү авлигын гэмт хэрэг, зөрчилд холбогддог гэх нотолгоо байхгүй ч НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны (UNODC) “Цаг нь ирлээ: Авлигын жендертэй холбоотой асуудлыг анхааран авч үзэх нь” гэх гарчигтай нийтлэлд авлига нь олон нийгэмд бий болсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх мэдлийн тэнцвэргүй байдал, нийгмийн хэм хэмжээ, өргөн тархсан хүйсээр ялгаварлан гадуурхах үзлээс үүдэн авлига нь дэлхийн олон оронд эрэгтэй, эмэгтэй хүмүүст өөр өөрөөр нөлөөлдөг болохыг онцолсон байдаг.

Үр дүнтэй оролцоог бодитоор хангахын тулд залуучуудын бүлгийн доторх олон талт байдлын огтлолцлын хэмжигдэхүүнийг олж харах чухал юм. Ямар ч залуу хүн, ялангуяа авлигад бусадтай харьцуулахад бага өртөж буй хүмүүс авлигын асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах боломжтой байх нь чухал юм. Олон талт байдал, тэгш оролцоог бүх бүлэгт тохирсон арга барилаар дэмжих ёстой. Энд арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, хүйс, бэлгийн чиг хандлага зэрэг залуучуудтай холбоотой огтлолцлын асуудлыг харгалзан үзэх ёстой. Дээр тайлбарласны дагуу эдгээр бүлгүүдийн оролцоог хангахтай холбогдон гарах зардал өндөр байж болох бөгөөд боломжийг олгоход нэмэлт саад бэрхшээл тулгарч магадгүй юм. Жишээ нь:

- ➔ Өрхийн орлого багатай орон нутгийн сургуулиудтай хамтран ажиллахыг зорьж буй авлигатай тэмцэх байгууллага залуу хүн авлигатай тэмцэх сайн дурын үйл ажиллагаанд оролцсоноор ямар нэг ажил хийх, гэр бүлээ халамжлах зэрэг бусад зүйлээ алдаж байгаа эсэхийг анхаарч тооцох хэрэгтэй.
- ➔ Жендерийн тэгш бус байдал ноцтойд тооцогдох орон нутагт залуу эмэгтэйчүүдийн үйл ажиллагаа шөнө тохиох, эсхүл ганцаараа явах шаардлагатай үед гэр орны ажлаа хийх, гэр бүлээ асрамжлах үүрэгтэй нь зөрчилдөж, сайн дураар оролцох боломж хомс байдаг.
- ➔ Зохион байгуулагчид хөгжлийн бэрхшээлтэй залуучуудтай хийх арга хэмжээг төлөвлөхдөө ямар арга хэрэгсэл, арга барил, байгууламж тохиромжтой болохыг анхаарч үзэх хэрэгтэй.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх байгууллагууд нь өөр өөр нийгмийн гаралтай, янз бүрийн түвшний оролцооны боломжтой залуучуудыг тэгш боломжоор хангах ёстой. Байгууллагын стратеги нь зорилтот бүлгийн залуучуудын оролцоог хангахаас гадна эдгээр нийгмийн бүлгийг өөрсдийг нь тэдний нөхцөл байдлыг харгалзан үзэж, эдгээр үйл ажиллагаанд оролцох нөхцөлөөр хангах ёстой.

Хэрэгжилтийг үнэлэх тухай зааварчилгаа: Хамрагдаж буй залуучуудын дийлэнх хэсэг нь хүн ам зүйн өөр өөр бүлэг болон нийгмийн эмзэг бүлгийн төлөөлөл эсэхийг шалгах



- ➔ Залуучуудын оролцоонд суурилсан оролцогч талуудын дүн шинжилгээ нь залуучуудын үр дүнтэй оролцоотой холбоотой авлигатай тэмцэх байгууллагын олон талт байдал, тэгш оролцоог хангах шаардлагуудыг тодорхойлсон бөгөөд үүнд залуучуудын оролцоо чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Үндсэн санаа 2: Оролцох нөхцөлийг хангах орчин

Залуучуудын үр дүнтэй оролцоог дэмжих зорилгод хүрэхэд орчин нөхцөл чухал ач холбогдолтой. Өсвөр үеийнхний үр дүнтэй оролцоог хангах таатай орчныг бүрдүүлэх нь дараах хоёр талтай. Үүнд:

- ➔ Залуучуудыг татан оролцуулах байгууллагын хувьд залуучуудын оролцоог хангахтай холбоотой нөөц, боловсон хүчний чадавх, техникийн мэдлэг зэрэг байгууллагын бэлэн байдал.
- ➔ Залуучууд орцод хувь нэмэр оруулах, эдгээр орцын талаар нухацтай авч үзэхэд нь шийтгэл, ялгаварлан гадуурхлаас ангид байлгах аюулгүй орон зай байгаа эсэх.

Эдгээрийг 3А бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх байгууллагууд оролцох нөхцөлийг хангах таатай орчныг бүрдүүлэхийн тулд залуучуудыг үр дүнтэй оролцуулах хүчин чармайлтыг дэмжих, ийнхүү дэмжих байгууллагын бэлэн байдлыг бэхжүүлэх, түүнд оролцож буй залуучуудын аюулгүй байдлыг хангахад анхаарах.

Хэрэгжилтийг үнэлэх тухай зааварчилгаа: Залуучуудын оролцоог хангах үйл ажиллагаанд стратегийн уялдаа холбоо байгаа эсэхийг тодорхойлж, залуучуудын оролцоог дэмжих тогтолцоо, үйл явцыг шинэчилж, залуучуудын оролцоог хангах чиглэлээр ажиллах ажилтнуудад хангалттай нөөц (санхүүгийн болон хүний нөөц гэх мэт) байгаа эсэхийг баталгаажуулах. Залуучуудын оролцоог хангах санаачилгад тохирсон залуучуудыг хамгаалах бодлого, эсхүл журам байгаа эсэхийг тодорхойлох.

**Үндсэн санаа 3: Үе үеийн төлөөлөл хоорондын хамтын ажиллагаа (буюу түншлэл)**

Авлигатай тэмцэхэд авлигатай тэмцэх байгууллага, залуучууд хамтран ажиллах нэгдсэн хүчин чармайлт гаргахыг шаарддаг. Ийм хамтын ажиллагааг хөгжүүлэх нэг арга бол залуучууд болон авлигатай тэмцэх байгууллагад харилцан ашигтай хамтын ажиллагааны хэлбэрийг илэрхийлдэг хамтын үнэ цэнэ бүхий түншлэл юм. Энэ нь хоёр талд оролцож буй хувь хүн, эсхүл бүлгүүдийн давуу талыг ашиглах боломжтой бөгөөд ингэснээр хамтын ажиллагаа нь бүгдэд нь өгөөжөө өгөх болно.

Тухайлбал, авлигатай тэмцэх байгууллагууд авлигатай тэмцэх бодлогын төслийг боловсруулахдаа дадлагажигч, эсхүл залуу ажилтнуудыг татан оролцуулах асуудлыг авч үзэж болно. Байгууллагууд ийм үйл явцын эхний үед залуучуудын үзэл бодлыг тусгаснаар тэдний судалгаа шинжилгээ, харилцааны ур чадвар нэмэгдэх ашиг тустай. Хариуд нь залуучууд бодлого боловсруулахтай холбоотой ур чадвар, туршлага хуримтлуулж, хамтран ажилладаг ахмад ажилтнуудаас суралцаж, чухал зүйлд хувь нэмрээ оруулж буйгаа мэдэрдэг.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх байгууллага залуучууд болон ахмад ажилтнууд нэг зорилгод ижил хувь нэмэр оруулж, харилцан ашиг хүртэх хамтын ажиллагааг дэмжих стратегийг анхаарч үзэх хэрэгтэй.

Хэрэгжилтийг үнэлэх тухай зааварчилгаа: Залуучуудтай хамтран ажиллах одоо байгаа арга замыг эргэн харж, ийм санаачилга нь оролцож буй залуучууд болон байгууллагын аль алинд тодорхой ашиг тус хүргэж байгаа эсэхийг тодорхойлох.



Үндсэн санаа 4: Залуучуудын үр дүнтэй оролцоо

Авлигатай тэмцэх байгууллага залуучуудыг аливаа санаачилгын янз бүрийн үе шатанд оролцох зохих боломжийг бүрдүүлж, яагаад залуучуудыг оролцуулж байгаа, тэдгээрийн саналыг нь хэрхэн ашиглах талаар ойлголттой байх ёстой.

Залуучуудыг аль нэг байгууллагын ажилд хувь нэмрээ оруулж байна уу гэдгийг харгалзалгүйгээр өрөө дүүргэх, шаардлагад нийцүүлэх “тоонд хүргэх” гэж үзэх нь тэдний идэвхийг сулруулж, тус байгууллагаар үйлчлүүлдэг хүн амын зонхилох хэсгийн дунд нэр хүнд унах, итгэлийг алдах аюултай. Үнэн хэрэгтээ бэлгэдлийн шинжтэй оролцооны эрсдэл нь залуучуудын авлигын эсрэг санаачилгад нэгдэх сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Өөрөөр хэлбэл, залуучууд өөрсдийгөө ашиглаж байна гэж ойлговол олгож байгаа боломжийн бодит гэдэгт итгэхгүй, авлигатай тэмцэх байгууллага өөрсдийнх нь амьдралд сайнаар нөлөөлнө гэдэгт эргэлзэж, цаашид энэ төрлийн арга хэмжээнд оролцохгүй байх магадлал өндөр болдог.

4 дэх үндсэн санааны суурь зарчим нь залуучуудад олгох боломж нь авлигатай тэмцэх ажилд хамааралтай байх бөгөөд тэдний чадавхад нийцсэн, хэрэгжүүлж болохуйц байх ёстой.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх байгууллагууд дүр эсгэсэн бэлгэдлийн шинжтэй оролцооноос зайлсхийхийн тулд залуучууд байгууллагын үйл ажиллагааг идэвхгүй байр сууринаас хүлээн авахаас илүүтэйгээр үүрэг хүлээж бодитойгоор оролцох боломжийг бүрдүүлэх ёстой. Энэ нь залуучуудын мэргэжил, ур чадварыг харгалзан байгууллагын өмнөө тавьсан зорилгод хүрэхийн тулд юу хийж болох талаарх бодит ойлголттой тэнцвэртэй байх ёстой.

Хэрэгжилтийг үнэлэх тухай зааварчилгаа: Залуучууд авлигын эсрэг үйл ажиллагаанд дадлагажигч, сайн дурын ажилтан, зөвлөх, түнш, санаачилга удирдагч гэх мэт оролцооноос гадна өөр ямар үүрэг гүйцэтгэж байгааг тодорхойлох. Залуучуудын оролцоог тогтмол хангах бүтэц бий эсэхийг үнэлэх.



Үндсэн санаа 5: Залуучуудыг чадавхжуулах

Залуучуудыг чадавхжуулах нь гурван түвшинд явагддаг ба эдгээр түвшин бүр нь ялгаатай боловч бие биеэ бататгаж, үр дүнд нь оролцож буй залуучуудын хувь хүний өсөлт хөгжилд төдийгүй нийгмийн бүлгийн түвшний хийгээд нийгмийн өөрчлөлтийг бий болгодог. Жишээлбэл:

- ➔ **Хувь хүний хөгжил:** Авлигын эсрэг санаачилгад оролцсоны үр дүнд залуучууд өөртөө итгэх итгэл, мэдлэг, ур чадвар, тэдний өсөлт хөгжилд хувь нэмэр оруулах харилцаа холбоотой болно. Тэд авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хэдий чинээ гүнзгий оролцоно, тэдэнд төдий чинээ хувь хүний хувьд хөгжих боломж нь нэмэгдэнэ. Тухайлбал, оролцогч нь сургуульд суурилсан сургалтын хөтөлбөрт хамрагдсанаар авлигын эсрэг үзэл баримтлалын талаар шинэ мэдлэг олж авах бол ийм арга хэмжээг зохион байгуулахад тусалдаг сайн дурын ажилтан, эсхүл дадлагажигч нь төслийн менежмент, арга хэмжээ зохион байгуулах, оролцогч талуудын оролцоог хангахтай холбоотой ур чадварыг эзэмшинэ. Энэхүү аргын ашиг тусыг мэдэрсэн залуучууд насанд хүрснийхээ дараа ажил мэргэжлээрээ залуучуудыг чадавхжуулах ажлыг дэмжигчид болж, байгууллагадаа манлайлагч болох магадлал өндөр байна.
- ➔ **Нийгмийн бүлгийн түвшний өөрчлөлт:** Авлигын эсрэг санаачилгад хамрагдснаар хувь хүний хувьд хөгжсөн залуучууд өөрчлөлтөд нөлөөлөх зорилгоор олж авсан мэдлэгээ ашиглах урам зоригтой болдог. Энэ нь тэд холбогдох хөтөлбөр, үйл ажиллагаанд илүү оролцох (жишээ нь, сайн дурын ажилд бүртгүүлэх), эсхүл нийгэмдээ өөрсдийн санаачилгаар манлайлах хэлбэрээр илэрч болно.
- ➔ **Нийгмийн өөрчлөлт:** Хувь хүний хөгжил, залуучуудын оролцоог дэмжсэн нийгмийн бүлгийн түвшний өөрчлөлтийн үр дүнд нийгэмд үнэ цэнтэй гишүүн нэмэгдэнэ. Залуучууд өөрсдийн нөлөөллийн хүрээнд илүү хүчтэй дуу хоолойтой болж, бусдад урам зориг өгч, сонирхогч талуудтай илүү хамтран ажиллаж, тэдгээр сонирхогч талууд болон бодлого боловсруулагчидтай бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой болдог.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх байгууллагууд нь залуучуудын оролцоог хангах үйл ажиллагааг хамтран төлөвлөхдөө залуучуудыг чадавхжуулах боломжийг хөтөлбөрт зорилготойгоор тусгах ёстой. Эдгээр боломж нь ямар байх талаар залуучуудаас санал авах нь сайн туршлага юм. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд өндөр түвшинд чадавхжуулсны үр дүн (жишээ нь, нийгмийн бүлгийн түвшний өөрчлөлт, нийгмийн өөрчлөлт) илрэн гарахгүй байж болохыг санаарай.

Хэрэгжилтийг үнэлэх тухай зааварчилгаа: Авлигатай тэмцэх байгууллагатай явуулсан урт хугацааны түншлэлийн үр дүнд залуучуудад үзүүлэх үр өгөөжийг тодорхойлсон тохиолдолд эдгээр нь чадавхын гурван түвшинд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх.



ОНОЛЫН ЖИШЭЭ

Алхам 4

Гурван ахлах сургуульд авлигын эсрэг клуб байгуулахыг дэмжих үйл ажиллагаа (62-р хуудасны гарц 2) залуучуудын үр дүнтэй оролцооны зарчмуудад нийцэж байгаа эсэхийг нягтлахын тулд авлигатай тэмцэх байгууллагууд дараах байдлаар ажиллаж болно. Үүнд:

1. Олон талт байдал ба тэгш оролцоо

Оролцож буй залуучуудын нэлээд хэсэг нь хүн ам зүйн өөр өөр гарал үүсэлтэй бүлэг, эмзэг бүлгийнхнээс бүрдэх эсэхийг **шалгаарай**.

Үр дүн: Оролцогч талуудын шинжилгээнд авлигын эсрэг клубийн гишүүдийн 40-с доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх ёстой бөгөөд эмзэг бүлгүүдээс хороодод төлөөлөх орон тоог хадгалсан байхыг шаарддаг. Авлигын эсрэг сургалт, сурталчилгааг үндэсний болон орон нутгийн цөөнхийн бүлгийн хэл дээр гаргаж, цахим хуудас, хэлэлцүүлгийн материалд дохионы хэлний орчуулгыг оруулсан байх ёстой. Авлигын эсрэг клубийн тохижилт, арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад хүртээмжтэй байх ёстой бөгөөд оюуны бэрхшээлтэй залуучуудын хэрэгцээг харгалзан үзсэн байвал зохино.

2. Оролцоог хангах таатай орчин

Залуучуудын оролцоог дэмжих тогтолцоо, үйл явц нь залуучуудын үр дүнтэй оролцоог хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд хангалттай нөөцтэй эсэх, залуучуудын оролцоог хангах чиглэлээр ажиллах ажилтнуудад зохих нөөцийг хуваарилсан эсэх, залуучуудыг хамгаалах зохион байгуулалтын бодлого байгаа эсэхийг **шалгаарай**.

Үр дүн: Авлигын эсрэг клубүүдийн үйл ажиллагааны стандарт удирдамжийг сургуулиуд болон залуучуудын төлөөлөл хамтран боловсруулахад залуучуудын чиглэлээр мэргэшсэн зөвлөхийг татан оролцуулж, авлигатай тэмцэх байгууллага хоёр жилийн гарааны санхүүжилт, урт хугацаанд авлигын эсрэг клубүүдтэй тогтмол хамтран ажиллах талаар байгууллагын зүгээс амлалт өгөх үүрэг хүлээдэг. Авлигын эсрэг клубүүдийг хамгаалах журмыг бий болгож, тогтмол бие даасан аудитыг жилд нэгээс доошгүй удаа явуулна.

3. Үе хоорондын хамтын ажиллагаа

Залуучуудтай хамтран ажиллах одоогийн аргуудаа шалгаж, үүнд хамрагдаж буй залуучууд болон авлигын эсрэг клубүүдийн аль алинд нь тодорхой ашиг тустай эсэхийг **тодорхойлоорой**.



Үр дүн: Авлигатай тэмцэх байгууллагын хяналт дор авлигын эсрэг клубүүд үйл ажиллагаагаа зөв чиглүүлж, нийгэм дэх авлигын гол асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор үе үеийн төлөөлөл бүхий оролцооны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

4. Залуучуудын оролцоо

Залуучууд авлигатай тэмцэх үйл ажиллагаанд оролцохоос гадна өөр үүрэг гүйцэтгэж байгаа эсэх, мөн тухайн байгууллагад залуучуудын оролцоог тасралтгүй хангах бүтэц бий эсэхийг **шалгаарай**.

Үр дүн: Авлигын эсрэг клубүүд залуучуудын идэвхтэй оролцоог дэмжиж, төрийн үйлчилгээг сайжруулахад хувь нэмрээ оруулснаар залуучууд өөрсдийн үүрэг хариуцлагад үнэлэмжийг нэмдэг. Байгууллагын оролцоог хангах урт хугацааны хамтын ажиллагааны төлөвлөгөөний нэг хэсэг нь залуучуудын амьдралд нөлөөлж буй төрийн үйлчилгээний үндсэн чиглэлүүдтэй холбоотой үе үеийн төлөөллийг оролцуулсан байнгын авлигын эсрэг хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааг тодорхойлох явдал юм.

5. Залуучуудыг чадавхжуулах

Залуучуудын үе үеийн төлөөлөл бүхий түншлэлээс хүртэж буй үр өгөөж нь хувь хүний, нийгмийн бүлгийн болон нийгмийн гэсэн гурван түвшинд залуучуудыг чадавхжуулахад хувь нэмэр оруулж байгаа эсэхийг **шалгаарай**.

Үр дүн: Авлигын эсрэг клубүүдийн залуучуудыг эдгээр клубийн гишүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг (хувь хүний) боловсруулж, сургуулийн захирлын зөвлөл, эцэг эхийн холбоодтой албан ёсны холбоо тогтоох, оролцогч талуудын дүн шинжилгээгээр тодорхойлсон орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллах (нийгмийн), мөн авлигатай тэмцэх үндсэн сэдвийн хүрээнд олон нийтийг соён гэгээрүүлэх кампанит ажлыг явуулах (нийгмийн бүлгийн) замаар чадавхжуулна.

Алхам 4-ийн үр дүн

Залуучуудын үр дүнтэй оролцоог шалгаснаар сонгосон арга нь залуучуудын үр дүнтэй оролцоонд тавигдах шаардлагыг хангаж байгааг баталж байна. Залуучуудын үр дүнтэй оролцоог хангах, оролцоог оновчтой хянах, үнэлэх, сургах суурь түвшин тодорхойлохын тулд санаачилгын үзэл баримтлалын тэмдэглэлд зарим нэмэлт мэдээллийг оруулж болно.

Сонгосон үйл ажиллагаа, гарцад хийсэн шалгалтаар залуучуудын үр дүнтэй оролцооны талаар асуудал, бэрхшээл байгаа гэж үзвэл авлигатай тэмцэх байгууллагууд алхам 3-ыг дахин хийвэл зохино.



ЗВ. ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, АМЖИЛТАА ҮНЭЛЭХ, ТУРШЛАГААС СУРАЛЦАХ

Авлигатай тэмцэх ажлыг үнэлэхэд хүндрэл учирдаг тул авлигатай тэмцэх байгууллагын хувьд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, суралцах, ялангуяа хөндлөнгийн оролцооны үр нөлөө болон үр дагаврыг хэмжих, үнэлэх асуудал бэрхшээл дагуулсаар байдаг. Авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэхэд авлига, авлигатай тэмцэх ажлыг нотлох баримтад тулгуурлан хэмжих нь чухал талаар олон улсын авлигатай тэмцэх нийгэмлэг нэгдсэн байр суурьтай байна. Гэвч энэ зорилгод үйлчлэх цогц, практик тогтолцоо бүрдээгүй байна.

Энэхүү гарын авлагад заасан удирдамжийн дагуу залуучуудын оролцоог тэдний зорилгыг өөрчлөхгүйгээр илүү үр дүнтэй болгохын авлигатай тэмцэх байгууллагын ажилд нэгтгэх ёстой аж. Өөрөөр хэлбэл, залуучуудыг татан оролцуулж буй авлигатай тэмцэх байгууллага нь авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, бууруулах зорилгоо өөрчилдөггүй. Залуучуудын үр дүнтэй оролцоо нь энэ зорилгод хүрэх арга хэрэгсэл бөгөөд авлигатай тэмцэх байгууллагад авлигатай тэмцэх зорилгодоо илүү үр дүнтэй хүрэхэд нь дэмжлэг болдог. Өөрчлөлтийн онолын дагуу залуучуудын оролцооны бүрэлдэхүүн хэсгүүдийн үр дүн, нөлөөллийн түвшнийг өөрчлөхгүйгээр үйл ажиллагаа, гарцын түвшинд нэмж болдог.

Залуучуудын ийм оролцооны амжилтыг зохих ёсоор үнэлэхийн тулд авлигатай тэмцэх байгууллагын ажлыг залуучуудын оролцоотой харьцуулсан үр дүнд суурилсан үнэлгээ шаардлагатай. Гэсэн хэдий ч одоогийн байгаа судалгааны төрөл, авлигатай тэмцэх байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавх техникийн мэдлэг, санхүүгийн эх үүсвэрийн хувьд хязгаарлагдмал байдаг тул ийм оролдлого хэтэрхий нарийн төвөгтэй бөгөөд нөөц их шаардахыг харж болно. Мөн авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийхэд хангалттай мэдээлэл байдаггүй нь ийм арга хэмжээний үнэ цэнийг хязгаарлаж байна.

Тиймээс авлигатай тэмцэх байгууллага нь зохих шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, мэдээллийн эх сурвалжийг сонгох замаар залуучуудын оролцоонд хяналт шинжилгээ хийхэд анхаарах ёстой. Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтэд тавигдах хяналт шинжилгээний ерөнхий шаардлагуудаас²⁵ гадна залуучуудын оролцооны үйл ажиллагаа, гарцыг хянахтай холбоотой дараах хүчин зүйлсийг анхаарч үзэх боломжтой. Үүнд:

Үр дүнд чиглэсэн байх: Гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг нарийвчлан боловсруулснаар үр дүнтэй оролцоог дэмжиж чадна. Бэлгэдлийн шинжтэй болон

²⁵ Тухайлбал, тэдгээр нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болох, үндэслэлтэй, хэрэгжих хугацаатай (SMART) байх ёстой бөгөөд хэмжиж байгаа зүйлийн чиглэл, эсхүл зорилтот үнэлэмжийг агуулаагүй байвал зохино.



жишиг үйл ажиллагаа, гарцыг шалгуур үзүүлэлт болгон ашиглахгүй байгааг баталгаажуулахын тулд залуучуудын үр дүнтэй оролцоог үнэлэх нь чухал.

Авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд залуучуудын гүйцэтгэх үүрэг, залуучуудын үр дүнтэй оролцооны таван үндсэн санааны дагуу ангилсан залуучуудын үр дүнтэй оролцоог хэмжиж болох шалгуур үзүүлэлтийн жишээг энэхүү бодлогын гарын авлагын веб портал дээр нийтэлсэн болно.

Харилцааны хувьд оролцооны ашиг тусыг авч үзэх: Залуучуудыг татан оролцуулах нь авлигатай тэмцэх байгууллагуудын хувьд үндэсний болон олон улсын түвшинд тухайн сэдвийг нэн тэргүүнд тавьж байгаа өнөөгийн нөхцөл байдлыг ашиглах боломж юм. Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд болон авлигатай тэмцэх байгууллагаас гаргаж буй мэдээлэл өгөгдлийг хэвлэн нийтлэх, мэдээлэл солилцоход ашиглах боломжтой байхаар төлөвлөх ёстой. Гаднын үзүүлэлтүүдийг (Тогтвортой хөгжлийн зорилтууд гэх мэт) шууд тусгах, эсхүл авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг тэдгээртэй шууд холбох нь байгууллагад ажлаа эерэгээр харуулахад тусална.


Мэдээллийн эх сурвалж: Хяналт шинжилгээ хийхэд шаардлагатай дотоод өгөгдөл мэдээлэл нь авлигатай тэмцэх байгууллагын мэдлийн хүрээнд байна. Энэ өгөгдөл мэдээлэл нь залуучуудын оролцоотой холбоотой үйл ажиллагаа, гарцыг тодорхойлсон захиргааны гаралтай мэдээлэл, эсхүл байгууллагын үйл ажиллагааны шууд үр дүнгээс бүрдэнэ. Авлигатай тэмцэх байгууллага нь залуучуудын оролцооны тухай зураглалд хяналт тавихын тулд бусад байгууллага, үйл явцын нөлөөлөлд байдаг гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг авч хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Үндэсний статистик, тоо баримт зэрэг үндэсний хэмжээний мэдээллийн эх сурвалжууд нь авлигатай тэмцэх байгууллагын дотоод мэдээллийн дутууг нөхдөг. Гаднын шалгуур үзүүлэлтүүд, тухайлбал олон улсын засаглалын үзүүлэлтүүд нь тэдгээрийн ашигладаг арга зүйгээс шалтгаалан авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлэхэд хэрэг болохуйц мэдээлэл өгөгдлийг өгч чаддаггүй.²⁶

²⁶ United Nations Development Programme, *Strategic Programming of Anti-Corruption Agencies*.



Туршлагаас суралцах: Нөөц ашиглах үндэслэлийг тогтоох, ажлын амжилтыг баталгаажуулахаас гадна суралцах нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийх гол шалтгаануудын нэг юм. Хэдийгээр энэ нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөмж боловч авлигатай тэмцэх байгууллагууд олж авсан сургамжийг идэвхтэй тодорхойлж, ажлаа сайжруулахад ашиглахад чиглэсэн зохион байгуулалттай, институцичлэгдсэн аргачлалыг хэрэглэсэн талаар хангалттай нотлох баримт гаргаж байгаагүйг бидний судалгаа харуулдаг. Эсрэгээрээ амжилт, эсхүл бүтэлгүйтлээс суралцах оролдлого нь түр зуурын, зохион байгуулалтгүй байдлаар явагддаг. Иймд авлигатай тэмцэх байгууллага нь залуучуудын үр дүнтэй оролцоог бий болгоход чиглэсэн хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаандаа сургалтын бүрэлдэхүүн хэсгийг тодорхой тусгах хэрэгтэй. Олж авсан сургамжаа тодорхойлон, эерэг, эсхүл сөрөг үр дүнтэй зохион байгуулсан залуучуудын оролцооны санаачилгад тулгуурлан ажиллах нь яваандаа үйл ажиллагааг сайжруулна. Энэ нь авлигатай тэмцэх байгууллагад дараах хоёр түвшинд дэмжлэг болдог. Үүнд: Авлигатай тэмцэх байгууллагуудад институцийн механизмыг бий болгох буюу сайжруулах (байгууллагын түвшин), залуучуудын оролцоог амжилттай хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх (үйл ажиллагааны түвшин) гэсэн хоёр түвшин болно.

Байгууллагын бэлэн байдлыг давтамжтайгаар шалгах: Авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудыг бодитойгоор татан оролцуулахад шаардлагатай стандартад нийцсэн эсэхийг баталгаажуулахын тулд байгууллага нь институцийнхээ гол идэвхжүүлэгчид болон тэдгээрийн хүрэлцээтэй болон хангалттай байдлыг тогтмол үнэлж байхыг зөвлөж байна. Залуучуудын оролцоог хангах стратегийн ажлыг төлөвлөх дасгалын нэг хэсэг болох байгууллагын бэлэн байдлын анхан шатны үнэлгээний дараа зөвлөмжид жил бүр хяналт шинжилгээ хийж байх ёстой. Нэмж дурдахад, авлигатай тэмцэх байгууллагыг явц байдлын талаар сайтар мэдээллээр хангахын тулд гурван жилийн дараа, эсхүл зохих завсарлага авсны дараа байгууллагын бүрэн үнэлгээг хийж байх хэрэгтэй. Зохих хяналтыг байгууллагын ажилтнууд болон “итгэл хүлээхүйц” залуучуудын сүлжээ, түншүүдийн оролцоо, санал хүсэлтийн дагуу хийж болно.



4


УРАГШЛАХ ЗАМ



Дөрөвдүгээр бүлэг: Урагшлах зам

Энэхүү гарын авлагыг боловсруулахад зориулж хийсэн судалгаа нь авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын үр дүнтэй оролцоог нэмэгдүүлэх асар их боломжийг тодорхойлсон. Авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд залуучуудыг татан оролцуулахад тулгарч буй зарим сорилт, бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг болж, энэ үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна. Хэдийгээр авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын оролцоо өндөр байгаа боловч авлигатай тэмцэх байгууллагууд энэхүү цар хүрээг илүү өргөжүүлэх боломжууд бий. Илүү олон байгууллагууд залуучуудыг татан оролцуулж эхлэх бөгөөд оролцоог хангах ажлыг хийж байгаа хүмүүс тэдний оролцоог сайжруулахад чиглэсэн оновчтой арга замыг хэрэгжүүлснээр хүчин чармайлтыг сайжруулж чадна. Энэ нь авлигатай тэмцэхэд чадавхын болон нөөцийн дэмжлэгийг нэмэгдүүлэх болно.

Энэхүү бодлогын гарын авлага нь эцсийн шийдэл биш бөгөөд авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд залуучуудыг үр дүнтэй татан оролцуулахад дэлхийн тавцанд хүргэх гишгүүр юм. Энэ санаа нь дэлхийн бүх байгууллагуудын, тэр дундаа авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын тулгамдаж буй асуудлын жагсаалтын дээгүүрт бичигддэг. Гэсэн хэдий ч авлигатай тэмцэх байгууллагуудын залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилго, эрмэлзэл өндөр байгаа боловч хэрхэн нэмэгдүүлэх талаарх мэдлэг, чадавх, судалгаа бага байгаад ялгаа бий. Өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн энэхүү гарын авлага нь авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын оролцоог хэрхэн нэмэгдүүлэх талаар анхан шатны чиглэл, удирдамжуудыг өгсөн. Бусад салбар, институцид ч залуучуудын оролцоо, хүчин чармайлтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно. Сайн туршлагауд болон мэдлэгийг шинэчлэн нэвтрүүлснээр авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг болно.





Үйл ажиллагааны уриалга:

Хэрэгцээ шаардлага нэмэгдсэн

Техникийн нөөцүүд:

Залуучуудыг татан оролцуулахыг зорьж буй байгууллагуудад байгууллагын бэлэн байдлын үнэлгээ хийх, бэлэн байдлыг сайжруулахын тулд бодит нөхцөл байдалтай уялдуулан хэрэгжүүлэх арга хэрэгсэл хэлбэрээр заавар, дэмжлэг хэрэгтэй бөгөөд “итгэл хүлээхүйц” залуучуудын сүлжээг бий болгох, кейс судалгаа, сайн туршлагын жишээ, түүнчлэн сургалт, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг бий болгох, сайн туршлага, сургамжийг үе хооронд тогтмол хуваалцахад дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Нэмж дурдахад, авлигатай тэмцэх ажил, авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагааны бодит мэдээлэлд суурилсан залуучуудын амжилттай үр дүнтэй оролцоо, үр нөлөөг хэмжихэд ашиглах гол хүчин зүйлсийг илүү сайн ойлгохын тулд шаардлагатай олон судалгаа хийх хэрэгтэй.

Энэхүү дөрөвдүгээр бүлгийн үндсэн зарчим нь залуучуудад олгох боломж нь авлигатай тэмцэх ажилтай холбоотой, тэдгээрийг дэмжих, чадавхад нь нийцсэн байх ёстой гэж үздэг.



**Санхүүгийн нөөц болон техникийн дэмжлэг:**

Авлигатай тэмцэх олон байгууллага чадавхыг бэхжүүлэхээс гадна өөрийн үйл ажиллагаандаа залуучуудын оролцоог бодитоор хэрэгжүүлэхийн тулд, ялангуяа ажил эхлүүлэхэд санхүүгийн дэмжлэг болон техникийн туслалцаа шаардлагатай байдаг. Энэхүү гарын авлагад дурдсанаар эхний удаад байгууллагуудаас залуучуудын оролцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлтыг шаардах боловч энэ нь эргээд тэдэнд үр өгөөжөө өгөх болно. Энэ нь авлигатай тэмцэх байгууллагууд гадны тусламжгүйгээр даван туулах боломжгүй, хүчин чармайлт шаардсан ажил юм.

Төслийн түншүүд болон энэхүү гарын авлагын судалгаа, боловсруулалтад оролцсон байгууллагууд нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд залуучуудын оролцоог идэвхжүүлж, дэмжлэгийг бэхжүүлэхийг авлигатай тэмцэх байгууллагуудад уриалж, тууштай ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.

АЭБДХ нь энэхүү гарын авлагатай уялдуулан, авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх талаарх нэгдсэн мэдээллийг дэлхий дахинд түгээх зорилгоор вэб порталыг үүсгэсэн. Энэхүү портал нь авлигатай тэмцэх байгууллагууд болон бусад авлигатай тэмцэгчид хоорондоо мэдлэг мэдээлэл, сайн туршлага, арга барил, нөөц бололцоогоо хуваалцах боломжтой төвлөрсөн цахим платформ байх болно. Мөн АЭБДХ нь сургалтын хөтөлбөр, семинар, хурлаар дамжуулан дэлхийн өнцөг булан бүрд байгаа авлигатай тэмцэх байгууллагуудтай залуучуудын оролцоог дэмжих туршлагаа идэвхтэй хуваалцдаг.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба нь залуучууд, соён гэгээрүүлэгч нарын төлөөлөл бүхий оролцогч талуудын чадавхыг хөгжүүлэх арга хэрэгслээр хангаж, авлигатай тэмцэх байгууллагуудад авлигын эсрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Авлигын эсрэг боловсрол олгох болон залуучуудыг чадавхжуулах Дэлхийн нөөцийн санаачилга нь сурган хүмүүжүүлэгчид, эрдэмтэн, судлаачид, залуучууд, авлигатай тэмцэх байгууллагуудын хамтын ажиллагааны талаарх мэдлэг, туршлагыг олон улсын хамтын нийгэмлэгт хүргэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд боловсрол олгох, залуучуудыг чадавхжуулах, авлигаас татгалзах соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.





Авлигатай тэмцэх үндэсний байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудыг татан оролцуулах, тэдний хүчин чармайлтыг бэхжүүлэх талаар хүсэл зоригоо илэрхийлж, олонхи улс орнуудаас өөрсдийн бодит кейсэд суурилсан туршлагаа сургамж болгон оруулсан байна.

Залуучуудын зөвлөх хороо нь энэхүү гарын авлагыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, залуучуудыг эхнээс нь үндэсний болон олон улсын түвшинд үйл ажиллаганыхаа нэг хэсэг болгох зорилгоор дэлхийн форум хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. Энэ форумыг өргөжүүлэх, ялангуяа үндэсний түвшинд ижил бүтцийг болгох нь нэн чухал юм. Мөн Залуучуудын зөвлөх хорооноос энэхүү гарын авлагыг боловсруулан гаргасныг үнэлж, энэхүү гарын авлагыг дагаж мөрдөн, хэрэгжүүлэхэд чиглэсэн уриалгыг бэлтгэсэн (VII хуудсыг үзнэ үү). Залуучууд авлигатай тэмцэх эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох, дэмжих талаарх хүсэл эрмэлзлээ байнга илэрхийлсээр ирсэн.

Төслийг эхлүүлэхийн өмнө энэ чиглэлээр мэргэшсэн, өргөн мэдлэгтэй 18 мэргэжилтэн болон Залуучуудын зөвлөх хорооны 9 гишүүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн багийг байгуулсан. Энэхүү шинжээчдийн баг нь уг төсөлд залуучуудын оролцоог хангах чиглэлээр байгуулагдсан олон улсын хамтын нийгэмлэгийг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ баг нь энэхүү төслийн хүрээнд боловсруулсан гарын авлагын дагуу авлигатай тэмцэх байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээдэг.

Энэхүү гарын авлага нь дэлхийн улс орнуудын авлигатай тэмцэх байгууллагуудаас авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудыг татах оролцуулах, оролцоог хангах чиглэлээр өрнүүлэх аяны эхний алхмыг хийхэд дэмжлэг болно гэж найдаж байна. Эдгээр түншүүд, тэр дундаа авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд энэ асуудлыг хөндөж, сайн туршлагаа хуваалцах, харилцан суралцах талаар сонирхол, урам зоригийг нэмэгдүүлсэн. Энэхүү гарын авлага нь авлигатай тэмцэх байгууллагуудад авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, сайжруулахад чиглэсэн олон улсын болон улс хоорондын сүлжээг бий болгоход ихээхэн түлхэц болно гэж үзсэн төдийгүй авлигаас урьдчилан сэргийлэхэд залуучуудын оролцоог дэмжих чухал асуудлын талаарх мэдлэг мэдээлэл, санал санаачилгыг нэвтрүүлэхээр зорьж буй байгууллагуудад анхны чухал баримт бичиг байх болно.

Хавсралт I: Судалгааны арга зүй ба мэдээлэл цуглуулах

Энэхүү гарын авлагыг боловсруулахад зориулан хийсэн судалгаа нь үйл ажиллагаа бүрийг сонгон авсан, дараалсан холимог аргачлалын дагуу хийгдсэн бөгөөд судалгааны дараагийн шатанд дамжуулах мэдээллийг цуглуулах зорилготой хийгдсэн. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2022 оны 09 дүгээр сараас 2023 оны 02 дугаар сарын хооронд үндсэн болон хоёрдогч мэдээллийг цуглуулах гурван үе шаттайгаар зохион байгуулсан (доорх хүснэгт 6-г үзнэ үү).

Хүснэгт 6: Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа ба үр дүн

Үе шат	Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа	Үр дүн
Үе шат 1: Баримт бичгийн шинжилгээ Цаг хугацаа: 2022.09-10 сар	А. Ном, гарын авлагын шинжилгээ	- Авлигатай тэмцэх үйл ажиллагаа болон залуучууд идэвхтэй оролцоо хоорондын уялдаа холбоог сайжруулах үзэл баримтлалын тогтолцоог бий болгосон. - Залуучуудын идэвхтэй оролцоог хангах гол чиглэлүүдийг тодорхойлсон. - Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын цаашдын үйл ажиллагааны чиглэлийг бий болгосон.
	Б. Оролцогч талуудын дүн шинжилгээ буюу зураглал / жижиг судалгаа/	- Судалгаанд оролцох үндсэн болон хоёрдогч оролцогч талуудыг тодорхойлсон. - Судалгааны үйл ажиллагааг чанартай зохион байгуулах байгууллагуудын эхний жагсаалт болон мөн авлигын эсрэг санаачилга дахь залуучуудын оролцооны жишээнүүдийг гаргасан.
Үе шат 2: Чанарын мэдээлэл цуглуулах Цаг хугацаа: 2022.10-12 сар	А. Залуучуудын фокус бүлгийн ярилцлага	Залуучуудаас авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд тэдний идэвхтэй оролцоог дэмжих талаарх ойлголт, боломж, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх зөвлөмжтэй холбоотой мэдээллүүдийг цуглуулсан.
	Б. Шинжээчдийн үндсэн мэдээлэл цуглуулах ярилцлага	Шинжээчдээс авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд залуучуудын идэвхтэй оролцоог дэмжих талаарх ойлголт, боломж, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх зөвлөмжтэй холбоотой мэдээллүүдийг цуглуулсан.
	В. Залуучуудын зөвлөх хороотой зөвлөлдөх	Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны хүрээнд гаргасан зөвлөмжүүд болон залуучуудын идэвхтэй оролцооны талаарх сэдвүүдэд үндэслэн судалгааны эхний үр дүнг гаргасан.
Үе шат 3: Тоон мэдээлэл цуглуулах Цаг хугацаа: 2023.01-02 сар	А. Авлигатай тэмцэх байгууллагуудад хийсэн судалгаа	- Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа ба авлигын эсрэг үйл ажиллагаа дахь залуучуудын оролцоог хангах чиглэлээр хэрэгжүүлсэн туршлагын талаарх мэдээллийг цуглуулсан. - Авлигатай тэмцэх газраас залуучуудын оролцоог хангах чиглэлээр хэрэгжүүлж байсан үйл ажиллагааны талаарх цар хүрээг тодорхойлсон. - Авлигатай тэмцэх байгууллагуудаас залуучуудын оролцоог хангах хүсэл эрмэлзэл болон хэрэгцээ, шаардлага, дэмжлэгийг тодорхойлсон.



ҮЕ ШАТ 1: БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭ

А. Ном, гарын авлагын шинжилгээ

Ном, гарын авлагын шинжилгээнд байгууллагын тайлан, залуучуудын мэдэгдэл, хэвлэлийн мэдээ, сүүдрийн тайлан, хурлын илтгэлүүд, НҮБ-ын гол баримт бичгүүд гэх мэт эрдэм шинжилгээний баримт бичгүүд болон эрдэм шинжилгээний бус ном гарын авлагуудыг хамарсан. Энэ шатанд авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаа, залуучуудын идэвхтэй оролцоо хоорондын уялдаа холбоотой үзэл баримтлалыг тодорхойлж, авлигын эсрэг үйл ажиллагаа дахь залуучуудын оролцооны талаарх ойлголт, судалгаа хийхэд зориулсан задлан шинжилгээний суурь сэдвүүдийг тодорхойлсон.

Б. Оролцогч талуудын дүн шинжилгээ буюу зураглал

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх, эсхүл дэмжлэг үзүүлэх үндэсний, бүс нутгийн болон дэлхийн хэмжээний нөлөөлөгч оролцогчдыг тодорхойлж, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудын тайлан, хэвлэмэл материалууд, хэвлэлийн мэдээ, мэдэгдэл зэрэг баримт бичигт үндэслэн оролцогч талуудын дүн шинжилгээ буюу зураглалыг хийсэн.

Эдгээр баримт бичгүүдийг хянан үзэх явцад тодруулах шаардлагатай асуудлын талаар болон нэмэлт мэдээлэл цуглуулах зорилгоор дүн шинжилгээ хийх явцад гарч ирсэн оролцогч талуудын хүрээнд болон тэдний цахим сүлжээгээр дамжуулан жижиг судалгааг хийсэн. Судалгааны дүнд 64 оролцогчдоос хариу ирүүлсэн бөгөөд эдгээр хариултуудаас авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудыг татан оролцуулах талаар хэрэгжүүлэх эхний алхмуудыг тодорхойлсон.



ҮЕ ШАТ 2: ЧАНАРЫН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

Чанарын мэдээллийг цуглуулахдаа дараах гурван үндсэн аргыг ашигласан: Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд залуучуудын оролцоог дэмжих чиглэлээр ажилладаг шинжээчдийн зарим төлөөлөлтэй анхны мэдээлэл цуглуулах ярилцлага хийх; авлигатай тэмцэх үйл ажиллагаанд оролцож байгаа, эсхүл энэхүү арга хэмжээг чиглүүлж буй залуучуудын төлөөлөлтэй бүлгийн хэлэлцүүлэх хийх; Залуучуудын зөвлөх хорооны гишүүдтэй зөвлөлдөх.

Судалгааны мэдээллийг фокус бүлгийн 6 хэлэлцүүлэг, анхны мэдээлэл өгөх 7 оролцогчтой ярилцлага хийх замаар цуглуулсан бөгөөд эдгээр ярилцлага, хэлэлцүүлэг нь тус бүр 60 минутаас хамгийн ихдээ 90 минут хүртэлх хугацаанд үргэлжилсэн. Аудио болон видео бичлэг, гар тэмдэглэл болон хуулбараар цуглуулсан мэдээллийн чанарыг нягтлан шалгасан.

Мэдээллийн шинжилгээнд мэдээллийн шинжилгээний программ хангамж бүхий компьютерын тусламжтайгаар индуктив сэдэвчилсэн арга хэрэгслийг ашиглаж хийсэн. Сэдэвчилсэн дүн шинжилгээ нь холимог арга барилд тохирсон өгөгдлүүдийг кодлох, ангилах, учирзүйг олох ба өгөгдлийг илүү олон хүмүүст хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгодог арга юм.

А. Залуучуудын фокус бүлгийн ярилцлага

Нэг бүлэгт 3-4 залуучуудыг онлайнаар уулзуулж, авлигын эсрэг үйл ажиллагаанд оролцогч талуудтай нэгдэн, хамтарч ажиллаж байсан туршлагыг хуваалцсан. Фокусын бүлгийн ярилцлага нь оролцогчдын дунд яриа өрнүүлэх боломжийг олгож, нэг нэгнийхээ авлигын эсрэг оролцооны талаарх ойлголт дээр тулгуурлан, судалгааны сэдвүүдийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх боломжийг олгосон. Түүнчлэн, залуу оролцогчдод санал бодлоо илэрхийлэхэд таагүй мэдрэмж төрүүлэхээр байвал бүлгийн динамик нь энэхүү нөхцөл байдлыг өөрчилж, ганцаарчилсан ярилцлагаас илүү бүлгийн хэлэлцүүлэх өрнүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын шууд туршлага нь судалгааны 1 дүгээр үе шатны үндсэн дүгнэлтийг гаргахад дэмжлэг болж, авлигатай тэмцэх үйл ажиллагаа дахь залуучуудын идэвхтэй оролцоог бий болгох талаарх сайн туршлагыг хэрэгжүүлэх сорилт, боломжуудын талаар илүү нарийн ойлголттой болсон.

Б. Шинжээчдийн үндсэн мэдээлэл цуглуулах ярилцлага

Энэхүү ярилцлагыг авлигатай тэмцэх салбар, тэр дундаа авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанаас залуучуудын оролцоог хангах чиглэлээр хэрэгжүүлж буй чиглэлийг нөхцөл байдалтай холбон судлах, оролцогчдын туршлагын талаар илүү нарийн ойлголттой болох зорилгоор авлигатай тэмцэж буй насанд хүрсэн шинжээчидтэй хийсэн.



В. Залуучуудын зөвлөх хороотой зөвлөлдөх

Залуу манлайлагчид нь Залуучуудын зөвлөх хорооны гишүүнээр ажиллаж, судалгааны аргазүйг боловсруулах, судалгаагаар олж авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, зөвлөмж боловсруулахад дэмжлэг үзүүлж, “залуучуудын дуран” болж байв. Залуучуудын зөвлөх хороо нь үе тэнгийн залуучуудыг судалгааны зөвлөмж боловсруулах, залуучуудын фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцуулах болон судалгааны мэдээлэл цуглуулах арга хэрэгслийн талаар санал өгөхөд урьж оролцуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд баримт бичгийн шинжилгээ болон чанарын мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийхэд дэмжлэг авах зорилгоор Залуучуудын зөвлөх хороотой зөвлөлдсөн. Үүнд судалгааны үнэн зөв, бодитой байдлыг бэхжүүлэхэд гарч буй бэрхшээл, мэдлэг, мэдээллийн дутагдалтай байдлыг хэрхэн шийдвэрлэх боломжуудыг тодорхойлох зэрэг багтсан.

ҮЕ ШАТ 3: ТООН МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ

2023 оны 1, 2 дугаар саруудад Авлигатай тэмцэх байгууллагуудын нэгдсэн холбоогоор дамжуулан авлигатай тэмцэх байгууллагуудын онлайн судалгааг явуулсан. Судалгаанд авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий 403 байгууллагууд 39 асуулт бүхий судалгааны асуулгыг бөглөж, хамрагдсан. Нийт 73 хүчин төгөлдөр хариултыг хүлээн авч, дүн шинжилгээнд ашигласан.

Судалгааны үр дүнд авлигын эсрэг хүчин чармайлтад залуучуудын идэвхтэй оролцоог дэмжиж талаар үзэл баримтлалыг аль хэдийн хэрэгжүүлсэн авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудыг тодорхойлсон нь авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын оролцооны туршлагаас хамааран авлигын эсрэг тэмцэлд залуучуудын оролцооны талаарх ойлголтыг өгсөн (эсхүл өгөөгүй), мөн залуучуудын оролцоог сайжруулах сайн туршлагыг бэхжүүлэхэд авлигатай тэмцэх байгууллагуудад дэмжлэг үзүүлэх боломжит хувилбар, арга барилыг тодорхойлсон. Мөн авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын идэвхтэй оролцооны талаарх нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал болон түүнийг шийдвэрлэх боломжуудыг бий болгохтой холбоотой мэдээллүүдийг ил болгосон.

Хавсралт II: Залуучуудын идэвхтэй оролцоо– Байгууллагын идэвхжүүлэгчид

Байгууллагын идэвхжүүлэгчийн талаарх тодорхой мэдээллийг энэхүү хавсралтын 3А бүлэгт дэлгэрэнгүй тодорхойлсон. Авлигатай тэмцэх байгууллагуудын байгууллагын бэлэн байдлын үнэлгээний тодорхой удирдамжийг [энэхүү бодлогын гарын авлагын вэб порталаас авах боломжтой](#).

Залуучуудын үр дүнтэй оролцооны үндсэн санаа 1: Олон талт байдал ба тэгш оролцоо

1. Оролцогч талуудын шинжилгээ

Оролцогч талуудын ашиг сонирхлыг ойлгох нь залуучууд, иргэд болон бусад гол оролцогч талуудыг хамарсан үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг болдог. Энэ нь залуучуудад төвлөрсөн байгууллагуудыг тодорхойлж, (нийгмийн эмзэг бүлгийн залуучуудын бүлэг, хувь хүмүүсийн төлөөллүүд байх), тэдний үзэл бодлыг ойлгох боломж олгож, тэдний оролцоонд саад учруулж болох аливаа бэрхшээлүүдийг онцолж өгдөг. Энэхүү дүн шинжилгээг нийгмийн эмзэг бүлгүүдийн залуучуудын төлөөллүүдийг бий болгох болон залуучуудын институцийн “итгэл хүлээхүйц” сүлжээг байгуулахад ашиглах боломжтой.

Залуучуудын оролцооны хэрэгцээ шаардлагыг тэдний нэгдсэн зорилго, онцлогт тохируулан шинжлэн судлах нь үнэ цэнтэй байдаг. Үүнд эдгээр ангиллыг багтаана, насаар нь (жишээ нь 15-18, 19-22, 23-25, 26-30), учир нь залуучууд хүүхдээс насанд хүрэгчид рүү шилжих явцад тэдний сонирхол, зан чанар хурдан өөрчлөгддөг; хүйсээр нь, учир нь залуу эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн зан үйл, хандлага, хэм хэмжээ өөр, өөрөөр нөлөөлдөг; хөгжлийн бэрхшээлтэй эсэх байдлаар нь, учир нь танин мэдэхүйн болон бие махбодын ялгаатай хөгжлийн бэрхшээлүүд нь авлигын эсрэг санаачилга, оролцоог нэмэгдүүлэх, боломжийг бүрдүүлдэг. Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын чадавхаас хамаарч үндэс угсаа, шашин шүтлэг, газарзүйн байршил (хот/хөдөө), нийгэм-эдийн засгийн анги, боловсролын амжилт, ажил эрхлэлтийн байдал зэрэг бусад шинж чанаруудыг хамааруулан авч үзэж болно.

Залуучуудын талаарх мэдээлэл, тэр дундаа залуучуудын байгууллага, сүлжээний талаарх мэдээллүүд нь авлигатай тэмцэх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцад залуучуудын оролцооны талаарх стратеги, арга барилын талаарх ойлголтыг өгч чадна. Хүн амзүйн өсөлт, ашиг сонирхол, залуучуудын харилцаа,



харилцааны үр дүнг сайжруулах үр дүнтэй арга замууд, авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлийн залуучуудын байгууллага болон залуу манлайлагчдын сүлжээний талаарх мэдээллүүд нь үнэ цэнтэй юм. Авлигын эсрэг үйл ажиллагаанд аль хэдийн идэвхтэй оролцож байгаа залуучуудын авлигын эсрэг юу хийж байгааг ойлгохын тулд авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, мэдээлэл нь тэдний ажилд чухал ач холбогдолтой болохыг тодорхойлоход оршино.

2. Оролцооны төлөвлөгөө

Судалгаанд оролцогч талуудын дүн шинжилгээнд тулгуурласан оролцооны төлөвлөгөө нь авлигатай тэмцэх байгууллагуудын төслийг хэрэгжүүлэх хугацаанд идэвхтэй динамик хэвээр байна. Залуучуудын оролцоонд тулгуурлан маш сайн боловсруулсан төлөвлөгөө нь авлигатай тэмцэх байгууллагын үйл ажиллагаанд залуучуудыг хэрхэн, хэзээ, ямар үйл ажиллагаанд хамруулах талаар системтэй шийдвэр гаргахад чиглүүлнэ.

Залуучуудын үр дүнтэй оролцооны үндсэн санаа 2: Оролцоог хангах таатай орчин

3. Залуучуудын оролцоонд зориулсан тусгай санхүүжилт (байгууллагын гол идэвхжүүлэгч)

Санхүүжилтийн хүртээмжтэй байдал, тэр дундаа техникийн мэдлэг, чадвар нь авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын ажилтнуудад залуучуудын оролцоог дэмжих зорилгод нийлүүлэн ажиллах боломжийг бүрдүүлдэг. Тухайн байгууллагад хангалттай дотоод нөөц байхгүй бол авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын оролцоог хангах боломж хязгаарлагдмал болно. Үүний зэрэгцээ, байгууллагын дотоод нөөцийн хязгаарлагдмал байдлыг даван туулахын тулд гадны (авлигатай тэмцэх бус байгууллага) санхүүжилт, түүний эх үүсвэр нь бэлэн байгаа тохиолдолд өөрийн байгууллагаас ангид авлигын эсрэг үйл ажиллагаа явуулдаг залуу мэргэжилтнүүд, иргэний нийгмийн байгууллага, залуучуудын байгууллага, НҮБ болон эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах боломж бүрдэх, эсхүл хэрэгцээ шаардлага тулгарна. Авлигатай тэмцэх газрын тогтмол төсвийг хуваарилах захиргааны үйл явц, шаардлагууд болон залуучуудын оролцоог санхүүжүүлэх дотоод нягтлан бодох бүртгэлийн систем, үйл явцад анхаарал хандуулах, эсхүл онцгой анхаарах шаардлагатай байж болно. Авлигатай тэмцэх газрын санхүүгийн нэгжүүд нь залуучуудын оролцооны санхүүжилтийг цаг тухайд нь авах, тэр дундаа банканд дансгүй залуучуудын төлбөрийг авах боломжийг бүрдүүлэх шаардлагатай. (жишээ нь: тэтгэлэг, зардал, орчуулагчдад зориулсан мөнгө, насанд хүрээгүй хүүхдийг дагалдан явах хүнийг хамгаалах сан, аяллын зардал гэх мэт). Санхүүжилт хангалтгүй байгаа нь залуучуудын оролцооны орон зайг өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадах боломжтой залуучууд “элитийн олз” эзэлж, боломж тааруу залуучуудыг гадуурхагдахад хүргэдэг.



Залуучуудын оролцоог хангах аливаа үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө хангалттай санхүүжилттэй байх, захиргааны зардлын үр дүнтэй уян хатан механизм бий эсэхийг баталгаажуулах нь байгууллагын урьдчилсан (гол) хүчин зүйл гэж тооцогддог.

4. Залуучуудын оролцооны албан ёсны гэрээ байгуулах механизм

Залуучуудын оролцооны албан ёсны зохион байгуулалтын стратеги нь залуучуудын оролцооны зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зорилт, хамрах хүрээ, нөөцийн хуваарилалтыг тодорхойлдог. Ийм баримт бичиг байгаа нь залуучуудын идэвхтэй оролцоог дэмжих урьдчилсан нөхцөл биш юм. Гэсэн хэдий ч залуучууд, залуучуудын байгууллага болон авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын ажлын арга барилд нийцэхгүй, эрсдэлийг ойлгосноор таатай орчныг бүрдүүлэх чухал хүчин зүйл болно. Залуучуудын оролцооны албан ёсны гэрээ байгуулах механизмын талаар мэдлэгтэй залуучууд, мэргэжилтнүүд (залуучуудын байгууллага, ТББ, зөвлөх фирмүүд гэх мэт) болон хувь хүнийх нь хувьд залуучуудтай (зөвлөх, дадлагажигч, цалинтай ажилтан, сайн дурын ажилтан гэх мэт) эрт яриа хэлэлцээ хийх нь залуучуудын оролцооны үйл явцыг байгууллагын болон/эсхүл хөтөлбөрийн түвшинд тодорхойлж, залуучуудыг дайчлан оролцуулах явцад гарч болзошгүй саад бэрхшээлийг бууруулахад туслах болно.

Авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудыг татан оролцуулж эхлээд удаагүй байгаа, эсхүл хараахан эхлээгүй байгаа Авлигатай тэмцэх байгууллагуудын хувьд ийм стратеги байхгүй гэдгийг ойлгож магадгүй. Тиймээс, Залуучуудын оролцоог идэвхжүүлэх анхны хүчин чармайлт бол авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын авлигатай тэмцэх ажилд хэрхэн хувь нэмрээ оруулсан, хэрхэн сайжруулах талаар нарийвчлан судлан үнэлж, туршлага судлах үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах шаардлагатай төдийгүй залуучуудын идэвхтэй оролцооны үндсэн зарчмуудыг дагаж мөрдөхөөр зохион байгуулагдсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга техникийг ЗВ бүлэгт авч үзнэ.

Төрийн байгууллагуудын гэрээ байгуулах төвөгтэй, хүндрэлтэй тогтолцоо нь залуучуудыг авлигын эсрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулахад саад болж байна. Тухайлбал, Зарим байгууллагууд зөвлөх үйлчилгээний ажлын тодорхойлолтод өндөр шалгууруудыг зааснаар залуучуудыг зөвлөхөөр авахад хэцүү байдаг. Залуучуудыг анх ажилд ороход тулгардаг бэрхшээл нь мэргэшлийн шаардлага болон ажлын туршлагаар тэнцэхгүй байх магадлал их (жишээ нь: зөвлөх үйлчилгээний туршлага гурван жил, эсхүл ижил төстэй таван ажил гүйцэтгэсэн туршлага). Нэр дэвшигчдийн үнэлгээний илүү уян хатан шалгуур нь залуучуудын зан чанар, тэргүүлэх чиглэл, оролцоог хүлээн зөвшөөрч, сайн дурын болон уламжлалт бус хичээлээс гадуурх нийгмийн үйл ажиллагааны үнэ цэнийг харгалзан үзэх ёстой.

Залуучуудын идэвхтэй оролцоонд тулгамдаж буй бусад хүчин зүйлс: залуучуудын



бүлгүүд албан ёсоор бүртгүүлдэггүй учраас авлигатай тэмцэх газартай гэрээ байгуулж, дэмжлэг авч чадахгүй байх; мөн авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд залуучуудын оролцоог дэмжих талаар мэдлэгтэй, туршлагатай техникийн мэргэжилтнүүдийн жагсаалт байдаггүй.

Тиймээс одоо барьж буй бодлого, дагаж мөрдөж буй дүрэм, журамд нийцүүлэн авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын оролцоог хэрхэн хангаж ажиллах, үр дүнд хүрэх, түүнчлэн ямар өөрчлөлт хийх шаардлагатай байгааг шийдэх нь чухал байна.

Практик талаас нь авч үзвэл авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагаадаа залуучуудыг татан оролцуулах чиглэлээр эхний алхмуудыг нэвтрүүлсэн олон арга замуудыг судалгаагаар илрүүлсэн. Хамгийн түгээмэл алхмууд нь сайн дурын ажил, дадлага хийх чиглэлүүд байв.



Авлигатай тэмцэх байгууллагууд нь залуучуудын оролцоог дэмжих чиглэлээр гэрээ хэлэлцээр хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тэдний хүсэл эрмэлзэл, нөөц бололцоо, үйл ажиллагааны болон захиргааны шаардлагад хамгийн сайн нийцсэн залуучуудыг сонгож, нууцлал болон хамгаалалтын хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай. Гэрээний зохицуулалтаас илүү залуучуудын авлигын эсрэг үйл ажиллагаа дахь хүлээж буй үүрэг чухал байна.



5. Залуучуудын идэвхтэй оролцоог хангах талаарх албан хаагчдын мэдлэг

Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудад өөрийн ажилтнууд болон залуучуудын хамтын ажиллагааг бүтээлчээр үр дүнтэй зохион байгуулах зорилгоор залуучууд руу чиглэсэн тодорхой мэдлэг, ур чадвар, хандлага байх шаардлагатай. Залуучуудтай шууд харилцдаг албан хаагчийн хувьд тэдний үүрэг, хариуцлага болон аюулгүй байдлыг хамгаалах чиглэлийг тодорхойлж, мэдлэг, чадвар дутмаг үед нэмэлт мэдээлэл өгөх зэргээр дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагыг ойлгож, хандах нь зүйтэй. Настай холбоотой өрөөсгөл ойлголтыг (жишээ нь, “залуус авлигатай тэмцэх мэргэжилтэн биш учраас тусалж чадахгүй” гэх мэт) өөрчилж, хандлагыг эерэг болгох боломжтой. Тиймээс авлигатай тэмцэх байгууллагууд залуучуудын оролцоог хангах ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ажилтнуудын сургах, залуучуудын оролцооны талаар заавар, зөвлөгөөг нэмэгдүүлэх, дотоод зохион байгуулалтын чадавхыг бий болгох шаардлагатай байна.

6. Залуучуудын хамгаалал (байгууллагын гол идэвхжүүлэгч)

Авлигатай тэмцэх байгууллагууд үйл ажиллагаандаа залуучуудыг татан оролцуулж эхлэхээс өмнө тэдний аюулгүй байдлыг хамгаалах тогтолцоог (аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн) бүрдүүлэх ёстой. Залуучуудын аюулгүй байдал, хамгаалалтын тогтолцоо нь хамтран ажиллахад аюулгүй гэх итгэл үнэмшил төрүүлэхүйц байх ёстой. Авлигатай тэмцэх байгууллагууд нь хамгааллын бодлого, үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэхийн тулд дараах чиглэлээр тодорхой алхмуудыг хийнэ:

- Ёс зүйн хэм хэмжээ болон аливаа эрдлээс урьдчилан сэргийлэх зарчмуудыг тодорхойлж, тэдний хүсэл эрмэлзэл нь хамгийн чухал гэдэг итгэх үнэмшлийг бий болгох
- Авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучууд цахимаар оролцох байдал нэмэгдэж байгаа тул цахим хамгааллын үйл ажиллагаа чухал гэдгийг анхаарах
- Аюулгүй байдал, хамгаалалтыг зөрчсөн, эсхүл сэжигтэй тохиолдол гарвал хэрхэн ажиллах талаар зааварчилгааг ажилтнуудад өгөх
- Хамгаалалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх

Залуучуудын оролцоог хангах аливаа үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө тэднийг энэ чиглэлээр хамтран ажиллахад хамгаалалтын найдвартай тогтолцоотой байх нь (гол) байгууллагын идэвхжүүлэгч гэж үздэг.



Залуучуудын үр дүнтэй оролцооны үндсэн санаа 3: Үе хоорондын хамтын ажиллагаа (түншлэл)

7. Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын идэвхтэй оролцоог дэмжих төлөвлөгөө

Залуучуудын идэвхтэй оролцооны үр дүн нь авлигатай тэмцэх байгууллагуудын ажилтнууд болон авлигын эсрэг санаачилга гаргаж буй залуучуудад адилхан үр өгөөжөө өгөх ёстой. Үүнийг хэрэгжүүлэх нэг арга зам бол авлигын эсрэг үйл ажиллагаа болон төслийг хэрэгжүүлэхэд хамтын үнэ цэнийг бий болгох явдал юм. Ихэнхдээ, авлигатай тэмцэх байгууллагуудын албан хаагч болон залуучуудын хамтын ажиллагааны асуудал яригддаг боловч залуучууд шийдвэр гаргах түвшинд хувь нэмрээ оруулах бололцоо хязгаарлагдмал байдаг. Авлигатай тэмцэх газар нь залуучуудын нөхөрлөл, хамтын ажиллагаа, тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ авлигын эсрэг санал санаачилгыг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай. Авлигын эсрэг үе үеийн хамтын ажиллагаа, түншлэлийг албан ёсны гэрээ, хэлэлцээр боловсруулах замаар баримтжуулсан байх ёстой. Эдгээр гэрээ, хэлэлцээр нь залуучуудын оролцоог дэмжих, санхүүжилтийг шилжүүлэхэд албан ёсны байна.



Залуучуудын үр дүнтэй оролцооны үндсэн санаа 4: Залуучуудын оролцооны чанар

8. Залуучуудын хөдөлгөөн

Авлигатай тэмцэх байгууллагууд нь авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын идэвхтэй оролцоог дэмжихийн тулд тэдэнд “ширээний ард суудал” өгч, залуучуудын оролцоог үр дүнтэй зохион байгуулах талаар тэдний санал санаачилга, зөвлөмжийг авах хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд авлигын эсрэг үйл ажиллагаанд сайн дурын залуучуудын хөдөлгөөнийг дэмжих, дадлагажих хүсэлтэй залуучуудыг элсүүлэх, залуучуудын хамтын ажиллагааг сайжруулахаар залуу удирдагчидтай хамтран ажиллах замаар хүрч болно. Энэ нь авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын оролцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид бэлэн байх боломжийг бүрдүүлдэг.

Залуучууд төслийг хэрэгжүүлэх үе шат, үйл явцын бүхий л хугацаанд боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ болон үнэлгээнд тодорхой үүрэг гүйцэтгэх ёстой. Залуучуудын идэвхтэй оролцоо нь авлигатай тэмцэх үйл ажиллагаанд тэднийг хөндлөнгийн оролцогчийн байр сууринд байлгахад илүү боломжийг тэдэнд бий болгоход оршино. Залуучуудын оролцоог үр дүнтэй хэрэгжүүлэхэд авлигатай тэмцэх байгууллагууд нь өөрийн зорилгод хүрэхэд дэмжлэг болох залуучуудын мэдлэг боловсрол, ур чадварыг харгалзан хэрхэн хувь нэмрээ оруулж болох талаар ойлголттой байх ёстой.

9. Залуучуудын оролцооны бүтэц (Байгууллагын гол идэвхжүүлэгч)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Бидний нийтлэг дагаж мөрдөх бодлогын баримт бичгийн товч танилцуулга 3: Бодлого боловсруулах болон шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог хангах нь нийтлэлд дурдсанчлан шийдвэр гаргах үйл явцыг илүү үр дүнтэй болгож, төрийн байгууллагуудад итгэх итгэлийг нэмэгдүүлэх сайн туршлагыг баримталснаар авлигатай тэмцэх байгууллагууд нь залуучуудын идэвхтэй оролцооны зарчмуудыг баримтлан үйл ажиллагааныхаа шийдвэр гаргах бүх түвшинд залуучуудын оролцоог дэмжсэнээр үр дүнд хүрнэ. Энэ нь залуучуудын оролцоог тухай бүрт дэмжихэд шаардлагатай хөрөнгө, нөөц бололцоогоор хангах байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандарт журмыг шаарддаг.



Залуучуудын оролцоог хангах эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд захиргааны байгууллагын бүтэц, арга барилга харилцан адилгүй тул богино болон урт хугацааны дадлага хийх, залуучуудын сайн дурын ажил, залуучуудын үйл ажиллагааг дэмжих хувь хүн, эсхүл бүлэг, холбоо, зөвлөл, хамтын болон түншлэлийн байгууллага, залуучуудын “хотын танхим”, залуучуудын нас насны бүлэг хоорондын онлайн сүлжээ, орон нутгийн залуучуудын сүлжээ болон залуучуудад чиглэсэн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана. Авлигатай тэмцэх байгууллагаас идэвхтэй залуу мэргэжилтнүүдийн ажил эрхлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр залуучуудыг өргөнөөр хамруулах хүчин чармайлтад чухал нөлөө үзүүлнэ.

Залуучуудын оролцоог хангах аливаа үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө шийдвэр гаргах бүх түвшинд залуучуудын оролцоог хангах, хамтран ажиллагсад болон /эсхүл түншийн хувьд эрт яриа хэлэлцээ/зөвлөлдөхөд залуучуудыг оролцуулах зайлшгүй шаардлага нь (гол) байгууллагын идэвхжүүлэгч гэж үздэг.

10. Залуучуудад ээлтэй бодлого ба чадавхыг дэмжих

Авлигатай тэмцэх байгууллагууд нь залуучуудын оролцоог идэвхжүүлэх, тэдэнтэй үр дүнтэй хамтран ажиллахын тул авлигатай тэмцэх техникийн нөөц бололцоо сайтай байх ёстой. Авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучууд болон насанд хүрэгчдийн оролцоо, хүчин чармайлтыг дэмжихэд байгууллагын чиг үүрэг, бодлого, чиглэл, үйл ажиллагаатай холбоотой гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтууд, техник хэрэгсэл болон үүнд тохирох арга барил, хэлбэрээр хамтран ажиллах үйл явц, зөвлөн туслах чиглэлүүдийг багтдаг. Залуучуудын бүлэг, холбоод болон ялангуяа нийгмийн тусгаарлагдсан бүлгүүдэд чиглэсэн таниулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, чадавхыг бэхжүүлснээр авлигатай тэмцэх байгууллагуудын авлигын эсрэг санаачилгын хүрээг өргөжүүлэх, залуучуудын оролцоог үр дүнтэй хангах баталгаатай платформ бий болно.



Залуучуудын үр дүнтэй оролцооны үндсэн санаа 5: Залуучуудыг чадавхжуулах

11. Залуучуудын чадавхыг бэхжүүлэх

Залуучуудын хувь хүний хөгжлийг удирдан чиглүүлэх, нийгэм дэх өөрчлөлтийг хянах, нөлөөлөх чадвар, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхэд нь туслах, суралцах болон манлайлах боломжуудыг нээх нь авлигын эсрэг тэдний оролцоог татах хүчирхэг хэрэгсэл болж чадна. Энэ нь голчлон залуу нийгэмлэгүүдэд (жишээлбэл, хөгжиж буй орнууд болон жижиг орнуудад) бодитой байдаг. Авлигатай тэмцэх байгууллагын чиг үүргийн талаарх залуучуудын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, санал санаачилгыг дэмжих хэрэгцээ шаардлага, манлайлал, мэдлэг, ур чадварын талаар сургалт явуулж залуучуудыг хамтран ажиллахад бэлтгэх шаардлагатай болно. Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд залуучуудыг чадавхжуулах ажлын нэг хэсэг нь үе үеийн хамтын ажиллагааны талаарх туршлагыг хуваалцах сургалтыг зохион байгуулах нь үр дүнтэй. Авлигатай тэмцэх байгууллагуудын залуучуудтай хамтран хэрэгжүүлж буй ажил, нөгөө талаас залуучуудын авлигын эсрэг тэмцэлд гаргаж буй ололт амжилтыг үнэлэх нь хамтын ажиллагааны үр дүнд чухал юм. Авлигатай тэмцэх байгууллага, тэр дундаа удирдах ажилтнуудаас үзүүлж буй дэмжлэг нь авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудын оролцоог сайжруулах гол хүчин зүйл юм.

12. Залуучуудыг (урвуу) чиглүүлэх хөтөлбөрүүд

Залуучуудыг авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчидтай холбож, авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар суралцаж, чадавхжих боломжийг олгосноор залуучуудын авлигыг эсрэг тэмцэх итгэл үнэмшил, урам зоригийг нэмдэг. Чиглүүлэг нь сэтгэлгээний шинэ арга барилыг нэвтрүүлж, өрөөсгөл буруу ойлголтыг засах замаар залуучуудыг хувийн болон ажил мэргэжлийн зорилгодоо хүрэхэд тусалдаг. Энэ хөтөлбөр нь залуучуудад амьдралын чухал сургамжуудыг олж суралцах, түүнийгээ хуваалцахад тусалдаг бөгөөд ажил мэргэжлийн хөгжлийн түвшинг сайжруулах үнэ цэнийг бий болгоно. Нөгөө талаас, залуучуудаас авлигатай тэмцэх газрын албан хаагчдад өгч буй чиглэлүүд нь насанд хүрэгчдээс залуучуудыг ойлгож, хамтарч ажиллах чадавхыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой. Залуучуудын оролцоог сайжруулах эдгээр олон чухал зарчмууд нь залуучууд болон насанд хүрэгчдэд эерэгээр харилцааг бий болгоход ашиглаж болно.



13. Залуучуудын оролцоог хангахад насанд хүрсэн оролцогч талуудын туршлага

Залуучуудтай хамтран ажиллах нь тэдний хувь хүний хөгжлийг ойлгох, дэмжих, чиглүүлэхэд багагүй ур чадвар шаарддаг. Энэ нь залуучуудыг өөрийгөө хөгжүүлэх, боломжоо ашиглахад нь дэмжлэг болно. Мөн залуучуудад өөрсдийн итгэл үнэмшил, үнэт зүйл, үзэл санааг олж илрүүлэх, ойлгоход нь тусалж, насанд хүрсэн үедээ амьдрах чадвар, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлж, төлөвшүүлэхэд нь туслах өгөөжтэй. Зарим тохиолдолд насанд хүрэгчид залуучуудын хэрэгцээ шаардлага, хүсэл тэмүүлэл болон чадварын талаар урьдчилан төсөөлдөг. Авлигатай тэмцэх байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучууд хэрхэн хувь нэмрээ оруулах боломжтой талаарх ойлголт чухал юм.²⁷ Насанд хүрэгчид нь залуучуудтай хамтран ажиллаж, үр дүнд хүрсэн талаарх сайн туршлага болон мэдээллээр өөрийгөө бүрэн хангасан тохиолдолд авлигатай тэмцэх байгууллагуудын зорилгыг залуучуудын идэвхтэй оролцоотойгоор үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Тиймээс насанд хүрсэн оролцогч талуудаас залуучуудын идэвхтэй оролцоонд дэмжлэг болохуйц нөөц бололцоо болон тэднийг татан оролцуулах ур чадварыг бий болгох шаардлагатай.

Залуучууд болон насанд хүрэгчдийн үе шаттай хамтын ажиллагааг чиглүүлэх зааварчилгаа, сургалтын хэрэглэгдэхүүнүүд бэлэн байна.²⁸ Залуучууд болон насанд хүрэгчдийн хамтын ажиллагаа, түүнийг сайжруулах чиглэлээр практик туршлагатай иргэний нийгмийн байгууллагууд болон залуучуудын бүлгээс дэмжлэг үзүүлэх боломжтой. Залуучуудтай хамтран ажиллахын тулд эерэг хандлагатай байх нь чухал. Насанд хүрэгчдийн хувьд залуучуудын итгэлийг нэг бүрчлэн олж авах нь чухал бөгөөд тэд хамтын ажиллагааны талаар бүх зүйлс тодорхой, тууштай байхыг шаарддаг тул буруутай, алдаатай зүйлсийг хурцаар олж хардаг тул тэдний итгэлийн алдахад хүргэдэг. Залуучуудаас насанд хүрэгчдэд зөвлөгөө өгөх хөтөлбөр зэрэг эдгээр сургалтын тусгай хэлбэрүүд нь тэдний үр дүнтэй хамтран ажиллах чадавхыг бэхжүүлэх, итгэлцлийг бий болгоход тусалдаг. Насанд хүрэгчдийн ур чадвар, хандлагыг сайжруулах зорилгоор зарим хөрөнгө оруулалтыг хийдэг ба үүнд авлигатай тэмцэх байгууллагууд болон насанд хүрэгч төвтэй ихэнх байгууллагууд идэвх санаачилгатай оролцох шаардлагатай.

²⁷ UNICEF, "What do adults misunderstand about young people", 2022 оны 8 дугаар сарын 12.

²⁸ Youth Power 2, Youth Center Toolkit: Creating Resources for Safe Spaces, Youth Centers, and After-school Programs (Washington, 2020).

АВЛИГЫН ЭСРЭГ *Нэгдье* Шударга ёс, хөгжил дэвшилд

Даян дэлхий аюулгүй
орших нь авлигаас эрс
татгалзаж, өөрчлөлтийг
манлайлж буй
залуучуудаас
шалтгаална.



Үгүй гэж хэлээд өөрчилъё! 

АВЛИГЫН ЭСРЭГ *Нэгдье* Шударга ёс, хөгжил дэвшилд

Залуучуудыг чадавхжуулах
нь тэдэнд ирээдүйд
шударгаар ажиллах
удирдагч болоход
шаардлагатай үнэт зүйл, ур
чадварыг бий болгодог.



Үгүй гэж хэлээд өөрчилъё! 

АВЛИГЫН ЭСРЭГ *Нэгдье*
Шударга ёс, хөгжил дэвшилд

Залуучууд авлигын
эсрэг шинэлэг
стратегийг нээн
илрүүлэхийн тулд
технологийг
ашиглаж байна.



Үгүй гэж хэлээд өөрчилье! 

АВЛИГЫН ЭСРЭГ *Нэгдье*
Шударга ёс, хөгжил дэвшилд

Залуучууд авлигатай
зоригтой тэмцэж, үйл
ажиллагаагаа бэлтгэн
төлөвлөж, өөрчлөлтийн
төлөөх нөлөө бүхий
дэмжигчийн хувиар хүчин
зүтгэж байна.



Үгүй гэж хэлээд өөрчилье! 

Орчуулсан:

Нэгдүгээр бүлгийг Д.Дуламсүрэн

Хоёрдугаар бүлгийг Ц.Булган

Гуравдугаар бүлгийг Д.Цэнд-Аюуш, Н.Бямбадорж

Дөрөвдүгээр бүлгийг Ц.Сэлэнгэ

Орчуулгын редактор: Д.Дуламсүрэн

С.Галбадрах

Цаасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 13хх

Хэвлэсэн тоо: 500

“Урангар пресс” ХХК-д хэвлэв.